

DDC
363.2
Б-342

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Хэвлэлийн хуудас ...

Цаасны хэмжээ: В.5

Хэвлэсэн газар:

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Г.Бямбадорж

ISBN 978-99962-8882-2-7

2014 № 2(10)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

- **Ж.Долгорсүрэн** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
- **Б.Пүрэв** Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор
- **Ж.Заанхүү** Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор
- **Б.Бат-Эрдэнэ** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
- **Д. Зүмбэрэлхам** Хууль зүйн ухааны доктор(Ph.D), профессор
- **Г.Гантөмөр** Хууль зүйн ухааны доктор,(Ph.D), профессор
- **З.Төрмандах** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Т.Оюунчимэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Сэтгүүлийн эрхлэгч: ХСИС-ийн тэргүүн дэд захирал **Б.Бат-Эрдэнэ**
Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
Эрхлэн гаргасан, нарийн бичгийн дарга: Докторант **Г.Бямбадорж**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

- **Т.Бямбаа** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Ж.Мөнхболд** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Т.Оюунчимэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **О.Цэцэгмаа** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Ц.Нямдорж** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Д.Энхжаргал** Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D), дэд профессор
- **Д.Мягмарцэрэн** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Ш.Ариунбилэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Б.Нармандах** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **М.Эрдэнэбаяр** докторант
- **Б.Баянмөнх** докторант
- **Б.Мөнхдорж** докторант

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл

(дугаар, 2014 №2)

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

З.ЦЭРЭНБАТ. ЦАГДААГИЙН АЛБА, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.ЧУЛУУН. ХАМГААЛАХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ.....

НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ

Б.БАЯНМӨНХ. ТЕРРОРИЗМЫН АЮУЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ.....

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ч.БАТЧИМЭГ, Б.ТӨМӨРХУЯГ. ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОХОД НӨЛӨӨЛӨХ СЭТГЭЛ ЗҮЙ, ХҮМҮҮЖЛИЙН ОНЦЛОГ.....

Т.МӨНХЧУЛУУН. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛ.....

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Г.БЯМБАДОРЖ. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ.....

Ж.ТӨГС-ОЧИР. МӨНГӨ УГААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮҮСЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....

С.СОЁМБО-ЭРДЭНЭ. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭР БЭЛТГЭСЭН БУЮУ ЗАВДСАН ҮЙЛДЭЛД ЯЛ ОНОГДУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ ГАДААД ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН УРЬДЧИЛСАН ҮЕ ШАТНЫ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.ОДХҮҮ. ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ТҮҮНИЙ ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГТ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ.....

Б.БАТ-УЧРАЛ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ТҮҮНИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ.....

УНШИГЧ ТАНЫ МЭДЛЭГИЙН САНД

ГЭРЧ ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ.....

ЦАХИМ ГАВНЫ ТУХАЙ



Төрсөн газар: 1965 онд Улаанбаатар хотод төрсөн.

Мэргэжил: Хуульч, эрх зүйч

Боловсрол: Дээд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), ОХУ-ын Дотоод явдлын Яамны Академи, АНУ Лос-Анжеласын Цагдаагийн Академид Цагдаагийн байгууллагын Удирдахуйн ухааны менежер, Монгол Улс Удирдлагын хөгжлийн Академид Удирдахуйн ухааны менежер.

Эрхэлж байсан ажил: 1989-1990 онд СБДЦХ-т төлөөлөгч, 1990-1994 онд Эрүүгийн Цагдаагийн Газрын дарга, 1994-1998 онд Эрүүгийн Цагдаагийн газарт чиглэлийн ахлах төлөөлөгч, 1998-1999 онд БГДЦХ-ийн дэд дарга, 1999-2001 онд Эрүүгийн Цагдаагийн Газрын дэд дарга, 2001-2011 онд хуучнаар Цагдаагийн Академийн Тэнхимийн эрхлэгч

Асуулт: Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

Хариулт: Баярлалаа. Танд ч бас энэ өдрийн мэндийг хүргэе!

Асуулт: Таны тухай, түүн дотроо эрхэлж байсан ажлын тань талаар цухас сонирхвол ямар вэ?

Хариулт: Би 29 жил Цагдаагийн байгууллагад тэр тусмаа Эрүүгийн цагдаагийн албанд илүү ажилласан. 2009 онд “Хүнийг санаатай алах гэмт хэрэгтэй тэмцэх” чиглэлээр МУИС-д хууль зүйн шинжлэх ухааны доктор цолыг хамгаалсан.

Асуулт: Та гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар ярьж байсан. Тэр сэдвээр тантай өнөөдөр ярилцъя гэж бодлоо?

Хариулт: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь манай улсад хэлбэрийн төдий л яригдаж, явагдаж байгаа, Тухайлбал: Хичнээн гэмт хэрэг үйлдэгдэхээс, ямар хохирол учрахаас урьдчилан сэргийлж байна вэ гэдэг нь ч тодорхой байх шаардлагатай бөгөөд урьдчилан сэргийлэх болон урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх асуудал дээр ч анхаарах цаг болсон.

Сүүлийн үед гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нь өсөн нэмэгдэж, нийгэм, улс оронд болон ард иргэдэд ихээхэн хэмжээний хор хохирлыг учруулах, айдсыг бий болгох явдал өсөх хандлагатай байгаа бөгөөд үүний эсрэг арга хэмжээнд ашиглаж болох хамгийн оновчтой олон аргуудын нэг нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийг байнгын хяналтанд байлгаж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нэгэнт үйлдэгдсэн тохиолдолд илрүүлэх, эрэн сурвалжлах зорилгоор ашиглах зориулалт бүхий **Цахим гав**-ыг хэрэглэх явдал юм. Өнөөдөр дэлхийг тойрон ажиллаж буй 27 ширхэг хиймэл дагуулаас 24 хиймэл дагуул нь идэвхитэй горимд ажиллаж GPS төхөөрөмжийг дэлхийн хаана байгааг хянаж байдаг. Цахим гав гэдэг нь GPS системд суурилсан хяналтанд авах шаардлагатай хүний гарт болон хөлд зүүх зориулалт бүхий бугуйвч хэлбэрийн төхөөрөмж бөгөөд хяналт тавих шаардлагатай хүмүүст зүүлгэснээр уг этгээдийг байнгын хяналтанд байлгах зориулалт бүхий төхөөрөмж гэж ойлгож болно. Цахим гав нь байршлыг тодорхойлох, аюулын буюу тусламж хүссэн дуудлага хийх, бодит байдалд хяналт тавих, явахыг хориглосон газрыг тэмдэглэх, зай дууссан, хэрэглэгч хөдөлгөөнгүй болсон үед нэмэлт дохиог төврүү илгээх ба Google map хэрэглэж болно. Мөн нууцлалын программтай, өнгө үзэмж сайтай, бусад хүмүүст ил харагдахгүй байх боломжтой, гэмт этгээд уг төхөөрөмжийг тайлах болон тайлахыг оролдох үед түгшүүрийн дохиог хяналтын болон цагдаагийн байгууллагад мэдээлэх зэрэг маш олон төрлийн үзүүлэлтүүдтэй төхөөрөмж юм.

Асуулт : Одоогийн байдлаар хууль хяналтын байгууллагаас явуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг та юу гэж бодож байна вэ?

Хариулт: Яах вэ одоо бол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил гэж яриад л байгаа бодитой үр дүнтэй ажил харагдахгүй байна. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад өөрт учирах эрсдлүүдийг урьдчилан тооцож, төлөвлөгөөтэй тодорхой арга хэмжээнүүдийг авах нь чухал байдаг. Өнөөдрийн байдлаар өдөрт дунджаар 5 хүний амь нас ямар нэг байдлаас хамаарч хохирч байна. Энэ нь жилээр тооцохоор их олон тоо гарч байгаа нь харамсалтай санагддаг. Монгол Улсын ҮАБ-ийн үзэл баримтлалаар хүний аюулгүй байдлыг хангах талаар нэн тэргүүнд тавьсан боловч энэ нь хэлбэрийн төдий л цаасан дээр тэмдэглэгдэж, урьдчилан сэргийлэх ажил бодитой үр дүнд хүрэхгүй өдийг хүрлээ. Мөн өнөөдөр байгалийн үзэгдэл, гамшигаас шалтгаалан олон тооны мал сүрэг үхэж, үрэгдэж өвчин тусч байгалийн гамшигт нэрвэгдэж байгаа нь хэзээ ч нөхөгдөшгүй юугаарч сольшгүй тийм харамсалтай зүйл гэдгийг бодитой ухаарч төр засаг, хууль хяналтын байгууллагаас хүн, мал, ан амьтаны амь нас хохирсны дараа бус өмнө нь урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж эхлэх цаг нь болсон гэж үзэж байна.

Асуулт : Урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг хэрхэн тооцох ёстой вэ?

ХР: Харин тийм. Урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцох хэмжүүр, үзүүлэлт, урамшуулалын тогтолцоо зайлшгүй үгүйлэгдэж байна. Жишээ нь: Хүнийг санаатай алах гэмт хэргийг илрүүлсэн ажилтанг урамшуулан, төрийн одон медалиар шагнадаг. Гэтэл хүнийг санаатай алахаас, амь насыг нь хохирхоос нь өмнө урьдчилан сэргийлбэл ямар үзүүлэлтээр шагнаж урамшуулах нь ойлгомжгүй мэт санагдаад байгаа юм.

Асуулт : Сүүлийн үед Цагдаагийн байгууллагууд дээр шинэчлэлт өөрчлөлтийн талаар их ярьж байна. Энэ талаар та юу гэж бодож байна?

Хариулт: Цагдаагийн байгууллагад сүүлийн жилүүдэд шинэчлэлт өөрчлөлттэй холбогдолтой бүтэц зохион байгуулалтын болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлийн олон өөрчлөлт хийгдэж байна. Гэхдээ 1990 оноос хойш цагдаагийн дүрэмт хувцасны өнгө, загвар, үзэмжийн тал дээр л хэтэрхий анхаарснаас биш яг гэмт хэрэгтэй тэмцэх арга тактик, шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх, гадаад орны туршлагаас судлах, боловсон хүчний сургалт бэлдэх ажил дээр анхаарч төдийлөн сайн шинэчлэлт, өөрчлөлт хийсэн гэж миний хувьд бодохгүй байна.

Харин сүүлийн жилд хийсэн ажлын нэг ололттой тал нь боловсон хүчинтэй холбоотой шинэчлэлт өөрчлөлт байсан юм болов уу!



Асуулт : 1990-д оноос хойш Монгол улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо ихэсч, гэмт хэргийн төрөл нэмэгдсэн төдийгүй үйлдлийн арга нарийсч, улам харгис хэрцгий болж байгаа нь хуулийн байгууллагуудын судалгаанаас харагдаж байгаа. Үүнээс үүдэн дээрхи төхөөрөмжийг манай улсад хэрэглэх нийтийн хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байгаа гэж ойлгож болох уу?

Хариулт: Судалгаанаас харахад МУ-ын хэмжээнд зөвхөн 2012 онд 19734 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 71 хүн захиргааны хяналтанд байхдаа, 161 хүн хэрэг бүртгэлт

мөрдөн байцаалтын шатанд батлан даалтанд байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн байна.

-Одоо хоригдож байгаа 6911 ялтаны 3414 нь давтан гэмт хэрэг үйлдэж дахин ял шийтгүүлсэн байх ба хэрэв эдгээр давтан гэмт хэрэг үйлдсэн 3414 хүн, дээр дурьдсан 161 хүнд цахим гавыг хэрэглэж хяналт тогтоосон бол 70%-80% нь, түүнээс ч илүүгээр гэмт хэрэгт холбогдохгүй байх, цаашлаад иргэд, байгууллагад тэр хэмжээгээр хохирол учрахгүй байх бололцоотой байжээ гэж үзэж болохоор байгаа.

-2012 онд 2794 ялтан ерөнхийлөгчийн зарлиг болон өршөөлөөр, хугацаа дуусч суллагдсан байх ба захиргааны хяналтанд нийт 2573 хүн, 382 хүүхэд хорих ял шийтгүүлж хойшлогдсон гэсэн шалтгаанаар Цагдаагийн байгууллагын хяналтанд байна.Эдгээр тоо баримтуудаас нэгтгэн дүгнэж нийт эрүүгийн гэмт хэрэгт холбогдогчдын болон давтан гэмт хэрэг үйлдэгчдийн тоо, захиргааны хяналтанд авагдах этгээдүүдийн тоог гаргасны үндсэн дээр цахим гавыг байнгын хэрэглэх субъектуудын тоог тодорхойлж болохоор байгааг харж болно.Одоо ч УИХ-аар Өршөөлийн хууль хэлэлцэгдэж байгааг та бүхэн мэднэ.

Өнөөдөр гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа, гэмт хэрэг үйлдээд суллагдсан, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд тавих хуулийн хяналт нь хэлбэрийн төдий байгаагаас дээрх этгээдүүдээс гэмт хэрэг дахин үйлдэх, нийгэмд түгшүүртэй аюултай байдлыг бий болгох, хүний амар тайван аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хязгаарлаж байна.

Асуулт :Тэгвэл цахим гавыг эн тэргүүнд хэрэглэх шаардлагатай ямар хүмүүс байна вэ?

Хариулт: 1-рт:Хорихоос суллагдсан этгээдүүдийг давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг.Захиргааны хяналтанд авагдах ёстой этгээд хэсгийн байцаагчид анх бүртгүүлснээс хойш сард нэгээс доошгүй удаа биеэр очиж бүртгүүлэх үүрэгтэй гэж Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан байдаг нь тэднийг бусад бүхий л хугацаанд хяналтгүйгээр, сул чөлөөтэй байх, цаашлаад гэмт хэрэг үйлдэх боломжийг олгож байна гэхэд хилсдэхгүй. Захиргааны хяналтыг үр дүнтэй авч хэрэгжүүлж, хяналтанд байх ёстой хүн нэг бүрт цахим гавыг хэрэглэж байнгын хяналтанд байлгах шаардлагатай.Ингэснээр хяналтанд бүрэн аваад зогсохгүй уг этгээдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх гэсэн санаа сэдлийг бууруулах ач холбогдолтой.

/2012 онд улсын хэмжээнд 2004 ялтан суллагдаж,захиргааны хяналтанд 2573 хүн бүртгэгдсэн байх ба шүүхээс 1597 хүн ял тэнсэгджээ. Мөн онд 8324 хүн ял шийтгүүлснээс 1544 нь урьд ял шийтгүүлсэн этгээдүүд байгаа бөгөөд үүнээс онц аюултай гэмт хэрэгтэн 98 нь байгааг судалгаанаас харж болно./

2-рт:Гэмт хэрэг үйлдсэний улмаас хуулийн байгууллагад шалгагдаж байгаа этгээдүүдээс гэмт хэрэг үйлдэх,хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатнаас оргон зайлах явдал их байгааг судалгаанаас харж болно.Иймд уг хүмүүст хэрэглэснээр оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг ихээхэн хэмжээгээр бууруулах хөшүүрэг болж чадна.Бараг бүрмөсөн буурна гэхэд хилсдэхгүй болов уу.

/2012 онд нийт 19734 хүн гэмт хэрэг үйлдсэнээс хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд болон эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан үедээ 161 хүн дахин гэмт хэрэгт холбогдсон гэх тоо баримтаас харахад энэ шатанд дээрхи төхөөрөмжийг хэрэглэх хэрэгцээ шаардлага нэгэнт үүссэн гэдэг нь харагдаж байна/

3-рт: Ял эдэлж буй иргэнийг чөлөөгөөр гадуур гарах, гадуур хөдөлмөр эрхлүүлэх, хуяглан хүргэх, мөн гэрийн хорионд байгаа болон тодорхой эрхийг нь хязгаарласан хүнд цахим гавыг хэрэглэх. Энэ тохиолдолд ял эдэлж буй иргэнийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох бөгөөд оргон зайлсан тохиолдолд уг төхөөрөмжөөр байршил, замыг шууд тогтоон баривчлах боломжтой ба ингэснээр

эрэн сурвалжлах ажиллагааны зардлыг хэмнэх, хамгийн чухал үр дүн нь дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлнэ. ШШГБ-ын хувьд хоригдол оргосон гэх нийгэмд төрүүлсэн айдсыг хурдан хугацаанд арилгах зэрэг ач холбогдолтой юм.

Дэлхийн улс орнуудад зөвхөн гэмт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,нийгмийн хэв журам хамгаалах тусгай зориулалтаас гадна ахуйн хэрэглээнд өндөр настан, сэтгэцийн өвчтөн, тээврийн хэрэгсэл, үнэт эд зүйл, тэжээвэр амьтан, мал зэргийн байршил, хөдөлгөөн хянахад ашигладаг туршлага бий. Өнөөдөр манай улсад дархан цаазат амьтан, тул загас,тээврийн хэрэгсэлд байршуулж ашиглаж байгаа бөгөөд цаашид ашиглагдах бүрэн боломжтой гэж үзэж байгаа юм билээ.



Асуулт :Дээрхи төхөөрөмжийг манай улсад шууд хуулбарлан хэрэгжүүлэх боломжыг та хэрхэн үнэлж байна вэ?

Хариулт: Манай улсад уг төхөөрөмжийг нэвтрүүлэхэд доорхи боломжууд бүрэн байгаа юм.

1. Уг төхөөрөмжийг хэрэгжүүлэх, хяналт тавихад манай улсынзасаг захиргааны нэгжийн зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн хуваарилалт бүрэн зохицоно. Жишээ нь нийслэлд дүүрэг хорооны, аймагт аймаг, сумын хууль сахиулах байгууллагын ажилтан шууд хяналтыг тавьж хэрэгжүүлэх боломжтой юм.Түүнчлэн шаардлагатай холбоо харилцаа, техник хэрэгсэл,дэд бүтцийн салбарт нь ажиллах мэргэжлийн боловсон хүчний хувьд бүрэн боломжтой байгаа гэж үзэж болно.

2.Хууль сахиулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын хувьд мөн бусад орны адил зохицоно.Жишээ нь хяналтыг Цагдаагийн Байгууллагын захиргааны хяналт тавих үүрэг бүхий ажилтнууд тавьж, давхар хяналтыг шууд удирдлага болон хэрэг зөрчлийн шалгалтад хяналт тавихтай адилаар Прокурорын байгууллагаас хариуцаж болно.

3. Энэтхэг, Америк, Мексик зэрэг манай улстай адил нутаг дэвсгэр томтой, зохих этгээдүүдэд шууд хяналт тавих боломж муутай орнуудад шинжлэх ухаан, техникийн ололтыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаанд ашиглаж, уг төхөөрөмжийг амжилттай хэрэглэж өндөр үр дүнд хүрч буй туршлагаас харахад манай улсад ашиглах бүрэн боломжтой юм.

Гэхдээ Монгол Улсын нутаг дэвсгэрт, газар зүйн байрлал, зан заншил, хүний эрх, эрх чөлөөг хангах зэрэг онцлогоос шалтгаалан тухайн техникийг хэрэглэхдээ анхаарч үзэх зүйлс байгааг үгүйсгэхгүй.

Асуулт :Уг төхөөрөмжийг нэвтрүүлж үр бүтээлтэй ашиглахын тулд эн тэргүүнд ямар ажлуудыг хийх шаардлагатай вэ?

Хариулт: -Шаардлагатай мэргэжлийн ажилтнуудыг багтаасан судалгааны багыг бүрдүүлж төсөл боловсруулан хэрэгжүүлэх.

-Санхүүгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд тендер зарлан сонгон шалгаруулах замаар дотоод, гадаадын хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулан шийдвэрлэх боломжтой юм.Гэмт хэрэгтнийг хуяглан хүргэх, гадуур хөдөлмөр эрхлэх,онцгой дэглэмд болон гянданд хоригдож байгаа ялтнуудад хэрэглэх г.м зарим тохиолдолд гарах зардлыг төрийн зүгээс хариуцдаг, бусад тохиолдолд хяналтанд авагдах хүмүүсээс өөрсдөөс нь зардлыг гаргуулдаг байх зэрэг нөхцлүүд байж болно.

Асуулт : Цахим гавыг Монгол улсад нэвтрүүлсэнээр ямар чухал ач холбогдолтой болох талаар та дурьдана уу?

Хариулт: Дээрхи баримтуудаас дүгнэж үзэхэд цахим гавыг гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд зүүлгэн байршуулж, байнгын хяналтанд байлгаж чадсанаар:

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад нөлөөлж, үүний үр дүнд үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурч, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

2.Хууль сахиулах байгууллагуудын шинэчлэлт өөрчлөлтийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх тогтолцоог боловсронгуй болгоход чиглэн хийгдэж байгаа тул уг төхөөрөмжийг ашиглах, түүнээс гарах эерэг үр дүн нь уг зорилготой нийцнэ.

3.Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх ажиллагаанд шинжлэх ухаан техникийн ололтыг ашигласнаар өмнөх хяналт тавьж үйл ажиллагаа хөнгөвчлөгдөнчанаржиж, бусад ажилд зарцуулах зав, боломж нэмэгдэнэ.

4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд төрөөс төсөвлөж зөрцуулах их хэмжээний зардлыг багасгах чухал ач холбогдолтой. Мөн CCTV хяналтын дэвшилтэт системийг хослуулан нэвтрүүлж камерын хяналтыг сайжруулсан тохиолдолд гэмт хэргийн илрүүлэлт эрс нэмэгдэх ач холбогдолтой г.м олон давуу талтай юм.

5.Мөн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүд байнгын хяналтанд байгаа болохоо мэдэж байгаа учраас гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд илчлэгдэнэ гэдгээ ойлгосноор гэмт хэрэг үйлдэх санаа сэдэл нь багасна.

6.Нэгэнт үйлдсэн тохиолдолд төхөөрөмжөөс ирэх мэдээллийн дагуу гэмт хэрэгтнийг хурдан шуурхай баривчилсанаар байгууллага, иргэдэдэд материаллаг болон материаллаг бус хохирол, аюул занал учрахаас сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Асуулт : Өнөөдрийг хүртэл энэ техник хэрэгслийг монголд нэвтрүүлж ашиглах боломж байгаагүй юм уу?

Хариулт: Мэдээж боломж байсан боловч ихээхэн хугацаа алдсан. Гэхдээ энэ нь бас учир шалтгаантай боловуу. Тус цахим гавыг Монгол улсад нэвтрүүлж ашиглахын тулд хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн баг, хамт олны үйл ажиллагаанаас ихээхэн шаардлагатай талаар дээр дурьдсан.

Энд хуулийн мэргэжилтэн дан ганцаараа энэ асуудлыг хэрэгжүүлэх биш, өөрөөр хэлбэл сайн мэдээлэл технологийн инженер/GPS/,цахимын талаарх мэргэжлийн хуулийн ажилтан, программист, радио долгионы инженер, санхүүгийн шинжээч, мэдээж менежер зэрэг олон мэргэжил албадын хүмүүсийн хамтын ажиллагаа, мэдээж төрийн туслалцаа дэмжлэг, оролцоо, гадаад, дотоод хөрөнгө оруулалтгүйгээр шийдвэрлэхэд хүндрэлтэй. Өнөөдрийн байдлаар Монгол улсад цахилгаан гавыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд нөхцөл бололцоо, тохироо нь бүрдсэн

гэж үзэж байна. Зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага нь ч тулгамдсан асуудал болсон байна.

Асуулт : Цахим гавыг хэрэглснээр хүний эрх, эрх чөлөөнд халдаж, хязгаарлаж байгаа асуудал биш үү?

Хариулт: Цахим гавыг гагцхүү хүний эрхийг зөрчиж болзошгүй, хүний эрх, эрх чөлөө, эд хөрөнгөнд халдаж гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хуульд заасан үндсэн журмын дагуу хэрэглэхээр тусгана. Ингэж тэдгээр этгээдүүдийн эрхийг хуулийн дагуу хязгаарласанаар бусад иргэдийнхээ Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалж байгаа явдал юм.

Асуулт : Бодит амьдрал дээр цахим гавыг хэрхэн ашиглаж болох вэ? Жишээ дурьдана уу ?

Хариулт: Гэмт хэрэг үйлдээд суллагдсан этгээдүүдийн өмнө үйлдсэн гэмт хэргийн байдал, зан авир, хувийн байдал зэргийг харгалзан үзэж зорчих маршрут, орох газруудад хязгаарлалт хийж болно. Өмнө нь хамтран амьдрагч эмэгтэйтэй байнга дарамтлан зодож гэмтээн ял эдлээд суллагдсан этгээдэд шүүхээс уулзахыг хориглосон тохиодолд хяналтанд авсанаар зүүлгэсэн хяналтын цахим гаванд өмнөх хамтран амьдрагчийн гэр, ажил, зорчих чиглэлийн дагуу явахыг хориглосон программ суулгасан болох, зөрчиж болохгүй талаар өөрт нь мэдэгдэж, уг этгээд шаардлагыг зөрчин маршрутаас гарч өмнөх хамтран амьдрагчтайгаа уулзахыг завдсан үед дохио, мэдээлэл тухайн хяналтын газар буюу цагдаагийн ажилтанд ирнэ. Ингэснээр хууль хяналтын байгууллагын ажилтнууд газар дээр нь түргэн шуурхай очиж хохирогч эмэгтэйн эрхийг хамгаалж хяналтанд авагдсан этгээдийг саатуулах болно. Мөн өмнө нь бизнесийн хүрээнийхнийг дарамталж мөнгө эд зүйл авдаг байсан этгээдэд бизнесийн хүрээний олон нийтийн арга хэмжээ зохиогдох газар, үзвэр үйлчилгээ, ресторан, цэнгээний газар зэргүүдэд очихыг хязгаарлаж, уг газруудаад цахим гавтай хүнд үйлчилдэггүй байх зохицуулалтыг хийж өгөх зэрэг олон хэлбэрээр ашиглаж болно. Энэ тохиолдолд иргэд дээрхи газруудаар айх аюулгүй, амар тайван үйлчлүүлэх, үйл ажиллагаанд оролцох боломжоор хангагдаж байгаа юм.

Асуулт : Сүүлийн асуултыг танд үлдээ!

Хариулт: Хууль сахиулах байгууллагуудын, тэр тусмаа Цагдаагийн байгууллагын шинэчлэлт өөрчлөлтөөр хууль тогтоомжид нэмэлт заалт оруулах, цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх өөрчлөлтүүд хийгдэж байгаатай зэрэгцэн шинжлэх ухаан, техникийн ололт амжилтуудыг гадаад орнуудыг туршлагыг судалсны үндсэн дээр нэвтрүүлж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажилд ашиглаж хэрэгжүүлэх нь чухал. Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж иргэдийн эрх зөрчигдсөнийх нь дараа биш үйлдэгдэхээс нь урьдчилан сэргийлж, таслан зогсоож сайн ажиллах ёстой юм.

Цаг зав гаргаж бидэнтэй ярилцсан танд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье!

Ярилцсан: Р.Баярмагнай

Т.Ганбаатар

ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн захирал,
докторант, цагдаагийн хурандаа

Өөрийн судалгааны ажилдаа цагдаагийн эргүүл харуул хамгаалалтын тухай тайлагнахаас өмнө та бүхэнд цагдаа гэдэг үгийн талаар тайлбарлах нь зүйтэй гэж үзэж байна.

Цагдаа гэдэг үгийг Я.Цэвэл хэл зүйн үүднээс нь тайлбарлахдаа “Цагдан хорих, хоригч, цагдан сэргийлэх албаны ажилтан, манах, хянах, байцаах зэрэг хэргийг гүйцэтгэх хүн”¹, “Улс нийгмийн, ард түмний амгалан тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий цагдан сэргийлэгч ажилтан”, “Манах, хянах, байцаах хэргийг гүйцэтгэх үүрэг бүхий хүн”² гэсэн утагтай үг хэмээсэн байдаг бөгөөд Англи хэлэнд “police” буюу энэ нь “журамлагч, эргүүл хийгч, хуулийн хэрэгжилтийг хянагч” гэсэн утагтай үг.

Эргүүл гэдэг үгийг Монгол хэлний тайлбар толинд: “Сэргийлэн хамгаалах хянах ажлыг явуулын байдлаар гүйцэтгэдэг албан тушаалтан: гэж авч үзсэн нь эргүүлийн үйл ажиллагаа нь хуулийг сахиулах иргэдийн амгалан тайван байдлыг хангах “Олон нийтийн газар гэдэгт гудамж, талбай, хүн амын бүх төрлийн үйлчилгээний газар, тээврийн буудлууд, бусад үйлдвэр, албан газар, байгууллага, нийтийн тээврийн хэрэгсэл, орон сууц, нийтийн байр, зах зээлийн газар хамаарагдана”³ үүргийн хүрээнд явуулж буй цагдаагийн үйл ажиллагаа юм.

Цагдаагийн хөгжлийн үе шатыг дараах байдлаар хувааж байна:

Үүнд:

- Их бага хаадын үе /1189-1691/ он
- Манжийн үеийн цагдаагийн байгууллага /1691-1911/
- Богд хаант засгийн үеийн цагдаагийн байгууллага/1911-1921/
- Ардын төрийн цагдаагийн байгууллага /1921-1940/
- Цагдан сэргийлэх байгууллага/1940-1960/
- Цагдан сэргийлэх байгууллагын хөгжилт, бэхжилтийн үе/1960-1990/
- Ардчилал, шинэчлэл-өөрчлөн байгуулалтын үеийн цагдаагийн байгууллага /1990-2013/ гэсэн байдлаар хуваан авч үзэж үечилж болох юм.
- 2014 оноос хойшхи цагдаагийн байгууллагын шинэчлэл

Их бага хаадын үе /1189-1691/ он

“Есүхэй баатрын хүү Тэмүүжин 1180-1189 онд овог аймгуудыг нэгтгэн эрхэндээ оруулж, хамаг Монголын хаан Чингис хаан цол хэргэмд өргөмжлөгджээ. Тэмүүжин 1185-1206 онд 32 удаа дотоодын дайн явуулж 81 аймгийг нэгтгэн төхнүүлсэн байна. Эдгээр тэмцэлийн үр дүнд Чингис хаанаар өргөмжлөгдөж бүх монгол туурагтны хаан болсоноор Шихихутагт үүрэг болгож улсынхаа дотоодод дэг журамыг тогтоож хэв журам сахиулах хэрэг зөрчлийг шийдвэрлэх болжээ.”⁴

Монгол улсын түүхэнд эзэн Чингис /1206-1227/ хаанаас эхлэн хамгийн сүүлчийн хаан Чингисийн удам Монголын Лигдэн /1604-1634/ хаан хүртэл 427 жил хаант төр тогтоохдоо хэв журам сахиулах хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг төрийн “тусгай байгууллага, яам, цэргийн” хүчээр болон харъяат улс, түүний зуут, мянгат ,

¹ Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь” УБ., 1966 779-р тал

² Идшинноровын Дамбажав. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг” 2-р боть. 2010 он. 889 тал

³ Б.Пүрэв “Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар” 1997 он УБ хот 27 дах тал

⁴ Нийгмийн хэв журам хамгаалах алба 9 дэх тал

түмтийн аймаг засаг ноёдын хүчээр зохион байгуулж дэв, зэрэгтэй түшмэдүүдэд тохоон томилж байжээ.

Их засаг хуульд цэрэг дайны тухай, ард иргэдийн харилцааг зохицуулах, өв хөрөнгө залгамжлах, олон улсын харилцаа, аж ахуйн өрхийн ба гааль гувчуурын татвар, эрүүгийн хэрэг түүнийг шийтгэх заалт оруулж шийтгэл ноогдуулдагаа байсан.

“Чингис хаан хамаг монгол улсаа сэргээн байгуулсанаас эхлэн их монгол улсын хаанд өргөмжлөгдөх хүртэлх түүхэн үе буюу 1190-1205 он цэргийн байгуулалтынх нь 2-р үе шат байв. Эд шатанд Чингис хаан уламжлалт турхаг цэргийн байгуулалтдаа түшиглэн байнгын бүрэлдэхүүн бүхий “Хишигтэн цэрэг” байгуулан улсын бүх цэргийг арватын тогтолцоонд шилжүүлж байлдааны цагийн хатуу чанд хууль цааз тогтооно, зөвхөн Хишигтэн төдийгүй шууд бус захиргааны цэргээ ч мөн өөрийн шууд удирдлагадаа оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, цэргийн нэгдмэл захиргааны ёсыг бүрэн агуулгаар тогтоох нөхцөлийг бүрэлдүүлсэн нь монгол цэргийн байгуулалтын түүхнээ эрс шинэтгэлийн үе болсон юм.”⁵ Өдрийн эргүүлд “торхон” шөнийн манаанд “хэвтүүл” гэх цэрэг бүхий хишигтэнг ажиллуулж байжээ.

Чингис хааны үед байнгын цэрэгтэй байж, дайн байлдааны үед тэдгээрийг манлай цэрэг, гэзэг цэрэг, гол цэрэг, сүүл цэрэг гэж хуваарилан цэргийн аравт, зуут, мянгат, түмтийн жанжны удирдлагаар хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг зохицуулж иржээ.

Өгөөдэй, отгон дүү Тулуй, II хаан Өгөөдэйн ахмад хүү Гүюг, Чингисийн ач Тулуй овогтой Мөнх, Хубилай нарын үед Чингисийн үеийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгон уламжилж иржээ.

Хубилай хаан ширээнд сууж 1271 онд Юань гүрэн байгуулав. Юань улс нь төв байгууллага, цэргийн хүрээлэн, хууль цаазын байцаах хороо гэсэн байгууллагатай байж хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэхэд гол үүрэгтэй бүтэц бүхий хулгай дээрэмчдийг барих хэлтсүүдтэй байжээ.

Юань улсын үед баруун болон зүүн этгээдийн манаж цагдах, анхан манаж цагдах яамдууд байгуулж, элдэв дэв зэрэгтэй ажилтантай.

Дэв зэрэгтэй түшмэлүүдэд хулгай барих, замын дэлгэрэнгүй тохижуулах, гэмт хэрэг мэдэгч, хэрэг бүртгэгч түшмэлүүд байсан. Мөн тагнуулчийн Яам байгуулж хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх тодорхой төрөл, аппараттай байсныг гэрчилнэ. Монголын V хаан Хубилайн дараагаар Чингисийн ач, гуч нар үе залгамжлан Хубилайн хүү Өлзий-төмөрөөс (1295-1307) эхлэн Тогоонтөмөр (1333-1370) хүртэл арван хаан улс орондоо хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэхдээ эзэн Чингисийн “Их засаг” хуулийг үндэслэн Чингис хааны хүү, ач нарын гаргасан зарлиг, хуулийг баримтлан дэг журам тогтоож иржээ.

Энэ үед торгоны замын дагуу толгой дээрээ тэмээн чинээ алт авч явахад айх аюулгүй байна гэж түүхэн эх сурвалжид дурдаж өгсөн байдаг нь тухайн үеийн эргүүлийн үйл ажиллагаа хэрхэн явдаг байсныг харуулж байна.

Нүүдлийн соёл иргэншилтэй Монголын нийгэм 170 гаруй жил хөгжиж XIV зууны сүүлчээр гүрэн задран бутарчээ. Хятадын ард түмний бослогоор Юань улс устаж, Монголын хаад ноёдыг нутгаасаа 1368 онд хөөн гаргаснаар Хятадыг захирч байсан Монголын 160-аад жилийн ноёрхол эцэс болж, Монгол улс зүүн, баруун хэсэгт хуваагдав.

Зүүн хэсэг нь зургаан түмэн буюу улсаас бүрдэж, дотроо зүүн, баруун түмэн гэж хуваагдаж, зүүнийг хаан, барууныг хааны ойр төрлийн хүмүүс захирч байв.

⁵ Монгол улсын Батлан хамгаалах яамны эрдэм шинжилгээний хүрээлэн “Монгол цэргийн түүхийн товчоон” тэргүүн дэвтэр 107 дахь тал

Баруун Монгол буюу Ойрадууд нь Дөрвөн түмэн буюу дөрвөн аймгаас бүрдэж байжээ. Энэ нь дөрвөд, торгууд, өөлд хошууд гэдэг аймаг улс байв. Ойрдуудын толгойлогч нь хаан Тайши гэдэг тушаалын хүн байжээ.

Монголын бутралын үед хаан буюу Ойрадын тайши нар Чингисийн угсааны халх хаадын хоорондын тэмцэл өрнөж байв. Энэ үеийг Монголын “Бага хаадын үе” гэж үздэг байна. Бага хаадын үед нийгмийн хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх ажилд нэгдмэл байгууллага байсангүй, мөн л цэрэг, жанжнууд, ноёд түшмэд, зарагч-шүүгч нарын хүчээр зохицуулагдаж байжээ.

Манжийн үеийн цагдаагийн байгууллага

Баруун Монголын хаан Галданбошигт нэгдсэн Монгол улс байгуулж, Манжийн эсрэг тэмцэх бодлогыг явуулахад халхын түшээт хаан, богд Жавзандамба нар зөвшөөрөөгүйгээс тэмцэл, тулаан өрнөж Манж чин улс Монголыг дайран түрэмгийлж эрхэндээ оруулснаар 1691 оноос 1911 он хүртэл 220 гаруй жил Манж чин улсын дарлалд байв.

Манжийн түрэмгийлэгчид халх Монголыг өөрийн дарлалд оруулж, ард түмнээс олон төрлийн алба гувчууруудыг авах болсон. Эдгээр алба гувчуурыг хүчээр албадан төлүүлэх нь хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа болж байв.

Энэ үед Монголын хаадын баримталж ирсэн “Их засаг” хууль хоригдож, Халх гурван хошууны дүрэм, 1709 онд халхын түшээт хаан, ноёдын зохиосон “Халх журам” хуулийг даган мөрдөхийг зөвшөөрч, дараа нь Манжийн 1817 оны хууль зүйн бичиг, 1795 оны Монголын цаазын бичгийг голлон хэрэглэж байжээ.

Ар Монголд Улиастайн цагдаа, Их Хүрээний цагдаа, Орон нутгийн цагдаа хэмээх үндсэн 3 том цагдаагийн алба байснаас гадна Богд хан уул, Хан Хэнтий уулын ойн цагдаа, Авын цагдаа, Харчин өртөөний цагдаа зэрэг томоохон цагдаагийн алба байжээ. Их Хүрээний болон Улиастайн цагдаагийн алба тухайн сурвалж судалгааны зохиолд төдийлөн дурьдагдаагүй байна.

Түүхч Б.Буянчуулган 1634 онд туурвисан “Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн” хэмээх зохиолд “Халх Дөрвөд аймгуудын доторхи олон хошуу шавийн хооронд хуваарилагдсан нутгийн өөр өөрийн хил хязгаарыг харгалзсан цагдаагийн алба байв.”⁶

Түүхч Ц.Сономдагва 1961 онд туурвисан “Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911)” хэмээх бүтээлд “Аймаг хошууд нь тусгайлан заан олгосон хил хязгаар бүхий газар нутагтай ба харгалзах цагдаа харуултай байсан.”⁷

Түүхч Л.Гомбо 1960 онд туурвисан “Манжийн үеийн алба гувчуур (1750-1911)” хэмээх зохиолд “Олон хошуудын хилийг харгалзсан харуулуудыг цагдаа буюу тайгам гэж нэрлэж байсан бөгөөд хилийн цагдаа харуул нь ихэвчлэн Монгол нутгийн өмнөд талаар байрлаж байв.”⁸

Ц.Насанбалжир.1963 онд туурвисан “Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911)” хэмээх зохиолд “Олон хошуудын цагдааг нутгийн цагдаа, савын цагдаа, хилийн цагдаа, тайгам хэмээн нэрлэдэг”⁹ хэмээжээ.

Ар Монгол дахь орон нутгийн цагдаагийн гүйцэтгэх үүрэг, байршилийн онцлог байдал зэргээс үндэслэн хоёр ангилж болох юм. Үүнд:

- Дотуур харуул буюу Хилийн харуул лугаа зах нийлсэн цагдаа.

⁶ Б.Буянчулуун. Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн. Худам монгол бичгээс крилл бичигт буулгасан: Хэрээд Ж.Урангуа, Боржигон Дориг З.Энхтайван. УБ., 2010 69-р тал
⁷ Ц.Сономдагва.Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911) ЦБ., 1961

⁸ Л.Гомбо. Манжийн үеийн алба гувчуур (1750-1911) УБ., 1960

⁹ Ц.Насанбалжир. Ар Монголоос Чин улсад залгуул байсан алба (1691-1911). УБ., 1963 129- тал

- Олон хошуудын хилийг харгалзсан цагдаа хэмээн хоёр ангилна.

Манжид 1636 онд Өвөр Монгол, 1691 Ар Монгол буюу Халх Монгол дагаар орсон бөгөөд тэрхүү явцыг далимдуулан Манж нар Монголд олон хошууны систем тогтоож Халхын үндсэн долоон хошууг дотор нь хагалан бутаргаж 86-д хүргэсэн байна.

Архивын барим данс хараанд хошуудын нутгийн хил заан тогтоохыг “нутаг дээслэх”, “савлах”, “ зураг зурах” гэх мэтээр нэрлэж байгаад нэгэнт шийдсэний дараа “язгуураас тогтоосон хэц”, “нутгийн сав болсон газар”, “үүрд зах болсон нутаг”, “хоёр нутгийн дээс”, “овоо байгуулсан газар”, “сав нээсэн нутаг”, “нутгийн тогтоол”, “хил хэлхээ”, “данст нутаг” зэргээр нэрлэж байсан бөгөөд хошууны нутгийн хил тойруулан овоо босгох, пайз тэмдэг хатгах, цагаан чулуу тавих зэргээр батлан бэхэлж байсан бөгөөд тэдгээр халхын олон хошуудын хилийг харгалзах харуулуудыг “цагдаа” хэмээн нэрлэж байсан байна. Тийм учраас олон хошуудын цагдааг нутгийн цагдаа, савын цагдаа, хилийн цагдаа, тайгам хэмээн нэрийддэг байжээ.

ОЛОН ХОШУУДЫН ХИЛИЙГ ХАРГАЛЗСАН ЦАГДАА

Энэхүү цагдаагийн алба нь халхын олон хошуудын хилийг харгалзан тухайн хошууны ард иргэдийг өөр хошуу нутагруу урвуулахгүй байлгах түүнийг таслан зогсоох, хориглох мөн өөр хошууны хүмүүсийг зөвшөөрөлгүйгээр өөрийн нутагт оруулахгүй байх, зах давж харилцан хулгах ардуудыг таслан зогсоох худалдааний хүмүүсийг баривчлах зэрэг цагдан сэргийлэх үүрэг гүйцэтгэдэг байжээ. Тус цагдаагийн албан хаагчдыг халхын олон хошуудаас тэр дундаа харъяат хошуудаас өрх хөрөнгийн хамт нүүлгэн авчирч уул албыг залгуулдаг байсан байна. Олон хошуудын цагдаагийн алба нь орон нутгийн чанартай улсын чухал албаны нэг байсан байна.

Халхын Түшээт хан аймагт: Рэнцэнцаламаас Дамран хүртэлх таван сүвд суугаа олон тооны цагдаа, Түшээт хан аймгийн Тариатайгаас Манхдай хүртэлх дөрвөн суурь цагдаа¹⁰, Түшээ гүн Цэвээндашийн хошууны нутаг Зүлэгт Цагаан бургасын цагдаа цэргүүд¹¹, Шорноос Шаамарын хавцгай хүртэл Түшээт хан аймгийн засаг Эрэнчиндоржийн хошууны 8 суурь цагдаа¹² Түшээт хан аймгийн засаг Гампилдоржийн модны арыг цагдан суугаа цагдаа цэрэг.¹³

Халхын Сэцэн хан аймгийн нутагт: Бэйс Лаваанрэгээний хошууны нутгийн зүүн хойд этгээд Мандал гэх мэт 6 суурь цагдаа¹⁴ Тал булагаас Ундрагч хүртэлх олон тооны цагдаа цэрэг¹⁵, Авчиг Бүхүлэйн олон тооны цагдаа¹⁶ гэх зэрэг маш олон тооны цагдаа цэргүүдийг харъяат хошуудын нутаг дэвсгэр дээр тохиолдсон айл өрхүүдийг өрх хөрөнгийн хамтаар нүүлгэн авчирч уул албаны хашуулдаг байсан байна.

ДОТУУР ХАРУУЛ БУЮУ ХИЛИЙН ЛУГАА ЗАХ НИЙЛСЭН ЦАГДАА.

Энэхүү цагдаагийн алба нь харуулуудтай зах нийлэн байрладаг бөгөөд харуулын цэргүүдэд давхар хяналт тавих харуулын нутгаар дайран өнгөрөх худалдааны хүмүүс болон зорчигчдыг давхар шалган нэвтрүүлэх үүрэгтэй байсан байна. Ялангуяа дөрвөн аймгаас тус цагдаагийн албыг хашиж байжээ.

Халхын Түшээт хан аймгийн нутагт: Түшээт хан аймгийн Улиастайн хэвэй амбан Да Хошой чин вангийн хошууны нутгийн хойд зах Дамран зэрэг харуулуудын

¹⁰ МУУТА. ФМ-1 Д-1 Х.Н-3167,Б-35

¹¹ МУУТА. ФМ-1 Д-1 Х.Н-3168,Б-40

¹² МУУТА. ФМ-1 Д-1 Х.Н-3167,Б-34

¹³ МУУТА. ФМ-1 Д-2 Х.Н-391 ,Б-21

¹⁴ МУУТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746 ,Б-28

¹⁵ МУУТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746 ,Б-34

¹⁶ МУУТА. ФМ-1 Д-2 Х.Н-399 ,Б-4

дотуурхи цагдаа цэргүүд,¹⁷ Түшээт хан аймгийн засаг Цэрэндондовын хошууны Цагаан-Ус харуулын өмнөх Тосон, Харгиастай, Тайраг энэ гурван сүвийг харгалзах цагдаа цэргүүд,¹⁸ Түшээт хан аймгийн хэвэй амбан Хошой Чинн ван Цэрэндоржийн хошууны нутгийн хойд зах Суурьт, Баянбулагийн зэрэг газрын хооронд суулгасан цагдаа цэргүүд¹⁹ Түшээт хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж Үржинжавын хошууны цагдаа цэрэг (Сайн ноён хан аймгийн Иригтэй харуулын өмнөх ам сүвийг харгалзах цагдаа)²⁰, Түшээт хан аймгийн Да Хошой Чин вангийн хошууны нутгийн хойд зах Харлуг, Баянголын зэрэг газар дахь цагдаанууд²¹, Түшээт хан аймгийн Хошой Чин вангийн Цэдэндоржийн хошууны нутгийн хойд захыг цагдан суугаа цагдаа цэргүүд²² Хошой Чин ван Чивгадоржийн хошууны нутгийн хойд хилд суулгасан 9 суурь цагдаа цэргүүд²³, Очирбат Түшээт ханы нутгийн ар гөрөөчний нутгийн хойд захыг цагдан суугаа хоёр суурь цагдаа²⁴.

Халхын Сэцэн хан аймгийн нутагт: сэцэн хан аймгийн бэйс Лаваанрэгзэн засаг Махабаради Цэрэндондовдорж нарын хошууны нутгийн хойд этгээд харуул лугаа зах нийлсэн Цохын бүрдээс Эзнэй гол хүртэлх 5 суурь цагдаа²⁵, Сэцэн хан аймгийн бэйс Минжүүр доржийн хошууны харуул лугаа зах нийлсэн, Алдарууд зэрэг газар суусан 6 суурь цагдаа²⁶, Минж Хүй харуулын дотуур байгуулсан, Илгүүр голын зэрэг таван овооны цагдаа цэргүүд²⁷, Хаслагаас Агач хүртэлх харуулуудтай зах нийлэх хошуудын нутгийн хойд захын цагдаа цэргүүд, Чигтай харуулын амнаас Минж харуулын ам хүртэлх шавь хошууны 6 суурь цагдаа цэргүүд²⁸, Чигтай харуулын амнаас Минж харуулын ам хүртэлх шавь хошууны 6 суурь цагдаа цэргүүд²⁹ Чигтай харуулын амнаас Минж харуулын ам хүртэлх шавь хошууны 6 суурь цагдаа цэргүүд

Халхын Засагт хан аймгийн нутагт: Засагт хан аймгийн Жүн ван Ловчинжамцын хошууны нутгийн хойд зах Цагаанбулан баруун хойд зах Баянбулаг харуул хүртэлх олон ам сүвийн цагдаа цэргүүд³⁰

Засагт хан аймгийн чанчинминд явах Хотгойдын арван зэрэг нэмсэн зургаан зэрэг тэмдэглэсэн улсын түшээ гүнгийн засаг Нялх-Очирын хошууны нутгийн хойд зах нийлэх Тунгалаг толгой зэрэг газрын цагдаа цэргүүд гэх зэрэг маш олон тооны цагдаа цэргүүдийг суулгаж харуулын цэргүүдийг хянах, хяналт тавих үүргийг хүлээн тус албыг хашуулдаг байсан байна.

Харуулын нутагт орж ирэх худалдааны хүмүүсийг хориглох таслан зогсоох үүргийг голчлон гүйцэтгэдэг байсан.

УЛИАСТАЙН ЦАГДАА ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Манжийн зүгээс Монголыг баримтлан захирах гол төв газар нь Жавхлант хот буюу Улиастай (одоогийн Завхан аймгийн төв Улиастай хот) хот байв.

Улиастай хот нь Манж нарын хувьд маш чухал хот байсан учраас түүнийг самуун тэмцлээс хамгаалах, хулгай дээрмээс сэргийлэх ангид байлгахын тулд хянах цагдах явдлыг улам хүчтэй болгож байсан бөгөөд түүний нэг илрэл нь Улиастайн

¹⁷ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-84

¹⁸ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-90

¹⁹ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-90

²⁰ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-88

²¹ МУҮТА. ФМ-1 Д-2 Х.Н-399, Б-11

²² МУҮТА. ФМ-1 Д-2 Х.Н-399, Б-22

²³ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-3167, Б-36

²⁴ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-3167, Б-32

²⁵ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-29

²⁶ МУҮТА. ФМ-1 Д-2 Х.Н-391, Б-8

²⁷ МУҮТА. ФМ-1 Д-2 Х.Н-399, Б-32

²⁸ МУҮТА. ФМ-1 Д-2 Х.Н-399, Б-31

²⁹ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-33

³⁰ МУҮТА. ФМ-1 Д-1 Х.Н-5746, Б-85

байнгын 200 цагдаа цэрэг юм. Тэрхүү 200 цагдаа цэрэг нь Улиастай хотын дөрвөн зүг найман зовхист хуваагдан ажилладаг байсан байна. Тус газарт 1733 оноос “Хязгаар дахиныг тогтоогч их жанжин” хэмээн нэрлэгдсэн Манж Амба сууж байсан ба түүнийг тойрон хүрээлсэн “Хязгаар дахиныг тогтоогч туслагч жанжин” Хэвэй амбан Дорги³¹, Монго жургаан³², Буйган³³ жургаан, Цуухай³⁴ жургаан зэрэг газруудад мөн түүний дээр зэрэг газарт хуваагдан цагдан сэргийлэх, манах, хянах, зарлагад явах, адуу адуулах ээлжнээ суух, мэдээ дамжуулах гэх зэрэг үүрэг гүйцэтгэдэг байсан байна.

Улиастай орчмын зуун газрыг цагдах үүрэгтэй ба энэхүү 200 цагдаа цэргийн 170 цэрэг нь жинхэнэ цагдаагийн албаны үүргийг гүйцэтгэж үлдсэн 30 цэрэг нь цоохор өртөөнд алба хашдаг байв. Их жанжин, Хэвэй бэйс, Хэвэй амбан, Дотоод яаманд үүрэг гүйцэтгэж буй байсан бөгөөд Буйган жургаан, Цуухай жургаан, Монгол жургаан, Туслагч жанжны газарт алба хааж буй цагдаа цэргүүд нь мэдээний албыг хаших болоод туслагч жанжны газраас гаргасан дөрвөн этгээдэд тушаах, байцаах, дуудах зэрэг мэдээний албыг хаах үүргийг хүлээн ажилладаг байв.

Харин Дарийн хүрээ сахих, Наймаа зээлийн газар болоод дөрвөн аймгийн сүв газарт жинхэнэ цагдах, цагдан сэргийлэх үүрэг хүлээсэн цагдаа цэргүүд байх бөгөөд олон газарт хулгай худлын хэрэг болоод наймаа зээлийн газар сул хоргодон суугаа ард иргэдийг тус тусын нутаг хошуунд нь буцаах Улиастайн цагийн хүрээний ойролцоох газар нутгийг маш чандлан сэргийлэх үүрэгтэй байжээ. Манжийн Төр гэрэлтийн 7(1827) он 5 сард халхын дөрвөн аймгаас

Улиастай их жанжны зарлагад Түшээт хан аймгаас 13-н цагдаа цэрэг, Засагт хан аймгаас 2 цагдаа цэрэг, Сайн ноён аймгаас 9-н цагдаа цэрэг нийт 24 цагдаа цэрэг Хэвэй амбан бэйсийн зарлагад Түшээт хан аймгаас 3-н цагдаа цэрэг Сайн ноён хан аймгаас 17-н цагдаа цэрэг бүгд 20н цагдаа цэрэг, Хэвэй амбаны зарлагад түшээт хан аймгаас 9н цагдаа цэрэг, Сайн ноён аймгаас 5н цагдаа цэрэг, Засагт хан аймгаас 6н цагдаа цэрэг бүгд 20 н цагдаа цэрэг Дотоод яамны зарлагад Түшээт хан аймгаас 2 цагдаа цэрэг, Сайн ноён аймгаас 7 н цагдаа цэрэг, Засагт хан аймгаас 1 цагдаа цэрэг бүгд 10 н цагдаа цэрэг, Монгол жургааны яамны зарлагад Түшээт хан аймгаас 8 н цагдаа цэрэг, Сайн ноён аймгаас 2 цагдаа цэрэг, Засагт хан аймгаас 5 н цагдаа цэрэг бүгд 15 н цагдаа цэрэг, Буйган журганы зарлагад Засагт хан аймгаас 2 цагдаа цэрэг, Сайн ноён аймгаас 1 цагдаа цэрэг бүгд 3 н цагдаа цэрэг, Цуухай өртөөний зарлагад Сайн ноён аймгаас 3н цагдаа цэрэг, Дарийн хүрээ сахихад Сайн ноён аймгаас 1 цагдаа цэрэг, Засагт хан аймгаас 1 цагдаа цэрэг бүгд 2 цагдаа цэрэг.

Цоохор өртөөнд Түшээт хан аймгаас 17 н цагдаа цэрэг, Сайн ноён аймгаас 11н цагдаа цэрэг, Засагт хан аймгаас 6н цагдаа цэрэг бүгд 34 н цагдаа цэрэг, Маймаа зээлийн газарт Түшээт хан аймгаас 3н цагдаа цэрэг, Цэцэн хан аймгийг төлөөлж Түшээт хан аймгаас 5н цагдаа цэрэг бүгд 8 н цагдаа цэрэг, Түшээт хан аймгийн сүвийг цагдах газарт тус аймгаас 15н цагдаа цэрэг түүнээс занги 1, цагдаа цэрэг 14,

Сайн ноён аймгийн сүвийг цагдах, Жасаа жанжны мэдээ хавар намрын зургаан сар хаах цагдаанууд тус аймгаас 16 н цагдаа цэрэг үүнээс занги 1, цагдаа цэрэг 15, засагт хан аймгийн сүвийг цагдах газарт тус аймгаас 9 н цагдаа цэрэг, ТХА-аас 5 н цагдаа цэрэг бүгд 14 н цагдаа цэрэг үүнээс занги 1, цагдаа цэрэг 14 байсан байна.

Үүнээс үзэхэд Түшээт хан аймаг ба тус аймгаас Цэцэн хан аймгийг төлөөлж суулгасан цагдаа цэрэг 66, СНА-ийн цагдаа цэрэг 71, ЗХА-ийн цагдаа цэрэг 33 бүгд

³¹ Дорги жургаан хэмээх үг нь Манж үг бөгөөд Дотоод яам гэсэн утагтай.

³² Монго жургаан хэмээх үг нь Монгол яам гэсэн утгатай Манж үг

³³ Буйган жургаан хэмээх үг нь Сангийн яам гэсэн утагтай Манж үг

³⁴ Цуухай жургаан хэмээх үг нь Цэргийн яам гэсэн утагтай Манж үг

200 н цагдаа цэрэг байсан байна. Улиастайн цагдаагийн албыг халхын 4 н аймгийн олон хошуудаас татан эрүүлж залгуулдаг байсан байна.

ИХ ХҮРЭЭНИЙ ЦАГДАА БҮЮУ АРВАН ТАВНЫ ЦАГДАА, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭХ ТАВНЫ ҮҮРЭГ

ХІХ зууны II хагасаас Их Хүрээ нүүдлийн шинж орхиж суурьшмал байдалд шилжин хотжилт маш ихээр төлөвших болсон бөгөөд тэрхүү үйл явцтай уялдан хөдөө орон нутгаас зорин ирэх хүмүүсийн тоо нэмэгдэж хашаа байшин, сүм дугана, дацан олноор баригдаж худалдаа арилжаа өргөжин тэлж худалдаачид, лам нар харчууд гэсэн ялгавар гарчээ. Ялангуяа хөдөө орон нутгаас ядуу хоосон хүмүүс хүрээг зорин ирэх нь нэмэгдэж хулгай дээрэм, хэрэг будлиан гарах нь ихсэх болсон тул Их Хүрээний нутаг дэвсгэр дээр цагдаагийн албыг бий болгох зайлшгүй шаардлага тулгарсан байна.

Үүний тулд “1857 онд тусгай дүрэм гарч Их Хүрээний орчин тойрон газрыг сэргийлэх явдлыг чангатгах арга хэмжээ авсан”³⁵ боловч тэрхүү арга хэмжээ нь амжилтгүй болсон бөгөөд Бүрэнт засагчийн 5-р он (1866 он) 9н сарын 21-нд богдын шавь нарын хэргийг эрхлэн шийтгэх Эрдэнешанзудба Цэдэндорж, Сангийн хамаг хэргийг байцаан шийтгэх сайд тайж Эриндор, Да лам Лувсанхиш нараас хүрээн дэх Сэцэн хан аймгийн цуулган даргад илгээсэн бичигт “...Тушаасаныг дагаж хүрээний ойр тойрон 15 н газар*ыг хэмжээлэн 15 н анги хуваахад хүрээний төв дундыг бодож шар хүрээ**ний өмнөх хаалганы өмнө этгээд ойрхон газар цаг улирлын тооны 24 н зүгт зүг чиг үзэх толь тавьж нийлүүлэн зогсолтоос Эебэрхийн зүгт эрслэж Түшээт хан Цэцэн хан 2 аймаг, улаанаас харын зүг эрслэж Түшээт хан аймаг шавь, Цагаачинаас хөхөгчиний зүг эрслэж Сэцэн хан аймаг Шавь ийнхүү цагдан байцаах газрын завсар болгон хувааж хүрээний гадуур эргэх замаас үүсгэн 36 н алдыг нэгэн газар, 36 н алдыг 1 хувь болгон хэмжиж Эебэрх, Хар, Хөхөгчин 3н зүгийн хэмжээний 1 н газар тутам нижгээд тэмдэг мод хамгаалж гагцхүү 15 н газрын тэмдэг овооний модонд үсэг бичиж бусад 21 зүгийг мод гадуур эргэх замаас үүсгэн хэмжиж 15 н газрын эцэст тус бүр модоор овоо тэмдэг босгож³⁶ байснаас үзэхэд маш нарийн зохион байгуулалттайгаар их хүрээний ойр тойрон газрыг хэмжээлэн хувааж эртний “газар” хэмээх хэмжээсээр хэмжиж хэмжсэн газар бүртээ мод чулуугаар овоо босгох зэргээр таних тэмдэг тавин түүнийгээ цагдаагийн албан хаагчдад үзүүлэн таниулж хариуцуулдаг байсан байна. Ингэж хүрээний ойр тойрон газрыг богдын шар ордноор гол төв болгон зүг бүр тийш хуваахдаа

Зогсолтоос Иевэрхийн (Зүүн хойд зүгээс Баруун өмнөд)-ийн зүгт эрслэн хэмжиж нэгэн газар тутам нэжгээд мод хатгаж 15 н газрын эцэс Арцатын адаг дэвсгэ дээр үсэг бүхий нэгэн модон овоо

Улаанаас харын зүг эрслэн хэмжиж 1-н газар тутам нижгээд мод хатгаж 15-н газрын эцэст Даяны хүрээний баруун өмнө этгээд Нарсат давааний ар нуруу дээр үсэг бүхий модон овоо цагаачинаас хөхөгчиний зүг эрслэн хэмжиж 1н газар тутам нижгээд тэмдэг мод хатгаж 15-н мод газрын эцэс Туул голын хойд этгээд Хужирт булангийн баруун өндөр эргэцэгийн зүүн сайрт үсэг бүхий 1 модон овоо байгуулж энэ 3н овооны хоорон дахь газруудад мөн хүрээний дунд үг зүг чиг тохируулсан газраас зүг чигийг олж зүг тутам гадуур эргэх замаас үүсгэн 15н газар хэмжиж

1. Бар (Баруун урд)-аас Бичин (Зүүн хойд) зүг Туулын дунд голын өмнө төл дээр 1-н модон овоо

³⁵ Р.Гүнсэн, Б.Сэнгэдорж. Цагдан сэргийлэхийн түүхэн өгүүлэл. УБ., 1979 6-р тал “Газар гэдэг нь уртын хэмжүүр бөгөөд Нэг газар нь орчин үеийн хэмжээсээр 576 м болно.

“” Шар хүрээ гэдэг нь Богдын Шар ордонг хэлж байгаа ба хуучнаар Хүүхдийн Пионерын ордон бөгөөд Одоогийн Хүүхдийн урлан бүтээх төвийн хавь газар юм.

³⁶ МУУТА. ФМ-1, Д-1, Х.Н-5007 Б-20

2. Хөхөөс Цагааны зүг Бага наран хэмээх уулын зүүн өмнө этгээдэд 1-н модон овоо
3. Хөхөгчинөөс Цагааны зүг Толгойтын амны голын баруун хажуу дээр 1-н модон овоо
4. Туулай (Зүүн)-аас Тахиа (Баруун)-ны зүг толгойтын Баянхошууны баруун өмнө энгэр амны дээр 1-н овоо
5. Луу (Зүүн урд)-оос Нохой (Баруун хойд)-ын зүг толгойтын зүүн салааны зүүн хажуу байшинтын амны тус хойт хошуу үзүүрийн дэвсэг дээр 1-н модон овоо
6. Орлого (Зүүн урд)-оос Мөнх (Баруун хойд)-ын зүг байшинтын эхний өндрийн хажуу дээр 1н модон овоо
7. Могой (Зүүн урд)-оос гахай (Баруун хойд)-ын зүг Чингэлтэй амны баруун өндөр дээр 1н модон овоо
8. Морь (Урд зүг)-оос Хулгана (Хойд зүг) Даяны хүрээ (Дамба-Даржаа) –ийн аманд нэгэн модон овоо
9. Улаагчинаас харагчиний зүгт билчирт нэгэн модон овоо
10. Хонь(Баруун урд)-оос Үхэр (Зүүн хойд)-ийн зүг Богддавааны ард нэгэн модон овоо
11. Иевэрх(Баруун урд)-ээс Зогсолт(Зүүн хойно)-ын зүг улиастайн голын өмнө этгээдэд нэгэн модон овоо
12. Бичин (Баруун урд)-ээс Барс(Зүүн хойд)-ын Улиастайн голын зүүн этгээдэд нэгэн модон овоо
13. Цагаанаас Хөхийн зүг Мянган лантын амны нэгэн модон овоо
14. Тахиа (Баруун зүг)-аас Туулай(Зүүн зүг)-н Өндөр улааны өвөрт нэгэн модон овоо
15. Нохой (Баруун хойд)-оос Луу(Зүүн урд)- ийн зүг Хан уулын ард Зүүн модны хойд этгээдэд нэгэн овоо³⁷ босгожээ.

Иевэрх Хар хоёр зүгийн хоорондох захаас дотогш хуваарийн овооны доторхи газрыг хүрээний баруун этгээдэд худалдаалах иргэдийн хамтаар Түшээт хан аймаг, Хар Хөхөгчин хоёр зүгийн хоорондох захаас дотогш газар хуваарийн газрын хүрээний зүүн этгээдэд худалдаалах иргэний хамтаар Шавь, Хөхөгчинөөс Иевэрх зүг хоёр зүгийн хооронд дахь захаас дотогш хувиарын овооны доторхи газрыг хүрээний зүүн этгээдэд арван газрын эцэст суугаа иргэдийн хамтаар Сэцэн хан аймаг цагдах байцаадаг байжээ.сэцэн хан аймгийн цагдах ёстой арван таван газрыг доорхи байдлаар хувиарласан байна.Үүнд:

1. Мөнх (Баруун хойд)-оос орлого (Зүүн өмнөд)-ын зүг арван нэгэн газар (633 м)залаагийн зүүн хамрын тус булан дахь чулуун овооноос эрс чиг дөрвөн газар (2304 м)-ын үзүүр Богинын амны Баруун өмнө ар модон доторхи асганы хойд захад нэгэн ургамал хар модонд чулуугаар түшүүлэн цогцлоож нэгэн модон овоо
2. Гахай (Баруун хойд)-аас Могой (Зүүн өмнөд)-н зүг есөн газар (5184м)Бага тэнгэрийн амны баруун хошууны ар дахь чулуун овооноос зургаан газар (3456м) мөн бага тэнгэрийн ар модон доторхи хүрэн асганы зүүн этгээдэд нэгэн ургамал модонд мод чулуугаар цогцлоон нэгэн овоо
3. Хараас улааны зүг долоон газар гурван хувь (4204,8-м) Их тэнгэрийн амны баруун хошууны ар дах чулуун овооноос долоон газар долоон хувь (4435,2 м) мөн Их тэнгэрийн амны эх Хустын баруун өмнөх модон доторхи асганы зүүн этгээдэд ургамал модонд мод чулуугаар нэгэн модон овоо

4. Хулгана(Хойд)-аас Морь (Урд)-ны зүг долоон газар (4032 м) Зайсан толгойн зүүн хойд этгээдэд дэх чулуун овооноос эрс найман газар(4608м)-ын үзүүр Хараагийн зүүн хойд ар хормой Шар хадны өвөр модон дотор нэгэн ургамал хар модонд мод чулуугаар түшээлэн цогцлоож нэгэн овоо
5. Харагчинаас Улаагчны зүг долоон газар гурван хувь (4204,8 м) богины амны адаг дахь чулуун овооноос долоон газар долоон хувь (4435,2 м) зайсангийн эхний шар хадны баруун нурууны зүүн энгэр хажуугийн хэсэг хөх асганы баруун зах нэгэн нарс модонд чулуугаар түшүүлэн цогцлоож нэгэн модон овоо
6. Үхэр (Зүүн хойд)-ээс Хонь (Баруун хойд)-ны зүгт найман газар хоёр хувь (4723,2м) Чандманийн баруун хойд ар дахь чулуун овооноос эрс чиг зургаан газар найман хувь (3616,8 м) Хүйсийн амны өмнө ар модны баруун нурууны бага хөтлын өмнө эрмэг цохион хадан дээрхи нэгэн хуш модонд чулуугаар түшүүлэн цогцлоож нэгэн овоо³⁸ байгуулж Сэцэн хан аймаг хариуцан цагдан байцаадаг байжээ.

Ийнхүү Их хүрээний эргэн тойрон арван таван газрыг хэмжээлж цагдан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байсан учраас хожмоо Арван тавны цагдаа хэмээх нэр томьёо үүссэн түүхтэй юм.

Арван тавны цагдаа нар нь Их Хүрээний хэв журам сахиулах үүрэгтэй байсан юм. Бадаргуулт төрийн 2 он буюу 1877 оны 12-р сарын 30-нд хүрээ дэх Сэцэн хан аймгийн жасаанд суугаа туслагч тайж Гомбожавын бичигт³⁹ Бадаргуулт төрийн 4 он буюу 1879 оны 5-р сарын 1-нд Эрдэнэ Шанзудбын яамнаас Хүрээ сайдын яаманд илгээсэн бичигт⁴⁰ мөн Бадаргуулт төрийн 5-р он буюу 1880 оны 3-р сарын 30 нд хүрээ дэхь Сэцэн хан аймгийн жасаанд суугаа суугаа захирагч

Балжираас Хүрээ сайдын газарт илгээсэн бичгийн дотор бичсэн нь № “тушаасныг дагаж харьяат аймгаас гаргасан арван тавны газрын дотор цагдах дарга хуягуудад тушааж бусад гурван газраас гаргасан занги, шархач, хаалгач, банзач, манаач нарын хамтаар явж хүрээний ойр тойрон газарт илэрхий архины пүүс нээх ба дууч эмсийг агуулан архи дарс уух зоос наадах зэрэг самуун ард байгаа үгүйг чандлан цагдан байцааваас хааяа архи худалдах, зоос наадахыг нь даруй барьж өөр өөрийн газар тушааж залхаан цээрлүүлхээс гадна энэ нэгэн сард энэ мэт муу самуун ард үгүй хэмээн батлан мэдүүлэв⁴¹” хэмээн өгүүлсэнээс үзэхэд Арван тавны цагдаа нар нь:

Их Хүрээний ойр орчмын эргэн тойрон газрын цаг ямагт цагдан манаж тухайн газар орны болоод ард олны аюулгүй байдал амар амгалан тайван байдлыг хангах үүрэг бүхий маш чухал алба байсан төдийгүй эргүүл хийх, харуул гарах явцад ёс бус үйлдэл гаргасан амгалан тайван байдал эвдсэн этгээдийг баривчилж харьяат газартаа тушаах эрх бүхий алба байсан байна.

Арван тавны цагдаагийн албыг Халхын Түшээт хан аймаг, Сэцэн хан аймаг, Богдын Шавь хэмээх гурван газраас цэрэг ардуудыг гарган хашуулдаг байсан ба түүнээс гарах зардлыг Халхын дөрвөн аймгаас бэлтгэн нийлүүлдэг байсан байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЦАГДААГЧИЙН ХҮЧ ХЭРЭГЛЭЛТИЙГ СУДАЛСАН НЬ

³⁸ МУУТА.ФМ-1, Д-1, Х.Н.-5007, Б-55

³⁹ МУУТА.ФМ-1, Д-1, Х.Н.-5606, Б-66

⁴⁰ МУУТА.ФМ-1, Д-1, Х.Н.-5728, Б-1

“Шархач гэдэг нь арван тавны цагдаа нарын бүрэлдэхүүнд явж цогцсонд үзлэг хийдэг албаны хүн. Одоогийнхоор Задлан шинжилгээний ажилтан гэсэн үг.

⁴¹ МУУТА.ФМ-1, Д-1, Х.Н.-5789, Б-5

Батсайханы Батжав

ХСИС–ийн Ерөнхий эрдмийн сургуулийн,
Албаны бэлтгэлийн тэнхимийн эрхлэгч,
цагдаагийн дэд хурандаа, докторант

Аль ч улс орны хувьд дотоод аюулгүй байдлыг ханган, нийгмийн амгалан тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад цагдаагийн байгууллага нь тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд манай улсын хувьд ч аливаа халдлага эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийгмийн дэг журмыг сахиулахад цагдаагийн байгууллагын үүрэг оролцоо өсөхийн хирээр үйл ажиллагааных нь орчны эрсдэл өсөн нэмэгдэж, алба хаагчдад тавигдах болзол, шаардлага ч өндөр болж байна. Төрөөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шинэчлэн өөрчлөхөд ихээхэн анхаарч эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдаагийн албаны хуулийг шинээр батлан гаргасан ба уг хуульд цагдаагийн алба хаагч биеийн хүч хэрэглэж болохыг заасан байна.

Уг хуультай уялдан биеийн хүч гэх ойлголт нь анх удаа шинээр гарч ирж байгаа бөгөөд одоогоор нарийвчлан судалсан судалгаа манай улсад байхгүй байна. Нийгмийн өөрчлөлт шинэчлэлт, мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийг даган гэмт хэрэг, зөрчлийн шинж аюултай, зохион байгуулалттай болж байгаагаас гадна цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, эрх чөлөөнд нь халдах тохиолдлууд цөөнгүй гарсаар байна.

Эдгээр нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан цагдаагийн хүч хэрэглэх сургалт бэлтгэлийн талаар дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч орон болох Америкийн нэгдсэн улсын цагдаагийн хүч хэрэглэлтийг судалж өөрийн орны сургалтанд ашиглах зорилгоор уг сэдвийг сонгон судалсан болно.

Америкийн нэгдсэн улсад олон улсын цагдаагийн удирдах холбоо байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг ба уг холбооноос цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн чиглэлээр судалгаа явуулдаг баүүний дотор цагдаагийн хүч хэрэглэсэн үйлдлийн талаар жил бүр судалгаа явуулж дүн шинжилгээ хийж цагдаагийн албадад дүгнэлт хүргүүлж ажилладаг байна. Уг холбоо нь 1995 оноос эхлэн үндэсний цагдаагийн хүч хэрэглэх өгөгдлийн сангийн төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Энэ төслийн хүрээнд 1999- 2000 оны хоорондох цагдаагийн хүч хэрэглэсэн үйлдлийг судалсан судалгааны үр дүнгээс товч танилцуулъя.

Уг судалгааг танилцуулахын өмнө Америкийн нэгдсэн улсын цагдаагийн сургалтанд хүч хэрэглэх гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлж ойлгодог талаар өөрийн судалгааны үр дүнгээс танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Учир нь манай орны цагдаагийн сургалт, практикт хүч хэрэглэх чиглэлээр нэгдсэн ойлголт, судалгааны ажил одоогоор хийгдээгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Америкийн нэгдсэн улсын цагдаагийн байгууллагаас “ Хүч гэдэг нь цагдаагийн ажилтаны хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцсэн үйлдэлд шахалт үзүүлэхийг хэлнэ.

Хүч нь биеийн хүч, химийн хүч, цохилтын хүч, цахилгаан төхөөрөмжийн хүч,галт зэвсгийн хүчний нийлбэр юмаа.”⁴² гэж тодорхойлсон байна.

“Биеийн хүч” гэдэг ойлголтонд гар, хөлөөрөө өшиглөх, цохих, биеэрээ хийж болох бусадаргуудыг,”Химийн хүч” гэдэгт нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодис болон химийн бодис ашиглахыг, “Цохилтын хүч” гэдэгт резинэн бороохойболон бусад төрлийн цохилтын хэрэгслийг,“Цахилгаан төхөөрөмжийн

⁴²IACP.Police use of force in America 2001. 1 – тал.

хүч”гэдэгт цахилгаан бороохой,ухаан алдуулдаг бууг,taser,цахилгаан зэвсгүүд,“Галт зэвсгийн хүч”гэдэгт төрөл бүрийн галт зэвсгүүдийг хэрэглэхийг ойлгоно.⁴³ гэж тайлбарлажээ.

Олон улсын цагдаагийн удирдах холбоо (IACP) нь цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой олон мэдээллийн санг ажиллуулдаг ба үүний дотроос Үндэсний цагдаагийн хүч хэрэглэх мэдээллийн сангийн судалгаанаас товч танилцуулъя.

Цагдаагийн хүч хэрэглэх мэдээллийн сан нь анх дүүргүүд болон орон нутгийн цагдаагийн байгууллагуудад хэрэглэгддэг байсан ба одоо үндэсний хэмжээнд мэдээллийн санг нэгтгэнажиллуулж байна.

Уг мэдээллийн санд 1991–2000 оны хооронд149,390,551 хүн амыг төлөөлж, 45,913,161 дуудлагын үйлчилгээнд 177,215 хүч хэрэглэсэн явдал, мөн цагдаагийн ажилтаны талаар 8,082 хүч хэрэглэсэн гомдолын талаарх мэдээлэл байсан байна. Зарим тохиолдолд нэг жилийн мэдээллийг төвлөрүүлэн харицуулж хүч хэрэглэсэн түвшинг судалж харуулдаг бол олон жилээр гаргасан судалгаа нь хүч хэрэглэсэн үйл явдлыг групп болгон харуулдаг байна.Дээрх мэдээллийн сангийнзарим судалгааны үр дүнгээс:

1. Цагдаа хэр ойрхон хүч хэрэглэдэг вэ?гэсэн асуултанд 10,000 үйлчилгээ авахыг хүссэн дуудлагын 3,61 хувьд нь цагдаа хүч хэрэглэсэн гэсэн мэдээлэл харагдаж байна. Энэ нь цагдаа 0,036% хүч хэрэглэсэн гэсэн үзүүлэлт юмаа.Нөгөө талаас нь авч үзвэл 99,9639 % цагдаа хүч хэрэглээгүй байна.

1999 онд 10,000 үйлчилгээ авахыг хүссэн дуудлаганд цагдаа хэдий хэмжээний хүч хэрэглэсэн үзүүлэлт

Хүн амын тоо	Бусад	Биеийн хүч	Химийн хүч	Цахилгаан төхөөрөмж	Цохилтын хүч	Галт зэвсэг	Нийт
1	0,00	13,39	0,00	0,00	1,34	0,00	14,73
2	0,00	2,45	1,54	0,00	0,05	0,05	4,10
3	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
4	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
5	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,00
6	0,00	0,00	0,00	0,00	0,00	0,28	0,28
7	0,00	0,00	8,02	0,00	0,00	0,00	8,02
8	0,00	0,72	0,46	0,00	0,49	0,08	1,75

Тэмдэглэл:

Энэ мэдээлэл нь цагдаагийн хүч хэрэглэх үйл явцыг тодорхойлж байна.

Энэ нь хүчний дэд түвшинг хэрэглэж буй цагдаа тус бүрийн үйл явдлынхувийг харуулж байна.


Хүн амыг ялгах тэмдэг

- | | |
|---|-----------------|
| 1 | 0- 15,000 |
| 2 | 15,001 – 35,000 |

⁴³IACP.Police use of force in America 2001.66-тал.


3	35,001 – 55,000
4	55,001 – 85,000
5	85,000 – 170,000
6	170,001 – 500,000
7	500,001 – 1,000,000
8	1,000,001 – 99,999,999

2. **Цагдаагаас хэр их хүч хэрэглэгдсэн бэ?** гэсэн асуултанд 1999–2000 он хүртэлх судалгаагаар цагдаагийн ажилтануудын хамгийн их хэрэглэж байсан хүч нь биеийн хүч байсан ба түүний дараа химийн хүч дараа нь цохилтын хүчийг хэрэглэж байсан байна. Химийн хүчийг хэрэглэх нь (нулимс асгаруулагч) галт зэвсэг, цохилтын хүч, цахилгаан төхөөрөмжийн нийт хүчний нөлөөллөөс илүү байсан.




3. **Цагдаа ямар нөхцөл байдалд хүч хэрэглэдэг вэ?**

1999-2000 оны мэдээлэлд хамгийн их байнгын нөхцөлд хэрэглэгдсэн хүч нь баривчилгаа байсан ба түүний дараа эмх замбараагүй байдал, дараа нь зөрчилтэй тээврийн хэрэгсэлийг зогсоох, уг жилүүдийн үйл явдлын мэдээлэлд хамгийн их хэрэглэгдсэн хүч нь баривчилгаа 39 %, дараагийн том ангилал нь эмх замбараагүй байдал 21%, зөрчилтэй тээврийн хэрэгсэлийг зогсоосон 14% байсан байна.



4. **Жолооч архи болон мансууруулах бодис хэрэглэн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн үед хүч хэрэглэх**

Тээврийн хэрэгсэлийг зогсоосон үед жолооч архи болон мансууруулах бодис хэрэглэснийг урьдчилан таамагласан үед урьдчилан арга хэмжээ авна. 1995 – 2000 онд 838,000 архи уусан зөрчилд мөн хэмжээний хүч хэрэглэсэн гэсэн мэдээлэл байна. Бүх хүч хэрэглэсэн үйл явдлын 46% -ийг архи уусан эсвэл мансуурсан зөрчил эзлэж байжээ.



Дүгнэлт

Дээрх судалгаанаас харахад мэдээллийн сангаас маш олон төрлийн мэдээллүүдийг авч дүн шинжилгээ хийх боломжтой нь харагдаж байна.

Америкийн нэгдсэн улсын цагдаагийн алба хаагчдын хамгийн их хүч хэрэглэсэн хүч нь биеийн хүч байна.

Мөн уг судалгаанд зөрчил гаргагчдын дийлэнх хувийг согтуу буюу мансуурсан үедээ үйлдсэн байгаа нь манай орны хэв журмын нөхцөлтэй ижил төстэй байгаа нь харагдаж байна. Америкийн нэгдсэн улсын үндэсний цагдаагийн хүч хэрэглэсэн мэдээллийн сантай адил мэдээллийн санг Монгол улсад бий болгох нь практик үйл ажиллагаанд хяналт тавих, цагдаагийн мэргэжлийн сургалтыг төлөвлөх, арга зүйг боловсруулахад ач холбогдолтой гэж үзэж байна.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Зэвэгийн Цэрэнбат

ОХУ-ын ДХЯ-ны Москвагийн их сургуулийн адъюнкт, цагдаагийн дэд хурандаа.

Судлаач миний бие өмнөх дугаарт цагдаагийн алба хаагчийн захиргааны эрх зүйн хамгаалалтын ойлголт, мөн чанар, онцлог, эрх зүйн баталгаа, тодорхой төрлийн алба хаагчид үзүүлэх нийгэм, эрх зүйн хамгаалалтын онол, арга зүйн талаар өгүүлсэн нийтлэл хэвлүүлсэн. Энэ удаад алба хаагчдын дунд “цагдаагийн алба хаагчийн нийгэм, эрх зүйн хамгаалалт (баталгаа)- ын өнөөгийн байдал” сэдвээр явуулсан санал асуулга, судалгааны ажлын дүн, цаашид энэ талаар эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хэрхэн боловсронгуй болгох тухай асуудлыг хөндөж байна.

Эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд цагдаагийн байгууллагын шинэчлэлийн асуудлыг боловсруулахдаа иргэдээс судалгаа авахад “Цагдаа иргэдэд үйлчилдэггүй, цагдаагийн байгууллагад шинэчлэл бус хувьсгал хийх хэрэгтэй” гэдгийг олон хүн онцолсоныг судалгааны дүн харуулжээ⁴⁴.

⁴⁴ . Хууль зүйн сайд Х. Тэмүүжин сэтгүүлчидтэй зангиагүй уулзалтанд хэлсэн үг. 2013.10.24. See more at: <http://www.zasag.mn/m/ministry-of-justice/view/3417#leaf>


Цагдаагийн алба, үйл ажиллагаанд дутагдалтай, боловсронгуй болгох шаардлагатай, ялангуяа удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний бодлогын хүрээнд шинэтгэл хийх шаардлагатай олон асуудал бий. Гэхдээ бид чинь цагдаагаа ямар нөхцөлд, шүүгч, прокурортой харьцуулхад хэдэн төгрөгний цалин хөлс олгочихоод, тэднийхээ нийгэм эрх зүйн хамгаалалтанд хэрхэн анхаарал хандуулчихаад байгаа билээ гэдгийг эргэж харах ёстой.

Цагдааг 24-хөн цаг татан буулгасныг зарлаад энэ хугацаанд ямар ч дуудлага авахгүй, хууль үйлчлэхгүй болгочихвол маргааш нь ямар аймшигтай улс болчихоод сэрэхийг төсөөл дөө⁴⁵. Цагдаагийн алба хаагчийн эрх зүй, нийгмийн хамгаалалтын баталгааг төр хамгаалдаг гэх боловч үнэн хэрэг дээрээ хамгаалж чадаж байна уу үгүй юу гэдэгт бид бүгд анхаарал хандуулах цаг нэгэнт болжээ⁴⁶.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь алба хаагчийн нийгэм, эрх зүйн хамгаалалтын талаар тэдний сэтгэл ханамжийн үнэлэмж өнөөгийн байдлыг судалж, үүнд тулгамдаж буй асуудлыг цогцоор тодорхойлох, өөрийн судалгааны ажилд бүтээлчээр ашиглах явдал байлаа.

Судалгаанд нийслэлийн дөрвөн дүүргийн цагдаагийн хэлтэс, баруун зүүн бүсийн хоёр аймгийн цагдаагийн газрын нийт зургаан байгууллагын 364 алба хаагчид санал асуулгад оролцсоноос офицер бүрэлдэхүүнээс 214 хүн, ахлагч бүрэлдэхүүнээс 150 хүн хамрагдсан байна. Ингээд санал асуулгад оролсон алба хаагчдын хариулсан санал, хүсэлт, үнэлэлт зэргийг нэгтгэн графикаар толилуулж байна.

1. Орлогчдын цолны байдал.




Цол	Дэд ахлагч	Ахлагч	Ахлах ахлагч	Дэслэгч	Ахлах дэслэгч	Ахмад	Хошууч	Дэд хурандаа
Тоо	57	50	43	58	78	46	26	6
Хувь	15,6	13,7	11,8	15,9	21,4	12,6	7,14	1,6

2. Боловсролын байдал.

⁴⁵ .Монголын мэдээ сонин. 2013. 12.11. Нэг л өдөр цагдаагүй амьдарвал...


⁴⁶ .Criminology.mn.



Боловсрол	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
Тоо / Хувь	74 / 20,8	9 / 2,47	281 / 77,1

Сүүлийн жилүүдэд ЦЕГ-ын боловсон хүчний бодлогын түвшинд цагдаагийн дамжаанд дээд боловсролтой, иргэдийг судлаж, сонгон шалгаруулж, сургаж томилж байгаа, ХСИС- ийн Цагдаагийн сургуулийг төгссөн, албанд ажиллах сонирхолтой иргэдийг сонгон, судалж шалгаруулан шаардлагатай албан тушаалд томилж, ажиллуулж байгаа учир цагдаагийн алба хаагчдын дунд, дээд боловсролтой иргэдийн тоо харьцангуй өссөн байгаа нь ажиглагдаж байна. Судалгаанд оролцогчдын 20,8 хувь нь бүрэн дунд, 2,47 хувь нь тусгай дунд, 77,1 хувь дээд боловсролтой алба хаагч нар байлаа.


3. Оролцогчдын хүйс.



Хүйс	Эрэгтэй	Эмэгтэй
Тоо / хувь	318 / 87,3	54 / 14,8

Судалгаанд оролцсон алба хаагчдын 87,3 хувь нь эрэгтэй, 14,8 хувь эмэгтэй алба хаагч байлаа.


Оролцогчдын насны байдал



Нас	19-24 нас	25-30 нас	31-36 нас	37-42 нас	43 дээш
Тоо / Хувь	34 / 9,34	148 / 40,6	97 / 26,6	65 / 17,8	20 / 5,49

Судалгаанд оролцогчдын насны хувьд 67,2% нь 25-36 насны залуучууд эзэлж байна. 43 дээш насны алба хаагчдын эзлэх хувь нь дөнгөж 5,49% байгаа нь харцангуй бага байна. “Дөч хүрсэн эр Дөрөвөө дарсан ат” гэж монголчууд ярьдаг жинэхэн хал үзэж, хашир суусан хийдэг, бүтээдэг насны, шинэ залуу боловсон хүчинд зааж зөвлөх хэмжээний туршлага суусан эрчүүд харьцангуй цөөхөн болсон нь албаны залгамж холбоо бүдгэрэх, ажлын үр дүнд нөлөөлөх магадлалтай байгаа нь судалгаанаас ажиглагдаж байлаа.

4. Таны албаны болон эрх зүйн хамгаалалтын мэдлэгийн түвшин.



Мэдлэгийн түвшин	Хангалттай мэддэг	Дунд зэрэг	Мэдэхгүй
Тоо / Хувь	51 / 14,01	194 / 53,2	119 / 32,6

Цагдаагийн төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 5/ Цагдаагийн байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулж, алба хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авна⁴⁷.

Мөн Засгийн газрын 1994 оны 85 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт монгол улсын цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэмээр цагдаагийн аль ч байгууллагын дарга дор дурдсан нийтлэг үүрэг хүлээнэ: гээд г/цагдаагийн байгууллагыг боловсон хүчнээр хангах, тэдний мэдлэг, чадвар, дадлага туршлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах; гэж заасан.

Цагдаагийн алба хаагчид өөрсдийнхөө эрх зүйн хамгаалалтын талаархи мэдлэгийн түвшинг 14,1 хувь хангалттай мэддэг, 53,2 хувь нь дунд зэрэг, 32,6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан юм. Алба хаагч өөрийн бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүрэг, хууль ёсны ашиг сонирхол, эрх зүйн хамгаалалтын тухай мэдлэг нь албан бэлтгэлийн сургалтын онолын нэг хэсэг болдог.


⁴⁷ . Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль. УБ., 1994.01.01. www.legalinfo.mn.

Мэргэжлийн их дээд сургууль, дамжаа төгсөж ирсэн алба хаагчийн мэдлэг дадлага, чадвар, чадамж практик дээр мартагдаж өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдлэг, мэдээлэлээр солигдож өөрчлөгдөн зарим нь бүр мартагдана.

Практик байгууллагад явагдах албаны сургалт нь батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу албанд шаардлагатай мэдлэг, дадлагыг байнгын давтамжаар чадвар, чадамж олгох, түүний тасралтгүй байх, бодитой цаг үеэ олсон байх, сургалтын шинэ арга технологи, хэрэгсэлийг нэвтрүүлсэн байх гээд энэ зарчимаар хэрхэн зохион байгуулж, явагдаж байна вэ?

“Хүн хэдий сайн ч хэлэхээс нааш санахгүй”-н учир тэдний мэргэжлийн мэдлэг, дадлага, чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд бодлогоор анхаарах, дэмжих, шинэчлэх цаг болсон нь бидний хийсэн судалгааны явцаас ажиглагдаж байна.

5. Техник, тусгай хэрэгсэлийн хангалтын түвшин.



Түвшин	хангагдсан	Дутуу хангагдсан	Хангагдаагүй
Хүн / хувь	27 чел / 7,4%	194 чел /53,2%	143 л /39,2%

Цагдаа хуулийг сахиулах, өөрийн болон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэлээр иж бүрэн хангагдсан байх шаардлагатай. Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүрэг гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ⁴⁸. Цагдаагийн албаны тухай шинэ хуулинд хэрэглэх үндэслэл, журмыг тодорхойлоогүй ч дагалдан гарах хуулиудаар зохицуулах тухай яригдаж байна.

Судалгаанд хамрагдсан 364 алба хаагчийн 7,4 хувь нь хангагдсан, 53,2 хувь нь хагас дутуу хангагдсан, 39,2 хувь нь хангагдаагүй гэх ба тусгай хэрэгсэлийг хэрэглэх боломжгүй, хэрэглэсэн тохиолдолд ихэвчлэн алба хаагч өөрөө буруутгагддаг гэж тайлбарладаг. Цагдаагийн алба хаагч бүр нүцгэн гараар” гэмт хэрэгтэй тэмцэж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Мөн албан үүргээ гүйцэтгэж явах үедээ эрсдэлд оруулах магадлалыг албаны тусгай хэрэгсэл, тэр тусмаа хамгаалах тусгай хэрэгсэл “байхгүй”-тэй адил байдаг нь эрсдлийг улам нэмэгдүүлж байна гэж үзэхээр байна⁴⁹. гэсэнтэй санал нэг байна. Ер нь гар хоосон төрийн тусгай алба хаагчтай хэнч яаж ч харьцаж болно гэсэн тийм сэтгэхүй нийгэмд давамгайлах хандлагатай байгаа нь ажиглагдаж байна.

⁴⁸. Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга. “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл.2013/№3.

⁴⁹. Монгол Улсын Хууль Зүйн Яам, Хууль Сахиулахын Их Сургууль, Цагдаагийн Ерөнхий Газар. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй,үйл ажиллагааны орчин түүний шинэтгэл судалгааны тайлан. УБ.,2013. 9 дэхь тал.

Цагдаагийн алба хаагчдыг доромжлох, дарамтлах, тэдний хууль ёс шаардлагыг иргэдийн зүгээс эсэргүүцэх, хүч хэрэглэх, амь биед нь халдах зэрэг үзэгдэл сүүлийн үед багагүй гарах болсон⁵⁰.


Хоосон буунаас хорин хүн айдаг. Манайхан дээр доргүй “галт зэвсэг” гэхээр л хийрхэж сүржигнэдэг.

Цагдаагийн алба хаагч зэвсэг, тусгай хэрэгсэлийг шууд хэрэглээд байхдаа гол нь биш байдаг. Харин ард иргэд энэ зэвсэг, хэрэгсэлээр намайг хамгаалах гэж байгаа юм гэдгийг л сайн ойлгож ухамсарласан байх учиртай.

Иж бүрэн хэрэгсэл, агсамжтай төрийн тусгай алба хаагч үүргээ гүйцэтгэж явааг хараад эмээх, хүндэтгэх, тэгээд алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлдэг байхаар зохицуулаад байгааг бусад улс орнуудын жишээнээс харагддаг.

Энэ нь нэг ёсны алба хаагчийнхаа эрх зүйн хамгаалалт баталгааг бодитой хангах нэг алхам гэж үздэг юм билээ. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүнд ард иргэдийн дунд харьцангуй сайн биш байгааг бас үүнтэй холбож тайлбарлаж болохоор байна.

6. Долоо хоногт ажилладаг цаг.



7 хоногт ажилдаг цаг	40 цаг	50-60 цаг	70 дээш цаг
Хүн / Хувь	22 хүн/6,04 %	112 хүн /30,7%	230 хүн / 63,1%

Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна⁵¹. Гэтэл 364 цагдаагийн алба хаагчийн 6,04 хувь нь долоо хоногт 40 цаг ажиллаж энэ хуулийг мөрддөг бол 30,7 хувь нь 50- 60 цаг, 63,1 хувь нь 70 дээш цаг ажиллаж байгаа нь судалгаанаас ажиглагдаж байна.

Цагдаагийн байгууллага, албан тушаалтанууд алба хаагчидаа хөдөлмөрийн хуульд заасны дагуу ажиллуулах, өөрсдөө хуулиа зөрчдөг, цагийг үр бүтээлгүй дэмий өнгөрүүлдэг, залхаах хэлбэртэй гэх мэт санал, хүсэлтийг алба хаагч нарын ихэнх хувь нь санал асуулгын хуудсанд тэмдэглэжээ. Байгууллагын дарга, удирдах бүрэлдэхүүнээс алба хаагч, хүнийхээ төлөө нийгэм, эрх зүйн хамгаалалттай холбоотой хуулиа бариад, мөрдөөд л ажилчихаа ч гэдгийг л хамт олон хүсэж байгаа юм билээ.

Хөдөлмөрийн хууль, гэрээгээр цагдаагийн алба, ажлын цаг, амралтыг зохицуулхад иргэний болон хувийн хэвшлийн байгууллагатай харьцуулахад нилээд онцлогтой байдаг. Тухайлбал: Албаны үйл ажиллагаа нь цэрэгжсэн хэлбэрээр, захиран, захирагдах ёс, тушаал өгөх, гүйцэтгэх журам, эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоо нь монгол улсын цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, холбогдох журмаар зохицуулагдах учир ажлын шаардлагаар уртасгасан цагаар ажиллах хэрэг түгээмэл

⁵⁰ . Мөн тэнд. 34 дэх талд

⁵¹ . Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 70.1,70.2, 70.3 дахь заалт. 1999оны 07 дугаар сарын 01-ны өдөр.


гардаг. Үүнийг зарим улс оронд дараах байдлаар зохицуулж байна. Хавсран ажиллах нөхцөлөөс хамаараад хэвийн ажлын үргэлжлэх хугацаа нь 7 хоногт 40 цаг байна.

Хавсран ажиллах гэдэг нь: Ажлын үндсэн цагт хүнгүй (шалтгаантай) байгаа үед хөдөлмөрийн гэрээ (контракт)- ний нөхцөлд өөр алба хаагч энэ ажлын байранд үүрэг гүйцэтгэх бол цалинтай байхаар зохицуулахыг хэлнэ⁵².

Ер нь ямар ч улс оронд хүнийг илүү цагаар ажиллуулах шаардлага гарсан үед алба хаагчтай тохиролцон, алба хаагчийн зүгээс үүргээ сайн гүйцэтгэх, байгууллагын зүгээс хангалттай цалин, хангамж олгодог байх тийм зарчим дээр тулгуурлаж гэрээ байгуулж ажилладаг юм билээ.

Ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх түүнийг зөв үр өгөөжтэй зохион байгуулах, хуваарлах чадвар, хамт олныг идэвхжүүлэх удирдлагын тэр зөв арга барил, менежмент хэрэгтэй байгаа нь ажиглагдсан.

7. Хөдөлмөрлөх нөхцлийн түвшин .



Түвшин	Хангалттай	Дунд түвшинд	Хангалтгүй.
Тоо / хувь	70 / 19,2	155 / 42,5	139 / 31,8

“Хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийг;⁵³

Судалгаанд хамрагдсан 364 алба хаагчдын 19,2 хувь өөрсдийн ажлын нөхцөлийг хангалттай, 42,5 хувь нь дунд түвшинд, 31,8 хувь нь хангалтгүй гэж үзсэн.

Цагдаагийн эрүүл мэнд аюулгүй ажиллагааны баталгаа нь номхотгох сандал, гав , хүлэг, номхотгох цамц, хорих өрөө байдаг⁵⁴. Тэгвэл хөдөө орон нутгийн сум, хорооны цагдаад ийм нөхцөл байхгүй нь алба хаагч үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж муу, тэдний эрх зүйн хамгаалалт баталгаагүй болох нь дээрхи судалгаанаас харагдаж байна.

Мэргэжлийн онцлогоос шалтгаалаад эрүүл мэндээрээ хохирдог, ялангуяа замын цагдаа, эргүүлийн цагдаа, эрүүлжүүлэх байрны цагдаа зэрэг нэгж дээр ажилладаг алба хаагчдын ажиллах нөхцөл хүнд байдаг байна⁵⁵.

⁵² .С.П. Матвеев. Служебно-трудовые отношения в системе государственной службы. Воронеж.2008. С.26.

⁵³ Мөн хуулийн 3.1.10.дахь заалт.

⁵⁴ www.olloo.mn.Монголын мэдээ. 2013.12.09. Мэдээний дугаар.1237704.

⁵⁵ Монгол Улсын Хууль Зүйн Яам, Хууль Сахиулахын Их Сургууль, Цагдаагийн Ерөнхий Газар. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй,үйл ажиллагааны орчин түүний шинэтгэл судалгааны тайлан. УБ.,2013. 35 дахь тал.


Ажиллах таатай нөхцөл, ажлын зөв зохион байгуулалт нь ажлын амжилт болдог. Хүний хүчээр гэмт хэрэг, гэмт хэрэгтэнтэй тэмцдэг цаг улиран одож буйг хөгжингүй орнуудын жишээн дээрээс харж болохоор байна⁵⁶.

Хууль сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэхэд орчин үеийн дэвшилтэд технологийг хэрхэн ашиглаж байгааг судалж цагдаагийн алба үйл ажиллагаанд нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд хуучин арга барилаар, сэтгэлгээгээ өөрчлөхгүйгээр цагдаагийн алба үйл ажиллагааг удирдах нийгмийн хөрс үгүй болсон.

Гэхдээ “өнгөрсөн үегүйгээр өнөөдөр, өнөөдөргүйгээр маргааш гэж байхгүйтэй” адил шинээр ажиллаж байна, шинэчлэж байна гээд урьд нь хэрэглэж байсан түүнд хүмүүс нь дасан зохицсон, ажлын дэвшилттэй арга барил, технологи, шинжлэх ухааны ололт зэргийг ашиглахгүй, хэрэглэхгүй байхын нэр биш юм.

Аливаа нийгэм дахь өөрчлөлт, шинэчлэлийн зорилго нь өнгөрсөн, одоо, ирээдүйн хөгжлийн тунгаамал байдаг л оршино⁵⁷.

8. Ажлын дараагийн өдөр амжилттай ажиллахад хангалттай амардаг эсэх.



хариулт	Тийм	Дунд зэрэг	Үгүй
Тоо / Хувь	41/11,2	100/27,4	223 61,2

Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна⁵⁸.

Судалгаанд хамрагдсан 364 алба хаагчдын дөнгөж 11,2 хувь нь дараа өдрөө ажиллахад хангалттай амардаг гэсэн бол 27,4 хувь нь дунд зэрэг, 61,2 хувь нь дараа өдрөө амжилттай ажиллахаар хангалттай амарч “чаддаггүй” гэсэн байгаагаас үзэхэд яаж ч ажилласан нэг л тогтмол цалин авна гэсэн сэтгэхүйтэй болсон нь ажлын амжилт, үр дүн харьцангуй муу байхаар ажиглагдаж байна. Жишээ нь жижүүрт гараад, буугаад үргэлжлүүлэн илүү цагаар ажилладаг учир маш их ядарсан байдаг, 7 хоногт нэг удаа амарвал их юм, удирдлагаас амрах боломж олгодоггүй, оройтож гэртээ харьдаг, ачаалал ихтэй байдаг, хэт оройддог,


Зарим алба хаагчид 24 цагаар жижүүрт гараад, 48 цаг амрах үедээ эргүүлд гардаг, техник хэрэгсэл дутуу байж болох ч удирдах албаны ур чадвар, сэтгэлгээ муу байж болохгүй, дарга нар зөвхөн өөрийгээ бодож, дээшээ бол долигнож харьцдаг, хэн хит их ачаалалтай ажиллаж байна гэдгийг мэддэггүй, бидэнд өнөөдөр амьд байх баталгаа байхгүй болсон шүү гэх мэтээр санал асуулгын хуудсанд тайлбар хийсэн нь дээрхи тоо баримтыг баталж байгаа юм.

⁵⁶ Я. Цэлмэн. Гэмт хэрэг, гэмт хэрэгтэнтэй тэмцэхд байрлал тогтоох системийг /GPS / ашиглах зарим асуудал. Нийтлэл “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл. 2013 /№3. 53 дахь тал.

⁵⁷ .З. Цэрэнбат. Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн баталгааны зарим асуудал. “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл 2013/№2 Нийтлэл. 82 дахь тал.

⁵⁸ .Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 70.3 дахь заалт. 1999оны 07 дугаар сарын 01-ны өдөр.

11.Ээлжийн амралтаа нэмэгдэл хоногтой нь эдэлдэг эсэх.




Хариулт	Тийм	Ажлын шаардлагаар дуудагдаж ордог	Үгүй
Тоо / Хувь	95 / 26,09	35 / 9,6	263 / 72,2

Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна⁵⁹.

Судалгаанд оролцсон 364 алба хаагчдын 26,9 хувь ээлжийн амралтаа нэмэгдэл хоногтой нь бүтэн эдэлдэг гэсэн бол 9,6 хувь нь ажлын шаардлагаар дуудагдаж орсон, 72,2 хувь нь амралтаа нэмэгдэл хоногтой нь бүрэн гүйцэт, сэтгэл амар амарч чаддаггүй гэсэн байна.

Мөн алба хаагчид амарвал зохих илүү хонгийг эдлүүлдэггүй, цагдаагийн байгууллагад хөдөлмөрийн хууль хэрэгжүүлдэггүй шүү, 14 жил ажиллахад нэг ч удаа бүтэн амраагүй, гэх мэтээр тайлбар хийснийг энд дурьдахгүй байх аргагүй юм.

12. Байгууллага албан тушаалтанаас алба хаагчийн эрхийг хамгаалах чиглэлээр зохиогддог ажлын түвшинг үнэлэнэ үү?



Хариулт	сайн	Дунд зэрэг	Муу
Тоо / Хувь	40 / 10,9	205 / 56,3	119 / 32,6

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэмэнд байгууллагын даргын нийтлэг үүргийн д/ бие бүрэлдэхүүний хууль ёсны эрх ашгийг

⁵⁹ .Мөн хуулийн 79.1.заалт /Энэ хэсэгт 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/


хамгаалах⁶⁰ гэж заасан нь тухайн байгууллагын дарга нь алба хаагч тэдний эрх ашгийг хамгаалах, нийгэм эрх зүйн хамгаалалтын ажлыг хамт олны дунд зохион байгуулж, удирдаж ажиллахаар харагдаж байгаа юм.

Судалгаанд оролцсон 364 алба хаагчийн 10,9 хувь нь алба хаагчдын эрх зүйн хамгаалалт нь “сайн” гэсэн бол, 56,3 хувь “дунд зэрэг”, 32,6 хувь нь бидний эрхийг хамгаалдаггүй “муу” гэсэн дүн тавьсан байна.

Мөн хүн удирдах, зохион байгуулах чадвар маш муу, хуучинсаг арга барилаас салах, алба хаагчдынхаа эрх ашгийг хамгаалах талаар дарга нар юу ч хийдэггүй, дарга нарын дэмжлэг хэрэгтэй байна, удирдлагын сэтгэлгээг өөрчлөх, удирдах албан тушаалтнуудын мэдлэг, чадвар, ажлын арга туршлагыг нь харгалзаж, шударгаар томилох гэх мэтээр шүүмжлэлтэй хандаж санал асуулгын хуудсан тэмдэглэсэн байна.

Харин шинээр дагаж мөрдөх “Цагдаагийн албаны тухай хуул”-ийн 14-д нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үүрэг гээд 1.6-д байгуулага, алба хаагч ажилтаны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах гэсэн байгаа нь сайшаалтай хэдий ч “байгуулага” гэдэг үг нь эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээх ямар нэгэн тодорхой албан тушаалтан биш учир хэн удирдаж, хэн зохион байгуулах нь бас л тодорхой биш санагдан.

13. Албан үүргээ гүйцэтгэж яваад ямар нэгэн эрсдэлд орсон нөхцөлд таны эрхийг хамгаална гэдэгт итгэх үү?



Хариулт	итгэдэг	Итгэдэггүй	Мэдэхгүй байна
Тоо / хувь	43 / 11,8	239 / 65,5	82 / 22,5

Хөгжингүй ардчилсан, энэрэнгүй хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг улс орнуудын туршлагаас ажиглахад цагдаагийн алба үйл ажиллагааг эрсдэлтэй, онцгой нөхцөл гэдэгт хамааруулж үздэг⁶¹.

Судалгаанд хамрагдсан 364 алба хаагчид дээрхи асуулгад 11,8 хувь нь ямар нэгэн эрсдэлд орсон тохиолдолд хамгаална гэдэгт **итгэдэг** гэсэн бол, 65,5 хувь нь **итгэхгүй**, 22,5 хувь нь **мэдэхгүй** байна гэж хариулсан.

Мөн алба хаагчид дараах байдлаар санал, шүүмжлэл бичсэн байна. Тухайлбал цагдааг хамгаалах ямарч эрх зүйн зохицуулалт байхгүй, дарга нар цагдаа хүн ямар ч зөв юм хийсэн ч бурууддаг явдал их бий, цагдаагийн зөв байсан ч шууд л түүнийг буруу мэтээр хандан, гутаан доромжилдог тэгээд албан үүргээ гүйцэтгэж яваад эрсдэл гаргасан л гэж тооцно, дарга нар алба хагчдыг цааш нь улам түлхэнэ, шууд группд гаргана гэнэ, эмчлүүлэх зав гардаггүй, асуудалтай тулвал цагдаа гэдгээ хэлэхээс аль болох зайлсхийдэг, ажил дээр дарга нар дарамтлан, гудамжинд үүргээ

⁶⁰. Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 85 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Монгол улсын цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм.

⁶¹. З.Цэрэнбат. Албан үүргээ гүйцэтгэж яваад тахир дутуу болсон, амь нас эрсэдсэн цагдаагийн алба хаагчийн ар гэрт үзүүлэх нийгэм, эрх зүйн хамгаалалтын онцлого. Нийтлэл. “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл. 2013 /3/. 13 дахь тал.

биелүүлээд явахаар захын иргэд буруутгана маш хэцүү гэхдээ удахгүй, хүнийхээ төлөө гэсэн тэр нэгэн цаг үе ирнэ гэдэгт итгэж байна гэх мэт.

Цагдааг хамгаалдаг эрх зүйн зохицуулалтгүй, өмөөрдөг дарга нар ховор гэдэг нь ярилцлагын судалгаанаас давхар нотлогдож байв.

Зарим дарга нь хамгаалахын оронд сахилгын арга хэмжээ авахыг эрмэлздэг гэж байв (Жилд дунджаар 2289 алба хаагч 2274 сахилга, ёс зүйн зөрчил гаргадаг бөгөөд үүний 82.9 хувийг нэгж байгууллагын буюу газар, хэлтсийн даргын шийдвэрээр арга хэмжээ авчээ).

Энэ бүхний үр дүнд цаашид Хууль зүйн яамны 2012-2016 онд хийх ажлын хүрээний төлөвлөгөөнд тусгагдсан “Цагдаагийн алба хаагчийн эрсдлийн менежмент”-ийг боловсруулан мөрдүүлэх нь зайлшгүй болжээ⁶².

Дүгнэлт:

Дээрхи санал асуулга, судалгааны ажил дээр үндэслэн цагдаагийн алба хаагчийн нийгэм эрх зүйн хамгаалалтын өнөөгийн байдалд дараах байдлаар дүгнэлт хийж болохоор байна.

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчин хангалтгүй, үүнд цагдаагийн алба хаагчдын эрх зүйн хамгаалалт, хуулиар баталгаажуулсан эдийн засаг, нийгмийн баталгаа, хуулиар тогтоосон үйл ажиллагааны хязгааралт, зохицуулалт хангалтгүй, хэрэгжүүлэх шаардлагатай зарим хууль, хуулийн заалт, зүйлүүдийг хэрэгжүүлэх механизм дутагдалтай, зарим дарга нар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай хуулийн заалт, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэггүй юм байна.
2. Даргалах, удирдах бүрэлдэхүүний томилгоог шударгаар томилдоггүй, мэргэжилийн бус, ажлын дадлага туршлагагүй, сонгон шалгаруулалтгүйгээр дээд газраас томилодог учир хамт олон түүнийг цаанаа хүлээж авдаггүй. Томилогдсон этгээд албаны онцлог, эрсдэл, алба хаагчдын сэтгэл зүйг гадарлахгүй байх тул хүнийхээ төлөө гэсэн сэтгэлгээг бүрэн төлөвшихгүй байсаар, ажил нь урсгалаар явагдсаар солигддог. ЦЕГ-ын хэмжээнд боловсон хүчний бодлого алдагдсан гэж дүгнэж болохоор байна.
3. Цагдаагийн алба хаагч орчин үеийн техник, хамгаалах болон нэг бүрийн тусгай хэрэгсэлээр хангагдаагүй, биеийн хүч, мэх хэрэглэсэн тохиолдолд эрх зүйн хамгаалалт сул учир ихэвчлэн өөрөө буруудаг учир зайлшгүй шалгах, хууль ёсны шаардлага тавих, таслан зогсоох ажиллагаа хийгдэхгүй эсвэл хугацаандаа хийгдэхгүй байх магадлалтай бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлтийн өсөлт, гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирогчдын тоо, бусад хохирол нэмэгдэж байгаа нь үүнтэй холбоотой байх магадлалтай. “Сайн мужаан хүн багажгүй бол юу бүтээх бол”... гэдэгтэй зүйрлэж болно.
4. Цагдаагийн алба хаагч, хамт олон дарга, удирдлагадаа итгэх итгэл нь суларсанаар бодит амьдрал дээр хууль сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээ үзүүлэх ажил бодитой биелэлээ олохгүй, ажил цаасан дээр, ярих төдийгөөр явагдаж, алба хаагчид сэтгэл зүй, бэлтгэлийн хувьд үүрэг гүйцэтгэхэд бэлэн бус байна гэж үзэж болохоор байна.
5. Алба хаагчийн ажиллах ажлын байрны нөхцөл хангалтгүй, ажил үүргийн хуваарилалт тодорхой бус байгаа нь ажлын үр дүн, гүйцэтгэлд сөрөгөөр нөлөөлсөөр байна. Ийм нөхцөл байдалд жирийн цагдаагийн албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ хэвийн сайн гүйцэтгэж байна гэж дүгнэж болно.

⁶². Монгол Улсын Хууль Зүйн Яам, Хууль Сахиулахын Их Сургууль, Цагдаагийн Ерөнхий Газар. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин түүний шинэтгэл судалгааны тайлан. УБ., 2013. 8 дахь тал.

**ТЕРРОРИЗМЫН АЮУЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ**

Балжиннямын Баянмөнх

ХСИС-ийн, цагдаагийн сургуулийн, цагаагийн эрх зүйн
тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн ахмад

Дэлхий дахинаа даяаршлын үйл явц улам бүр гүнзгийрэхийн зэрэгцээ олон улсыг хамарсан, үндэстэн дамнасан зохион байгуулалттай, алан хядах үйл ажиллагаа түүнээс улбаасан гэмт хэрэг, тухайлбал галт зэвсэг, мансууруулах бодис болон хүнийг хууль бусаар хил давуулан наймаалах гэмт хэргүүд газар авч, терроризмын аюул улам бүр дэлхийг хэрэн сүлжиж байгаа нь улс орнуудыг нэгдмэл хүчээр хамтарч ажиллахыг зүй ёсоор шаардаж байна.

Монгол Улс терроризмын эсрэг олон улсын үйл ажиллагааг дэмжиж дотооддоо холбогдох тогтоол шийдвэр гаргаж, түүний хэрэгжилтийг хангах, гадаад улсуудтай хамтран ажиллах, мэдээлэл харилцан солилцох зэрэг шат дараатай арга хэмжээ авч байна.

Тухайлбал “Терроризмтой тэмцэх тухай”⁶³ Монгол Улсын хууль, “Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай”⁶⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай”⁶⁵ Засгийн газрын тогтоол, “Олон улсын алан хядах үйл ажиллагаанаас сэрэмжлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг тус тус батлан гаргасан байна.

“Терроризмтай тэмцэх тухай” хуулинд терроризмаас сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг зааж, түүний аюулаас сэргийлэх талаар төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний хүлээх үүргийг тогтоож өглөө.

Энэ хуулиар Засгийн газар нь терроризмаас сэргийлэх үндсэн арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, терроризмаас сэргийлэх арга хэмжээний улсын нэгдсэн төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хүлээх болж байна.⁶⁶

Терроризм⁶⁷ гэдэг нь үзэл сурталжсан хүчирхийлэл дээр үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, улс төрийн тэмцлийн арга хэлбэр юм.

⁶³ УИХ-ын 2004 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганаар батлагдсан.

⁶⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 60 дугаар зарлигаар баталгаажсан.

⁶⁵ 2001 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Засгийн газрын 226 тоот тогтоол /захирамж/-оор батлагдсан. Уг тогтоолд АНУ, бусад улс орон, тэдгээрийн болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай алан хядагчдын санхүүжилтийн эх үүсвэрийг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллахад бэлэн ажиллахад илэрхийлж, үйл ажиллагаагаа Монголбанктай уялдуулан зохицуулах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенцид нэгдэн орох арга хэмжээг авах, терроризмын эсрэг дэлхийн улс түмэн хүч чармайлтаа нэгтгэхийг уриалсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохиож, НҮБ-д эргэж мэдээлэх, террористуудын талаар болон тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр болсон хар тамхи, мөнгө угаах үйл ажиллагааны талаар эвсэлд орсон улс орны холбогдох албадтай хуулийн хүрээнд мэдээлэл солилцох, хамтран ажиллахыг холбогдох сайд нарт даалгасан байна.

⁶⁶ Ц.Дашзэвэг., Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. УБ. 2004. 12 дахь тал

⁶⁷ “Терроризмтой тэмцэх тухай” хуулийн 3.1.1-д “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг;

Терроризм⁶⁸ –нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулах, олон улсын хэмжээний онц чухал объектууд, АЦС, цөмийн болон хими, бактерилогийн зэвсгийн үйлдвэрүүдийг эзлэх, халдахыг завдах, ард түмнийг айлган сүрдүүлэх, алан хядах бүлэглэлүүдийн эрх ашгийг хангахуйц шийдвэрийг удирдлагын зүгээс гаргуулах зорилгоор бие хүн болон байгууллагын эсрэг хүчирхийлэл үйлдэх, эд хөрөнгө, бусад материаллаг зүйлсийг гэмтээх, устгах, улс орны дотор улс төр, эдийн засгийн онцгой байдлыг бий болгох, улмаар улс хоорондын харилцааг хүндрүүлэх, дайн үүсгэх эх үүсвэрийг бий болгох, үндэстэн ястнуудын хооронд хагалан бутаргах үйл ажиллагааг санаатайгаар зохион байгуулах явдал юм.⁶⁹

Сүүлийн үед террористууд улс орон, олон нийт, үндэстэн хоорондын болон шашны нөлөөллийг ашиглан зэвсэгт тэмцэлд оруулж болзошгүй байгаа нь бүс нутгуудад болж байгаа үйл явдлуудаас тодорхой болж байна.

Бид юуны өмнө аливаа террорист халдлага аюул заналыг зэргэлдээ орнуудад болж буй үйл явдал, тэдний гадаад шинж төрх байдал олон улс орныг хамрах хүрээ, далайц зэрэгт дүгнэлт хийж, улс орны хил хязгаарыг нэвтрэн орж ирж болзошгүй нөхцөлд хариу арга хэмжээг цаг алдалгүй авахад бэлэн байж, дотооддоо нэн сонор сэрэмжтэй, аюулыг урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд хууль сахиулах байгууллагуудаас гадна олон нийт өндөр мэдрэмжтэй, сонор сэрэмжтэй байхыг цаг үе зүй ёсоор сануулж байна.

Тиймээс хөрш орнуудад болж буй террорист халдлагатай холбоотой гарч буй үйл явдлыг байнга ажиглаж, холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч байх шаардлагатай болдог.

Гэхдээ бид терроризм буюу алан хядах ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, тэмцэхдээ үндэсний хууль тогтоомжийн шинэчлэлд онцгой анхаарч, терроризм буюу алан хядах ажиллагааны тухай ойлголтыг улам илүү тодорхой болгох, алан хядах шинж бүхий гэмт хэргийн бүрэлдхүүнийг тогтоох, үндэсний хууль тогтоомжийг олон улсын жишиг стандартанд хүргэх, олон улсын гэрээ, конвенцийн заалттай нийцүүлэх шаардлага байна.

Терроризмын зорилго:

- Нийгмийг айдаст автуулах
- Хууль бусаар засгийн эрхийг авах
- Эдийн засгийн хохирол учруулах
- Шашны нөлөөлөл бий болгох
- Улс орны хүчин чадлыг сулруулах
- Үндэстэн хоорондын зөрчилдөөн үүсгэх
- Эмх замбараагүй байдал үүсгэх

Терроризмаас сэргийлэх гэдэг нь улс орондоо терроризм үүсэх шалтгаан, нөхцөл бүрдэхээс болон иргэдийн аюулгүй байдлыг террорист ажиллагаа, үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор төр, түүний байгууллага, иргэн, хуулийн этгээдээс авч хэрэгжүүлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхийг хэлж байна.

Өөрөөр хэлбэл терроризмаас сэргийлэх арга хэмжээний зорилго нь нэгд, терроризм үүсэх шалтгаан, нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх, хоёрт, төрийн

⁶⁸ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 401 дэх тал. Терроризм- (лат. англ. terror) өргөн утгаараа террорист бодлого ба практик хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл;

⁶⁹ Терроризмын эсрэг. /Терроризмын эсрэг Монголын холбоо/. УБ. 2003. 12 дахь тал

тогтвортой ажиллагаа хийгээд иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг террорист ажиллагаа, террорист үйлдлээс сэргийлэн хамгаалахад оршиж байна.

Тэгвэл терроризмаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэгч субъект нь:

1. Төр, түүний байгууллагууд;
2. Өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээдүүд;
3. Иргэд болж байна.⁷⁰

Тиймээс терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй нэг байгууллага, иргэд байхгүй бөгөөд үүнийг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагад ухуулан сурталчилах, тайлбарлан таниулах ажлыг чанартай, хурдан шуурхай зохион байгуулах явдал чухал юм.

Терроризмын сөрөг үр дагавар:

- Олон улсын аюулгүй байдалд заналхийлдэг
- Нийт ард иргэдэд сэтгэлзүйн хүчтэй нөлөөлөл бий болгодог
- Ямар ч гэм буруугүй энгийн олон иргэдийн амь насыг хохироодог
- Улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоог алдагдуулдаг

“Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”⁷¹ -д заасан үндэсний аюулгүйбайдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмаас сэргийлэх талаар мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий “Зохицуулах зөвлөл”-ийг Тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулан ажиллаж байна.

Терроризмын үйл ажиллагаа нь олон улсын хэмжээнд байгалийн эх үүсвэрийн нөөц, үнэт ашиг малтмалаар баялаг газар нутагт дарангуйлал тогтоох, дэлхийн улс гүрнүүдийн төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх оролдлого хийх, олон нийтийг хамруулсан улам их их аюул занал учруулж болзошгүй боллоо.

Ялангуяа бүс нутгийн тогтворгүй байдал үүсэхэд нөлөөлж буй терроризмын үр хөврөлийг үндсэрхэг үзэл, шашны үл тэвчих буюу хэт даврагч үзэл, цөмийн болон ердийн зэвсгийн тархалт, хууль бус цагаачлал, хүний арилжаа, хар тамхи, мансууруулах бодисын худалдаа, хил, газар нутгийн маргаан, зохион байгуулалттай гэмт хэрэг, амьдралын доройтол, ядуурал зэрэг нь олон зүйл нөхцөлдүүлдэг.⁷²

Тиймээс терроризмын гэмт хэрэгт холбогдож болзошгүй, террорист халдлага үйлдэж магадгүй гэсэн дор дурдсан этгээдүүдэд тавих захиргааны хяналтыг чангатгах, хяналтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавих субъектүүдийн ажлын зохион байгуулалтыг тодорхой болгож, нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангах шаардлага нэгэнтэй бий болсон байна. Хяналтанд заавал байх зайлшгүй шаардлагатай субъектүүдийн заримаас дурдвал:

- Хүнд, онц хүнд, давтан гэмт хэрэг үйлдэж хорих ял эдлээд суллагдсан этгээд
- Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээд
- Архаг архичид
- Шашны үзэл номлолд итгэгчид
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн
- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд татан оруулагч этгээд
- Тодорхой оршин суух хаяггүй тэнэмэл хүмүүс
- Сургууль завсардсан, орон гэрээсээ дайжсан хүүхдүүд
- Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүс
- Мансууруулах бодис худалдаж борлуулдаг этгээд
- Бэлгийн цөөнхи гэх мэт.

⁷⁰ Ц.Дашзэвэг., Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. УБ. 2004. 52 дахь тал

⁷¹ Төрийн мэдээлэл. 2002. №1 <http://www.legalinfo.mn/law/details/18>

⁷² Ч. Баатар. Терроризм, аюулгүй байдал. УБ. 2006. 100 дахь тал

Терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулбал тодорхой үр дүнд хүрнэ. Тухайлбал:

1. Терроризмын аюул занал, түүний хор уршгийн талаар иргэдэд хийх ухуулга сурталчилгаа, танилцуулгыг системтэйгээр зохион байгуулж явуулах
2. Монгол Улсад ажлаар болон жуулчлалаар ирж, явж, дамжин өнгөрч буй гадаадын иргэдэд хатуу хяналт тогтоох, хил, гаалийн байгууллагуудын хяналт, шалгалтын техник хэрэгслийг сүүлийн үеийн шинжлэх ухааны ололтын хэмжээнд хүргэж тоноглох
3. Гадаад паспорт, иргэний үнэмлэх, визний нууцлалыг сайжруулах
4. Гэрээт болон хувийн хамгаалалтын албадын үйл ажиллагааг сайжруулах, эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх, цагдаагийн албадын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах
5. Аюулгүй байдлын хүрээнд улсын онц чухал объектын жагсаалтанд багтсан цагдаагийн хамгаалалтанд байдаг объектууд болон галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон хүчтэй хордуулах бодисын агуулах зэрэг харуул хамгаалалтын өндөр зохион байгуулалт шаардлагатай газарт техникийн сүүлийн үеийн ололтыг нэвтрүүлэх
6. Мэргэжлийн тусгай албадын үйл ажиллагааг уялдуулж, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг өндөр хэмжээнд тогтмол бэлэн байдалд байлгах
7. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын харуул хамгаалалтыг камерын системд бүрэн холбож, бүрэн төгс хяналтыг бий болгох гэх мэт

Терроризмын аюул заналаас урьдчилан сэргийлэх нэг чухал үндсэн арга бол иргэдийн сонор сэрэмж юм. Ер нь сонор сэрэмж сайтай газар гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх боломж өндөр, гэмт хэргийн илрүүлэлт ч сайтай байдаг.

Үүнийг хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд анхааралдаа авч сонор сэрэмжийг дээшлүүлэх, албаны бэлэн байдлыг өндөр түвшинд байлгах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт тогтмол хийж байх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх болно.

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОХОД НӨЛӨӨЛӨХ СЭТГЭЛ ЗҮЙ, ХҮМҮҮЖЛИЙН ОНЦЛОГ

Чагнаадоржийн Батчимэг
ХСИС-ийн ЕЭС-ийн гадаад хэлний тэнхимийн
ахлах багш, магистр, цагдаагийн ахмад

Б.Төмөрхуяг
ЭМШУИС-ийн гадаад хэлний тэнхимийн ахлах багш,
хэл шинжлэлийн ухааны доктор

Өнөө үед манай ирээдүй болсон хүүхэд багачууд, өсвөр насныхан, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэгт холбогдон, гэмт хэрэг үйлдэх нь гадаад орчны хүчин зүйлүүд, гэр бүлийн уур амьсгал, амжиргааны нөхцөл байдал, хамт олон, бичил бүлэглэлийн харш нөлөөлөл болон тэдний зан төлөв хувь хүний сэтгэл зүйн онцлогуудын харилцан үйлчлэл, нөлөөллөөс үүдэлтэй байгаа нь бодит амьдрал дээрх олон олон асуудал, судалгаанаас батлагдсаар байгаа.

Насанд хүрээгүйчүүдийн үе тэнгийнхэн насанд хүрсэн хүмүүсийн арга мэхэнд хялбархан автаж аар саар жижиг зүйлд хууртагдан гэмт хэрэгт холбогдож байгаа нь тэдэнд өөрийн гэсэн амьдрал асрах хүмүүжих орчин үгүй, үйл ажиллагааны чиглэл, амьдралын зорилго үгүй, ирээдүйд итгэх итгэл байхгүй, нийгмийн харилцааны үзэл бодол зэрэг нь хараахан төлөвшиж бий болоогүй хөнгөн хийсвэр хүүхдийн гэнэн цайлган сэтгэлээр хандах зэрэг онцлогуудтай ихэвчлэн холбоотой байдаг байна.

Насанд хүрээгүйчүүд гэмт хэрэгт холбогдох, уруу татагдах, гэмт хэрэг үйлдэгдэх зэрэг нь ихэвчилэн 11-15 насны биологийн утгаар бэлгийн бойжилт болон бусад бие организмын өөрчлөлт явагддаг үеийн шилжилтийн насныханд тохиолддог байна. Энэ л үеэс тэдний нийгэмшлийн үйл явц эхлэхийн хамт тэдний сэтгэл зүйн ухамсарт эргэлт гарч, зарим дотоод зөрчилдөөн эхэлдэг байна. Жишээ нь: Өэдний ааш зан өөрчлөгдөн хувирч уур уцаартай болж аливаа зүйлд гэнэн цайлган хандах нь ихэсдэг.

Шилжилтийн үед сэтгэл зүйн болоод бие бялдарын эрчимтэй өөрчлөлт явагддаг. Энэ үед насанд хүрээгүйчүүдтэй бүх тохиолдолд ухаалаг, болгоомжтой, хүлээцтэй харьцаж тэдний зан төлөвийн онцлогийг харгалзан тэдэнд амьдрал, үйл ажиллагааг нь зөв чиглүүлэх зөвлөгөө заавар хэрэгтэй болдог байна.

Насанд хүрээгүйчүүдийг гол анхаарах үед нь буюу шилжилтийн насанд нь эцэг эх, сургууль, анги хамт олны зөв уур амьсгал, таатай орчин маш чухал. Насанд хүрээгүйчүүд хувь хүнийхээ хувьд гэр бүл сургууль, хамт олон дотор зөв төлөвшил олж чадахгүй бол өөрийгөө зөв залж мэдэхгүйгээр нийгэмд ашигтай хүрээллээсээ дайжих, сургууль завсардах, элдэв хэрэг зөрчилд амархан өртөх, хараа хяналтгүй өөрөө өөртөө итгэх итгэлгүй, өөрөөр хэлбэл өөрийн биедээ эзэн болж чадахгүйд хүрдэг.

Ийм тохиолдолд өөрийг нь ойлгох, дасан зохицох зам нийлэх боломжтой гудамжны гэгдэх бүлгийн нөлөөнд өөрийн эрхгүй ордог байна. Ингэж амьдралд байр сууриа олох гэж тэмтчин явах үедээ өөрөө мэдэлгүй эрх зүйн зөрчил гаргах гэмт хэрэг үйлдэх зэргээр хууль бус үйлдэл хийж, ёс суртахууны гажуудалд орж, нөгөө л нийгмийн дунд нэрлэгдэх муу нэртэй насанд хүрээгүйчүүд өөртэйгээ адил орчин, үе тэнгийхнийгээ эрж олохыг хичээх, тэдний дунд өөрийгөө илэрхийлэх, үнэлэх, байр сууриа олохыг эрмэлзэх нь тэдний сэтгэл зүйн түгээмэл онцлог.

Сүүлийн үед сэтгэцийн гажигтай насанд хүрээгүй гэмт хэрэгтний тоо нэмэгдэх хандлага манай орны хувьд ажиглагдах болсон нь төрөлтийн болон янз бүрийн гэмтлийн улмаас, эцэг эхийн удамшил согтуурал, мансуурлын үед олдсоноос шалтгаалдаг байна. Ийм оюуны хомсдолтой насанд хүрээгүйчүүд нийгмийн амьдралын хэвийн нөхцөлд амархан дасан зохицох чадваргүй учир тэд туршлагатай архаг гэмт хэрэгтнүүдийн сөрөг нөлөөнд автан, улмаар гэмт үйлдэх дуулгавартай зарц нь болдог байна.

Насанд хүрээгүй хүүхдүүд ихэвчлэн амьдралын утга учир, орчны нөхцөл байдал, хүмүүжлийн зан байдал, харьцааны мөн чанарыг танин мэдэх хүсэлдээ хөтлөгдөн яваа үед нь эцэг эх, ойр дотны хүмүүс нь ойлгохгүй. Элдэв хориг саад тавих нь хүүхдийг гомдоох, цөхрөх цаашилбал гэр орноосоо дайжих хань хамсаатнаа эрэлхийлэхэд хүргэдэг. Нөгөө талаар насанд хүрээгүйчүүдийг нууцлаг үед хэтэрхий энхрийлэн бөөцийлөх нь эцсийн эцэст бие даах чадваргүй, сэтгэлийн тэнхээгүй, арчаагүй, дорой байдалд оруулдаг байна. Ийм хүүхэд сургууль хамт олны дотор өөрийнхөө энэ байдлыг мэдэрч сэтгэл санаагаар унах явдал ажиглагддаг. Насанд хүрээгүйчүүдийн шилжилтийн үеийн сэтгэл зүйн нууцлаг үед нь эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид тэдэнтэй болгоомжтой, зөв боловсон харьцаж, сургааль зөвөлгөө өгч байх нь зүйтэй.

2011 оны ОУ-ын болон төрийн бус байгууллагуудын хамтран явуулсан насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэг үйлдсэн шалтгааныг судалсан судалгаагаар хөвгүүдийн гэмт хэрэгт холбогдох эзлэх хувийн жин 90-95% байна.

Зарим тодорхой хугацаа хамарч хийсэн судалгаагаар насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн дунд охидын эзлэх хувь 10-12% байгаа нь судлаачдын анхаарлыг татаж байна. Судалгаанаас үзэхэд насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүд ихэвчлэн эрүүгийн гэмт хэргийн субъект наснаасаа өмнө эрх зүйн зөрчил гаргасан хулгай дээрмийн хэрэгт холбогдсон хүмүүс байна. 14-15 насны хүүхдүүд хулгайн хэрэгт зонхилон холбогдсон байхад 16-17 насныхан согтууруулах ундаа хэрэглэсний улмаас хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдсэн мөн авто хэрэгслийн хулгай хийхэд оролцсон байдаг нь илүү их байна.

Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн дунд ажиглагддаг түгээмэл онцлог бол тэдний ихэнхи нь сурлагаар хоцорсон байдаг байсан бол сүүлийн үеийн судалгааг харж хандах эцэг эхгүй тэнэмэл хүүхдүүд сургууль завсардсан хүүхдүүд байна. Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд дараах онцлог шинжүүд ажиглагддаг байна. Үүнд:

- Тэдний ёс суртахууны зан төлөвшлийн хувьд доголдолтой байдал нь амьдрал дээр нь байнга илэрч байдаг. Энэ нь хараал хэлэх, бусдыг доромжлох, хэнийг ч үл тоомсорлох, өмч хөрөнгийг эвдэж сүйтгэх зэрэг болно.
- Сургалт хүмүүжлийн болон албан газар, гэрээсээ оргон зайлах, тэнүүчлэн амьдрах.
- Хүчирхийлэх зан төлөвийн үйлдлүүд хийх, бүдүүлэг авирлах, өш хонзон авах, хорон муу санах.
- Мөрийтэй тоглоом тоглох, согтууруулах ундаа хэрэглэх, зан заншлыг үл тоомсорлох.
- Бэлгийн харьцаанд эрт орох, бэлгийн замбараагүй амьдралд дасах.
- Эцэг эх болон гэр бүлийн бусад гишүүдийг заналхийлэх, гэр бүл байнгын хэрүүлтэй байх, зөрчилтэй байдлын өдөөгч байх.
- Сахилга сайтай, сурлагын амжилтаар сайн хүүхдүүдэд дайсагнасан хандлага гаргах.
- Муу зүйлийг тусгах, сурч авахад хурдан түүнийгээ даруй хэрэгжүүлдэг гэх мэт болно.

Насанд хүрээгүйчүүдийн бие хүн сэтгэл зүйн онцлогийг судалж тогтоосноор тэднийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх оновчтой арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх боломжтой юм.

Íàñàíà ò¿ðýý¿¿é àýìò òýðýãòìéé ñýðäýé ¿¿éí ñöëíà íü ààðààò ¿íàñýí øëíæðýé ààéäààг байна.

-Íééãýì òàìò íëíí, ñòðàòóëü, àýð á¿é áóñàà ìð÷ëí áóðó ò¿ì¿ìëéí ¿àí òàðüòàà àìüàðàëüí í°òò°é ààéäëüà òëìààñ ñýðäýé¿¿éí ààðàìòàíà ìðñíí.

- Íàñàíä ò¿ðýý¿¿é àýìò òýðýãòýí íü ò¿¿ðàëéí ò°àæëëéí òàìàëéí ýðñàýèðýé ¿à øàò àíëîò °ñà°ð ¿àëéí ò°àæëëéí ¿à øàòàíà ààéäàà ò÷ðààñ ñýðäýé ñàíàíàíü òóàüà òíàðàíðä¿é àìàðòàí òóðëàààà òíàíðòíé í°òò°ëà áóé ààéäàé íü òìðèðìíæä¿é áóñàüà ñýðäýé ñàíàíàíü àíëí ýð¿¿é íýíàëéí òóàüà ò¿÷ðèðëéäýà òàðàëñ òýðòàëé °ñ òí¿¿í ñàíàààà, ìàðààíüà ¿ðèòà ýðè¿¿éäýà áóñààðàé àìàðòàí ¿°ð°ëàà°à.

- Àýð á¿é ñòðàòóëü ò¿¿ðàëéí ààéäóóëààà íàé¿ í°ò°à àíëí àìüàðàëüí áóñàà í°òò°é íü òààà¿é ààéñíü òëìààñ ò¿ì¿ìæëé ìóòàé

-Ýðèëéí òóàìñàð ñöé á°ã°ã ýð¿¿äëéí ýðòèëéí òýíæýý áóñàà ýðòèëéí òìðèëéíèòüà ¿°ð÷èò àýñýí òàíàëàà íü òíàòñíí.

-°ñ ñòòàðòóóí ìóòàé íëí íéèðýýð ò¿éýýí ¿°ãø°ðñíí òýí òýíæýýà òàèðàðààà¿é àíëí ýàä¿é ¿à òýéýà òàðààé òýéäýà, àðòèäàí ñíàòóòàð áóðòàé, áóñàüà àýýðýéòýí

oioooodaaa ieeoeei 'i÷ o'oi'ia oaed aailae oaaaaa, oioaeoaaa caiaeoeeyaa cyda adaioeioae ianaia ozdyayez÷z÷ eö aeia.

-^{ai'o} zeeenei oaeaadö ieeaiö iu aaeeae noöaaeo azoye÷ o'a'ei'o nneöoeae az adao, iadaeae oyiayo, oyiz÷eyö, ai, oöoanöae aieio cyda oöeeöednai onyeöy aeaaa.

Äyo dyda zeyäy aienii cideai iu ^{oönaeei} 'a'ö oöoiui dydaoy ozny nneöoeüa oiaaada ÷eeyiy.

-Ozizaeeyö ÷eyöe noöeaaiaaa naei ozöazaeä zsy yaa, aeenaiäo oiaaeaa eeyda

-Oadaa oyiaeöaz eö caaae aeäaa ^{oöeeä} oiaaeao ÷aaadaaz ozlyyn ya zeeee iu aaaä aaäe cödeöae äy cyda iioeioie aeia.

Äyo dyda zeeanyi ozöaei nyöyoei ^{oö÷eö} iu oaiöeei aon daei aiuaöae ozizaeeei oaaaz i'oöe aeaeaan znyeyö aeö a'a^o yaayy ozöazä iu ^{oönaeeä} oaeöaa ÷aaaä noe aeay aäeo ÷aaadaaz dyo o'a^o eäioy cai zeeei oöua oiaoiöaz aeäa.

Ianaia ozdyayaz ozöazä yaaaaa zä oyiaeeioy aienia ianaia ozöny ozizneei adaa iyöyia aiäöai aäöae äyo dyda zeyay aeia ay ayoyy dyayia ^{oöeei} änyy aiuaöae zee aeaeaaaiu ÷eeye cideai, eöay ziyöe, zsy aiaie oadaöai o'e^o a^o az eyiy aeaeai nyöyeyö eöyioae änyy iioeioöoae çdei oaeaa öieaiöie aeia. ianaia ozdyayaz oziznyyn äyo dyda ^{ç÷e} zeyäy ozöay aieio ieeäyia daö zsy aiaie dyayia azöeyäy oiaoiöia aäaa i'oöe oaeöaa i'e^o aeia.

Äy azeei ozizaeeei aöoö i'e^o

Äy az iu ianaia ozdyayaz ozizneei ozizaeee aiöaa÷ oiaaei ied i÷ei iu a'a^o öeäayöy i'e^o aeiaa zczae aeäaa. Eeyyn ay azeei ozizaeeei aöoö i'e^o iu oöaei ozöaei oöaei çai o'ö azöeyäy oiaoiöia iioaie i'e^o oy aieio iu ieeaiöie.

Äy÷ iaiäe ieeäyia yöy yö iu zöayy oiaaeöaz aeäezeyö iu ieeäyia zö ozöyayy oiö ödeä daö ziayn aienii aeia. Äy÷ oiaoiöie ay azä ^{oöni} ozöy ay aöoiöae ozizneei i÷eia çai o'aei aaöoaeüa aäaaaaa oiöeiae aeaaa.

Yiy iu ianaia ozdyayaz ozöaei nyöyeyz iioeia aaiu i'e^o i^on aieaaeeä daöoöae aeia. Ö÷e iu ianaia ozdyayaz ozöaei nyöyeyz yizy iädee aeaeöae öieaiöie.

Yöy yö iu adö÷ei aiaei dyöae öeäae äydyi çeaeai ay iyö ieeaei daö cideiaz çai aäe aäaaaaa aie ozöy iu eöy÷ey ozizeä aaaa aöoöae ozizaeeeä ööeäaeai aäa oiöeiae aiuaöae eöyoy oiöeiaeia. Ianaia ozdyayaz÷zäee äyo dyda zeyäy aöoö ozizaeeei dyäyöaz i'e^o eä^o aeia. Yнд:

Ä. Oadaa oyiaeöaz anöae oyiaeöaz aeaeaa iu ozöaeä ^{oö} iu aaäaa /öyayy iu iadaeae oyiayo ozizaeeei aiaieaiöie aönaa ozöy ianaia ozöy÷aei aöoö i'e^o aaäaa/

Ä. Ozöy dyo öeöednai oyiaeö oaeö, dyayia iei o'eeei öideaeie oiaoin çadeai ööaa aeaeaaä daüaö

Ä. Nyöy naiaiu ^{oö÷eö} ayjeö ieeaiö oöaaeöazayy ozöoy dyayy o'iae zä aizaada aeaeaaä oiaaa.

Ä. Oadaen dyöaeayy ozizaeeyö ozöaei yia iya aeaeä aeaaanü o'e^o daöo öeöay ozöy aeiaui aeäan zäzödy ^{oö} aieaeö

Ä. Yöy эх ^{oöna} ozöy aöoö aeöae aieio n çz aieii dyöeei oy dyayayy oiaöaa /öioaeö, öeäe öeö, adöai niaöoöaa ay iyö/

Ä. Öyxaeä aöan oiaaaae ozizaeeyöeei iöia dyo yaei dyäyayy oiaaöüa özöazä aäeioeä iu aaz çai zee azöeyäy aän i'e^o ei^o.

Ё. Хүүхдээр дамын худалдаа, хулгай хийлгэх, архи худалдан авхуулах, мөрийтэй тоглоом тоглуулах зэрэг нийгэмд харш үйлдлийг шууд хийлгэх./эрүүгийн хуулийн 114-р зүйлд заасан насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг үйлдхэд татан оролцуулж байгаа болно./

Ж. Насанд хүрээгүй хүүхдэд зөвшөөрөгдөөгүй видео хуурцаг, кино, номын агуулгыг буруугаар тусгах.

3. Удаан хугацаагаар сургууль завсардуулах хамт олноос нь хол хөндий байлгах зэрэг нь насанд хүрээгүйчүүдийг гэмт хэрэг үйлдэхэд шууд нөлөөлнө.

Íàñàíà ò¿äýýä¿é÷¿¿äëëä äýìò õýäýä ¿ëëäýäýýñ òäüä÷ëëäì ñýääëëëýò зарим í°òëëëã дурдвал:

Íàñàíà ò¿äýýä¿é äóðò ääää íàñíí ò¿¿äýä íü äëä ò¿íëë òäüäüä ò°ë°äðëð òàìäëëí àíòíí ¿ä íü ääää íàñíààñ íëëäýìðëä ýäëýò ¿ä íü äýä ä¿ëýýñ ýäëýäýä ä°ä°ä ýíý òäääòäàíä ò¿¿äýä ¿àí ääëäëüí òäüäüä °òëëí äýñýí òýëäýä íëëäíëòðíë äíëäíä.

Õýäýä ýíý ë ¿ää íëëäýìðëò íü äóäòóò òàìäëäàääë äíëäíë äýìò ¿àí ¿ëëëëí øëíä ýü ä¿äýëäýä ýäýëíý.

Íàñàíà ò¿äýýä¿é ò¿¿äýäüä äóñäàääë òäðëëòäò °òëëä°ò ëëýäðëëëýò äíëíäëëä äýä ä¿ë ñòääòóòëü òàìò íëíí ¿¿äýýñ ä¿äýëä¿¿ëä °ää°ñ ääðëääí ìäðòóòäàò, òàìòë òàäàò, òóëääë òëëò, ¿ìòëí ääëäòóòëäòäë ñ äóñ ä¿ëýäò ýñýýò ¿ýäýä íëëäýìä òäðä ¿ëëäëëä òëëòä¿é äëä ò¿í ò°ë°äðëò°ä í°ë°ëí°.

Íàñàíà ò¿äýýä¿é÷¿¿ä íëëäýìðëò ¿ëë ýääää ò¿¿íëë ñýääýòëëí ýìäýä °ä÷ëí íü ò¿íääýë ò÷äòóòäää ääëä äíëí. Ýíý òìòëíëäíëä ¿°ò°í äääð ñòäääí ò¿ì¿¿ä¿¿äýä÷ ò°äëëä¿é ýä¿¿é ýíä ñýääýë¿¿ëí ääää òýìäýäüä íýääýäëëëí ò°äðëä ä¿ëòýäýä ÷äääò ò¿¿ääëëí ñýääýë¿¿é÷, ò¿¿ääëëí ýì÷, ò¿¿ääëëí ñýääýòëëí ýìäýä ñäëäëüí íýääýäëëòì¿¿ääýë òàìòíü ääëëääääíü ìäíëòíí ÷òääë òì.

Íëëäýìä òäðä ¿ëëäýë òëëä äíë¿ìä¿é íàñàíà ò¿äýýä¿é÷¿¿äëëí ¿àðëì õýñýä íü ìðóíü ò°ääëëëí òìòäíäíëòíë òíñäíëòíë ääëäää ää ýíý íü ò°ä íýääýëëëí ñëñòäíëëí °ä÷ëí òäðòëíü äýìòäýýñ ¿¿ñýòýë ääëíä.

Ýääýýä ò¿¿ää¿¿äëëä íëëäýìð¿¿ëýò ¿¿é äóñ ¿òäðëëäàñ òäüä÷ëëäì ñýääëëëýò ääëë íü ñòäääëò ò¿ì¿¿äëë äíëíäíòíëü ääëäòóòëääüí òóñääë ò°ò°ëä°ò°ò òëëääýíý. Ì°í ¿¿é äóñ äóäòóò ¿àí ¿ëë ¿àñäò,äýëäëëí ò¿÷ëäðëëëýë, òóëääë äýýäýí, ääðëäàñ ñíäòóòäàò, ìäíòóòäòóòäò äíäëñ õýäýäýòëëä òäñëñ ¿ò¿¿äýä òäñëñ ääëäääí ääää òýìäýäüä òíñëòóòëäí õýäýäýò íü ¿¿éòýë.

Íàñàíà ò¿äýýä¿é ò¿¿ääëëä ¿°ä ò¿ì¿¿ä¿¿äýòýä òýäýìä òóòëü ¿¿ëí íýäëýäëëä ääääàñ íü ñëñòäíòýëäýýä ñäëäòóòëä íýä¿¿ëýò õýäýääýë ääëíä.

Ñòääëäààнд оролцогчидоос авсан санал асуулга: Õà íàñàíà ò¿äýýä¿é ò¿íëëä äýìò õýäýäò òäääí ìäðòóòäò äýìò õýääýýñ òäüä÷ëëäì ñäääëëëýòýä ýìä ääää òýìäýäüä ëë¿¿ ¿ä ä¿ìòýë äýä ¿¿äýä äý?

Ä. Õ¿¿ääëëí ñòääòóòëü ¿àñäàääàò í°òòë¿¿äëëä äðëëääò 56 /93%/

Ä.Íàñàíà ò¿äýýä¿é÷¿¿äëëä äýìò õýäýäò òäääí ìäíëòíòíä òäüä÷ëëäì ñýääëëëýò ò°ðëëëí õýäòóýë äíäëíäí õýäýä¿¿ëýò 59 /98.3%/

Ä.Õ¿¿ääëëí ÷°ë°ò òääëëä ¿°ä äíëíäñíí °íä°ä¿¿ëýò í°òò° äíëíäëëä ñëñòäíòýëäýýä äëë äíëäíò 48 /80%/

Ä.Ääëä¿äëýë ýäòóòëüä äóòäòóòäò ýäëëí ääää òýìäýäüä ¿°ä ¿ìòëíòíë ýä÷ëä¿¿ëýò 51 /85%/

Ä.Õ¿¿ääýä ýýòýë ääääää äíòñäüí ò°ðëëí äóñ ääëäòóòëääüä ò°ð°ñ äýìäëò 37 /61% зэргээр хариулт өгсөн байна.

ТУҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛ

Түншийн Мөнхчулуун

Гаалийн Ерөнхий Газрын дэргэдэх Бүрдүүлэлтийн
дараах шалгалтын гарзны дарга, хууль сахиулахын

Дэлхий дахиныг хамарсан даяаршлын өнөө үед хүн төрөлхтөний язгуур үнэт зүйл, улс үндэстний оршин тогтнохын нэг чухал үндэс, тусгаар тогтнолын баталгаа бол тухайн улс үндэстний “Соёл”-ын үнэт зүйл юм.

Иймд улс үндэстнүүдийн хувьд нэг талаас дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн ижилсэх, нөгөө талаас, өөрийн үндэсний өвөрмөц онцлог, ёс заншил, өв уламжлал, соёлоо хадгалан үлдэх нь нэн чухал зорилго болж байгаа бөгөөд энэ зорилгыг ханган биелүүлэхэд соёлын өвийг хамгаалах асуудал голлох байр суурийг эзэлнэ.

Монгол Улс 1990 онд “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай” Конвенцид, 1991 онд “Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” Конвенцид тус тус нэгдэн орсон.

Дээрх Конвенц болон Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын үнэт зүйл тэр дундаа археологийн болон палеонтологийн олдворыг хамгаалах асуудлыг зохицуулсан байдаг.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах асуудал:

Түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах, түр солилцох асуудлыг журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Хувийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг бусдад худалдах нөхцөлд өмчлөгчтэй тохиролцон Төр худалдаж авна. Энэ талаар маргаан гарсан тохиолдолд шүүх байгууллагаар шийдвэрлүүлдэг.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ гадаадын иргэн, харьяалалгүй хүнд шилжүүлэхийг хориглосон байдаг.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх:

Түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг дараах байдлаар зохицуулсан байдаг. Үүнд:

Төрийн өмчлөлд байгаа түүх соёлын **хосгүй үнэт болон үнэт** дурсгалт зүйлийг гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцлийг бүрдүүлсний үндсэн дээр соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага /ТЗТБ/-ын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлж болно. Шаардлагатай бол энэ хугацааг сунгаж болно.

Хувийн өмчлөлд байгаа түүх соёлын **дурсгалт зүйлийг** эргүүлж авчрах нөхцөлтэйгээр судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах, өмчлөгч өөрөө язгуур ахуйн хэрэглээний зориулалтаар соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн ТЗТБ-ын зөвшөөрөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлж болно.

Түүх соёлын **үнэт дурсгалт** зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаагаар гадаадад гаргаж болно.

“УЛС, ОРОН НУТГИЙН МУЗЕЙН САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ” ЗГ-ын 2007.11.7-ны №287 тогтоолоор Үндэсний түүхийн төв музейгээс алдагдсан үзмэр, эд өлгийн зүйлийг эрэн сурвалжлах, түүх, соёлын ердийн дурсгалт зүйлийг улсын хилээр гаргахгүй байхаар заасан.

Хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын дурсгалт зүйл, улсын хилээр гаргасан түүх соёлын дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болгон зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн ТЗТБ болон цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулна.

Шүүхийн шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн бол хил нэвтрэх үед гаалийн байгууллагад хураагдсан, гаргасан түүх соёлын дурсгалт зүйлийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн ТЗТБ төрөл зүйлээр нь ялгаж, зохих байгууллагын сан хөмрөгт шилжүүлж хадгална.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх тохиолдолд “Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам”-ын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Онцлог барааг гаалийн хилээр нэвтрүүлэхдээ мэдүүлэгч тухайн асуудал хариуцсан яам, засгийн газрын агентлагаас холбогдох тодорхойлолт авсан байна. Жишээлбэл: Палеонтологийн болон археологийн олдворын дээж, сорьц – **Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны тодорхойлолтыг** авна.

Олдворыг шалгахдаа Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санд байгаа олдвортой холбоотой мэдээллийг тусгай пайзтай харьцуулж шалгах шаардлагатай.

Олдворын **тусгай пайзтай** дээр дараах мэдээллүүд багтсан байна:

- Олдворын нэр
- Олсон цаг хугацаа
- Олдворын холбогдох он цаг
- Олдворын хэмжээ
- Олдворын байршил
- Олдворын жинг бичсэн байх ёстой.

Ж: Хоёр үлэг гүрвэлийн зууралдсан хэлхээ яс

/Хожуу цэрдийн галав, 70 гаруй сая жилийн тэртээх/

Хаана хадгалагдаж буй: Палеонтологийн музей

Шинж байдал: Олдвор 1500х1500 см

Олдсон цаг хугацаа: 1970 он

**ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ УЛСЫН
ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРСАН
ЗӨРЧИЛ:**

2012.11.01-ний өдөр ЗҮГГ-аас ирүүлсэн эртний амьтны соёо байж болзошгүй /5 ширхэг/ эд зүйлийг ШУА-ийн Палеонтологийн төвийн лабораториор шинжлүүлэхэд уг бараа нь 30 гаруй сая жилийн өмнө оршиж байсан өвсөн идэшт хөхтөн амьтаны бага арааны тал, нэг их араа, хоёр соёо, шүдний паалангийн хэлтэрхий зэрэг 5 хэсгээс бүрдэх бөгөөд энэ нь палеонтологийн олдворт хамаарах болохыг тодорхойлсон байна.



2013-08-05-ны өдөр БУГГ-аас ирүүлсэн шашны эд зүйл болох **“1ш хос цан”** гэх барааг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох Мэргэжлийн зөвлөл”-ийн гишүүд биетээр үзэж нягтлан шалгаад **түүх, соёлын ердийн дурсгалт зүйлд** хамаарахыг тодорхойлсон байна.



2013-04-08-ны өдөр ЗҮГГ-аас ирүүлсэн **“5 ширхэг баринтагтай судрууд, 3 ширхэг гуулин шанага, эмээл 3 ширхэг”** зэрэг эд зүйлийг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох Мэргэжлийн зөвлөл”-ийн гишүүд биетээр үзэж нягтлан шалгахад **5 ширхэг баринтагт хадгалсан 9 ширхэг ном нь түүх соёлын үнэт зүйлд, 3 ширхэг гуулин шанага, 3 ширхэг эмээл, дөрөө, гөлөмийн хамт буй эд зүйлийг түүх, соёлын дурсгалт зүйл болохыг тус тус тодорхойлсон байна.**

- Санжид молон /Алтаар бичсэн/ 17хуудас /үнэт/

- Майдарын ерөөл /Алтаар бичсэн/ 7 хуудас /үнэт/
- Үл хөдлөгчийн үндсэн таринийг унших арга /үнэт/ алтаар бичсэн. 3 хуудас
- Санжид молон /үнэт/ алтаар бичсэн. 9 хуудас
- “9 эрдэнээр бичсэн Доржжодва судар” /үнэт/ 54 хуудас



ЗҮГГ-аас 04 сарын 02-ны өдөр МШХТШ-0006742 тоот баримтаар ирүүлсэн 2 ширхэг мөнгөн аягыг БСШУЯ-ны дэргэдэх “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох Мэргэжлийн зөвлөл”-ийн гишүүд биетээр үзэж нягтлан шалгахад “Бор эрэн өнгөтэй, яргай модны үндсээр хийсэн **том мөнгөн аяга нь түүх, соёлын үнэт дурсгалт зүйлд**; шар өнгөтэй, жижгэвтэр мөнгөн аяга нь түүх, **соёлын ердийн дурсгалт зүйлд** тус тус хамаарахыг тодорхойлсон байна.



ЗҮГГ-ын ГУБ-ийн саатуулж ирүүлсэн эд зүйл нь БСШУЯ-ны “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тодорхойлох МЗ”-ийн гишүүд биетээр үзэж нягтлан шалгахад

- Хос хутгатай, ясан савхтай, хэт бэлтэй бэлэн дээрээ 2 хятад ханз үсэгтэй, сийлбэртэй, ясан бөгжтэй, суман модон



хуй иштэй иж бүрэн хутга- нь түүх соёлын **үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд**, Эмэгтэй хүний үсний мөнгөн даруулга, цуглуулж хэлхсэн том, жижиг бөөрөнхий 155ш бүтэн шүр, 5ш тал хагархай шүр нь хагас үнэт чулуу бөгөөд түүх, соёлын **ердийн дурсгалт зүйл** болохыг тогтоожээ. 2013.03.27-ны өдөр ЗҮГГ-аас ирүүлсэн 39 ширхэг баринтагт 202 судар, 9 түүвэр судруудыг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох Мэргэжлийн зөвлөл”-ийн гишүүд биетээр үзэж нягтлан шалгахад 27 дугаар баринтагт буй “**Очироор огтлогч**” хэмээх судар нь түүх, соёлын **үнэт дурсгалт зүйлд** хамаарахыг, 25 баринтагт буй 9 түүвэр, 94 судрыг түүх, соёлын ердийн дурсгалт зүйлд хамаарахыг тогтоожээ.

ДҮГНЭЛТ

Сүүлийн үед гарч буй түүх соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар худалдах, наймаалахтай холбоотой гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь нэг талаас түүх соёлын дурсгалт зүйлээр бизнес хийгч этгээдүүдийн ашиг олох сонирхол ихэссэн, нөгөө талаас түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалахтай холбоотой эрх зүйн орчин сул байгаатай холбоотой байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн дагуу түүх соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар худалдах, наймаалах, хил нэвтрүүлэх олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ ч манай улсад бий болсон байна. Энэ нь мөн л дээр дурьдсан 2 шалтгаантай шууд холбоотой юм.

Иймд түүх соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар худалдах наймаалах гэмт хэрэгтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийг бууруулахад дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, түүх соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар худалдах, наймаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, оновчтой болгох;
2. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээллийн солилцоог сайжруулах;
3. Мэргэжлийн болон судалгаа шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах, ажлын уялдааг сайжруулах, хаана ямар төрлийн малтлага хийж байгааг тухай бүр бүртгэдэг механизмыг боловсронгуй болгох;
4. Түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэлийг сайжруулах, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах талаар ард иргэд, олон нийтэд ухуулга таниулга, сурталчилгаа хийх.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ

Ганбаатарын Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЦЭЗТ-ийн
багш, докторант, цагдаагийн ахмад

Монголчууд бид эрт дээр үеэс уламжлагдсан нүүдэлчдийн соёл иргэншлийн өвөрмөц хэв шинжийг агуулсан түүх соёлын ариун нандин өв бүхий ард түмэн юм.

Бидний өвөг дээдэс оюуны болон эдийн соёлын тэрхүү гайхамшигт зүйлсийг бүтээн бий болгох, өв залгамжлан үлдээхийн зэрэгцээ хайрлан хамгаалж ирсэн баялаг түүхтэй билээ.

Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүх нь Монгол улсын төрт ёсны түүхтэй салшгүй холбоотой байдаг.

Ардын хувьсгал хүртэлх үеийн эрүүгийн хууль тогтоомжуудад хамаарах Их засаг хууль /1206/, Юань гүрний нэвтэрхий хууль /1260-1294/, Алтан хааны цаазын бичиг /1507-1582/, Халх цааз эрхэмжийн 18 хууль, Монгол Ойрадын хууль /1640/, Халх журам хууль/1709-1796/, Зарилгаар тогтоосон монгол улсын хууль зэрэгт түүх соёлын дурсгалт зүйлтэй холбоотой хэрэг үйлдлийн талаар нарийвчлан хуульчлан тогтоосон зүйл, заалт байхгүй бөгөөд ихэвчлэн уул ус, мод ургамал, ан амьтан зэрэг байгаль хамгаалахад чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан байна.

1918 оны Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйн бичгийн Жаран тав дугаар дэвтрийн “Янз бүрийн гэмт хэрэг” гэсэн бүлэгт булшны чулуу, тэмдэг чулуу,

дурсгалт хөшөө зэргийг эвдэж сүйтгэх, хүний бичсэн зүйлс зурсан зургийг гэмтээж сүйтгэсэн бол 80 ташуур занчина.⁷³ гэж заасан нь түүх соёлын дурсгалт зүйлд халдсан гэмт хэргийн талаарх анхны зохицуулалт болжээ.

Мөн уг бүлэгт “Газарт булсан хуучны багаж, хонх, хэлтэрэг, бичиг баримт, тамга зэргийг олсон этгээд 30 хоногийн дотор мэдэгдээгүй бол 80 ташуур занчих”⁷⁴-аар зааж тайлбар хэсэгт газар булсан юмны эзэн нь олохгүй бол ухаж гаргасан этгээдийг эзэмшигч гэж үзээд олдсон эд зүйлсийн талаар холбогдох газарт 30 хоногийн дотор мэдэгдэх шаардлагатай болохыг дурьджээ.

Монгол улсын засгийн газрын 1924 оны 9 сарын 5-ны өдрийн хурлаар “Хуучны зүйлийг сахин хамгаалах тухай дүрэм” –ийг батлан гаргасан ба 10 зүйл бүхий энэхүү дүрэмд хуучны дурсгалд хамаарах зүйлүүдийг тодорхойлон зааж, тэдгээрийг эрж хайх, ухаж авах, судлан шинжлэх, хил нэвтэрүүлэх зэрэгт зөвшөөрөл өгөх, харгалзан хянах талаарх зохицуулалтыг тусгажээ.

Уг дүрмийн нэгдүгээр зүйлд “Монгол улсын хязгаар дотор буй бүхий хуучны дурсгал болох зүйл цөм Монгол улсын өөрийн хөрөнгө болох тул Монгол улсын Ардын гэгээрүүлэх Яамны Судар бичгийн хүрээлэнгийн мэдэл байна.” Аравдугаар дугаар зүйлд “Энэхүү дүрмийг зөрчигсөд буй аваас шүүх цаазын зохих зүй ёсоор яллан шийтгэвэл зохино.”⁷⁵ хэмээжээ.

1926 оны БНМАУ-ын Шүүх Цаазын бичиг: Нийт 31 бүлэг, 227 зүйлтэй энэ шүүх цаазын бичиг нь Ардын хувьсгалын жилүүдэд дагаж мөрдөж байсан анхны төрөлжсөн “Эрүүгийн хууль” бөгөөд шүүх цаазын бичгийн тусгай ангийн 15-р бүлэг. Ард олны ашиг, хөрөнгийг хамгаалах тухай хууль дүрмийг зөрчих нь. 114-р зүйлд “Эртний цагаас үлдсэн хуучны ба урлаж үйлдсэн дурсгал болох онц зүйлүүдийг сахин хамгаалах дүрэм зөрчигсдийг 1 жил хүртэл гяндан хорино.”⁷⁶ гэж заажээ.

Энэ нь хуучны дурсгалт зүйлтэй холбоотой харилцааг зохицуулж буй дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд шүүх цаазын дагуу ял оногдуулахаар хуульчлан заасан харилцан уялдаа холбоо бүхий оновчтой хууль байжээ.

1929 оны БНМАУ-ын Шүүх Цаазын бичиг: Засгийн газрын 30 дугаар хуралдаанаар батлагдсан 30 бүлэг 227 зүйл бүхий энэхүү шүүх цаазын бичгийн тусгай ангийн 14-р бүлэг. Ард олны ашиг, хөрөнгийг хамгаалах тухай хууль дүрмийг зөрчих нь. 118-р зүйлд “Эртний цагаас үлдсэн хуучны ба урлаж үйлдсэн дурсгал болох онц зүйлүүдийг сахин хамгаалах тухай дүрмийг зөрчигсдийг 600 төгрөг хүртэл торговол зохимой.”⁷⁷ гэсэн нь дүрэм зөрчигсдөд оногдуулах ялын төрөл хэмжээг хөнгөрүүлсэн /доошлуулсан/ боловч хэм хэмжээ нь хэлбэр, агуулгын хувьд өөрчлөгдөөгүй байна.

Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 1941 оны 11 сарын 13-ны өдрийн 79 дүгээр хурлаар “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг дахин шинэчлэн баталсан бөгөөд 1926 оны дүрмийн адил хуучны дурсгалд хамаарах зүйлүүдийг тодорхойлон зааж, тэдгээрийг эрж хайх, ухаж авах, судлан шинжлэх, хил нэвтэрүүлэх зэрэгт зөвшөөрөл өгөх, хяналт тавих талаарх зохицуулалтыг тусгаж, зарим үл хөдлөх дурсгалуудыг зэрэглэн бүртгэсэн боловч энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх заалтыг хасчээ.

⁷³ С.Жанцан, Б.Баярсайхан нар. “Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/ УБ хот. 2011 он. 73 дахь тал

⁷⁴ С.Жанцан, Б.Баярсайхан нар. “Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/ УБ хот. 2011 он. 71 дэх тал

⁷⁵ “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл” 2 дугаар боть. 492 дахь тал

⁷⁶ Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” 1998 он. 22 дахь тал

⁷⁷ Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ., 1998 он. 55 дахь тал

1934 оны БНМАУ-ын Шүүх Цаазын бичиг: Өмнөх шүүх цаазын бичгийн “дутагдлууд”-ыг засч өөрчлөн гаргасан энэ шүүх цаазын бичгийн тусгай ангийн 8-р бүлэг “Ардын эрүүл мэнд ба олон нийтийн амгалан байдал хийгээд хэв журам сахин хамгаалах тухай хууль дүрмийг зөрчих нь” 150-р зүйл “Данслан бүртгэх буюу улсын чухал зүйлүүдийг агуулан хадгалах газруудад шилжүүлэн хадгалуулбал зохих уран сайхны, хуучны дурсгал бүхий зүйлүүд хийгээд цуглуулан хураасан зүйлийг нуун дарагдуулсан бол 300 төгрөг хүртэл торгож уг зүйлийг хураавал зохилтой.”⁷⁸ хэмээсэн нь өмнөх Шүүх цаазын бичгүүдэд тусгагдсан үзэл санаа огт байхгүй болж хуучны дурсгал бүхий зүйлүүдийг нуун дарагдуулсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Энэ нь нэг талаас ард иргэдийн гар дээр байгаа хуучны дурсгалт зүйлүүдийг музей, номын сан зэрэг газруудад төвлөрүүлэх, хадгалах байдлаар төрийн хамгаалалтанд авч буй явдал мөн боловч нөгөө талаас иргэдийн өмчлөх эрхэд зохисгүй байдлаар халдаж, хуучны дурсгалт зүйлсийг хамгаалах асуудалд өрөөсгөл, явцуу байдлаар хандсан хуулийн зохицуулалт байжээ.

1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль: Монгол улс шинэ Үндсэн хуулиа баталсантай холбогдуулан 1942 оны 1 сарын 17-ний өдөр Улсын бага хурлаар Монгол улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа “БНМАУ-ын Эрүүгийн хууль”-ийг батлан гаргажээ. Уг хуулийн тусгай ангийн “Ардын эрүүл мэнд ба олон нийтийн амгалан байдал хийгээд хэв журам сахиж хамгаалах тухай хууль дүрмийг зөрчсөн гэмт хэргүүд” 9-р бүлгийн 187-р зүйлд “...Данслан бүртгэх буюу улсын чухал зүйлүүдийг агуулах, хадгалах газруудад шилжүүлэн хадгалуулбал зохих уран сайхны ба хуучин дурсгал бүхий зүйлүүд буюу цугларуулан хураасан үзэсгэлэнгийн зүйлийг нуун дарагдуулсан байвал 500 төгрөг хүртэл торгож уул зүйлүүдийг хураавал зохино...”⁷⁹ гэж хуульчилсан нь 1934 оны Шүүх цаазын бичигт заасан хуулийн хэм хэмжээ санкцын хувьд нэмэгдсэнээс өөрөөр өөрчлөгдөөгүй байна.

1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль: Энэ хуульд урлагийн бүтээл, онц үнэ бүхий буюу ховор зүйлийг хууль бусаар хилээр гаргасан, соёлын дурсгалт ба улсын хамгаалалт бүхий байгалийн зүйлүүдийг санаатайгаар устгасан, эвдсэн гэмтээсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилан заасан нь түүх соёлын дурсгалт зүйлсийг эрүүгийн хуулиар хамгаалах асуудалд багагүй ач холбогдол өгч, эрх зүйн зохицуулалтыг шинэ түвшинд гаргаж ирсэн болох нь харагдаж байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 1-р бүлэг. 2.Төрийн эсрэг бусад гэмт хэргүүд. 56-р зүйлд “Эд хэрэглэлийг хууль бусаар хил нэвтэрүүлэх.” /контрабанд/

А. Элдэв бараа материал бусад үнэт зүйлийг тусгай саванд нуун далдлах, баримт бичиг засамжлах буюу залилан мэхлэх аргаар гаалийн үзлэгээс нуун далдалж, БНМАУ-ын хилээр нэвтрүүлбэл 2 жил хүртэл хугацаагаар хорьж, нуун далдалсан бараа материал, үнэт зүйлүүдийг хураана.

Б. Эд хэрэглэлийг хууль бусаар хил нэвтрүүлэх явдлыг их хэмжээгээр үйлдэх буюу байнга амьдрал болгох эсхүл зохион байгуулалттай хэсэг бүлэг хүмүүс үйлдэх, түүнчлэн албан тушаалын хүмүүс албан тушаалынхаа байдлыг ашиглан үйлдэх, эсхүл хууль бусаар хил нэвтрүүлж байгаа зүйлүүд нь валютын үнэт зүйл, буу зэвсэг, байлдааны хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх буюу ухаан мэдрэл алдуулах, хордуулах бодис, түүнчлэн урлагийн бүтээл, онц үнэ бүхий буюу ховор зүйлийг гадагш гаргаж байгаа бол уг нутгаас зайлуулах буюу зайлуулахгүй 3-7 жил хүртэл хугацаагаар хорьж хөрөнгийг хураана.⁸⁰ гэжээ.

⁷⁸ Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ., 1998 он. 97 дахь тал

⁷⁹ Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ., 1998 он. 141 дэх тал

⁸⁰ Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ.,1998 он. 170 дахь тал

Контрабандын гэмт хэрэгт тухайн үеийн эрдэмтэн судлаачид онолын тайлбар өгч байсан. Тухайлбал: Доктор, профессор Г.Совд дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

1. Эд хэрэглэлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг нь бараа таваарыг улсын хил хязгаар нэвтрүүлэх талаар тогтоосон журмыг зөрчиж, гадаад худалдааны онц эрхийн ашиг сонирхолд халддаг.

2. Контрабандын гэмт хэргийн халдах зүйл нь улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж байгаа бүх төрлийн таваар, үнэт зүйл байж болох боловч тэр нь хуульд заасан бусад шинж тэмдгүүдтэй байж гэмээж нь конторбанд болдог.

3. Контрабандын гэмт хэргийн гол шинж нь бараа таваарыг хууль бусаар хил нэвтрүүлэхдээ гаалийн үзлэгээс нуун далдлах үйлдэл бөгөөд энэ нь:

А. Тусгай саванд нуун далдлах

Б. Гаалийн болон бусад баримт бичгийг хуурамчаар ашиглах

В. Их хэмжээний бараа таваар хил нэвтрүүлэх

Г. Зохион байгуулалттай хэсэг бүлэг хүмүүс үйлдэх

Д. Албан тушаалын байдлаа ашиглан үйлдэх

Е. Контрабандыг амьдрал болгон эрхлэх

Ж. Валютын үнэт зүйл, буу зэвсэг, байлдааны хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх буюу ухаан мэдрэл алдуулж хордуулах бодис

3. Урлагийн бүтээл буюу онц үнэ бүхий буюу ховор зүйл байна гэж хуульд онцлон заасан шинжүүдтэй байна.

4. Контрабандын эд зүйлийг нуун далдлах гэдэг нь гэм буруутай этгээд хууль бусаар хил нэвтрүүлэхээр авч яваа зүйлээ тусгай бэлтгэсэн саванд хийх, эсхүл ердийн савыг эд зүйл нуун далдлах зүйл болгон ашиглах, тээврийн хэрэгслийн элдэв сав, эд ангийг ашиглах зэрэг олон хэлбэртэй байж болно.

5. Баримт бичиг засамжлах буюу залилан мэхлэх гэдэг нь авч яваа зүйлээ гаалийн үзлэгт оруулахгүй байх зорилгоор зохиомол бичиг баримт үйлдэх буюу эсхүл бараа хил нэвтрүүлэх эрх олгосон буюу гаалийн татвараас хөнгөлсөн бичиг баримтыг засварлан ашиглах үйлдэл юм. Хил нэвтэрч байгаа этгээд гаалийн шаардах хуудсанд авч яваа эд зүйлийнхээ тоо чанарыг буруу бичсэн боловч авч яваа бараа таваараа үзлэгээс нуун далдлах, залилан мэхлэх, баримт бичиг засах арга хэрэглээгүй бол контрабанд гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй.

6. Их хэмжээний эд таваар гэдгийг авч явсан зүйлийн үнийн байдлаас гадна түүний аж ахуйн зорилго, улсын гадаад худалдааны гүйлгээнд эзлэх ач холбогдолтой харьцуулан үзэж хэрэг бүрийн онцлогийг харгалзан шийдвэрлэх ёстой.

7. Контрабандыг амьдрал болгон эрхлэх гэдэг бол бараа таваарыг үргэлжилсэн байдлаар олон дахин хил нэвтрүүлэх, үүгээрээ амьдралынхаа гол хэрэгсэл болгосон байх 2 шинжийн нийлбэрээр авч үзэх ёстой.

8. Контрабандыг зохион байгуулалттай хэсэг бүлэг хүмүүс үйлдэх гэдэг нь:

А. Гэмт үйлдэлд 2 буюу түүнээс дээш хүн санаатай оролцсон байх,

Б. Тэд нэр контрабанд хийхээр урьдчилан үгссэн байх 2 шинжийн хослол бүрдсэн нөхцөл байдлыг хэлнэ.

Хамтран үйлдсэн хүмүүс нь шууд хамтран гүйцэтгэсэн буюу эсхүл нэг нь контрабанд хийх бараа таваарыг олдог, нөгөө нь хил давуулж өгдөг, 3 дахь нь хилийн чандад борлуулдаг гэх мэтээр ажил үүргээ хувиарласан, хамтран оролцогчид ч байж болно.

9. Албан тушаалтан хүн өөрийн албан тушаалын байдлыг ашиглаж контрабанд үйлдэх гэдэгт гаалийн үзлэгээс чөлөөлөх эрх олгосныг далимдуулсан буюу эсхүл гаалийн хяналт шалгалт хийх эрх бүхий хүмүүс хамаарна.

10. Валютын үнэт зүйл гэдэг нь БНМАУ-ын болон гадаадын мөнгөн тэмдэгт, чек, алт, мөнгө, үнэт чулуу зэрэг зүйлүүд хамаарна.

11. буу зэвсэг, байлдааны хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх буюу ухаан мэдрэл алдуулж хордуулах бодис хилээр нэвтрүүлэх нь түүний тоо, хил нэвтрүүлсэн аргаас шалтгаалахгүйгээр гэмт үйлдэл болдог.

12. Контрабандын гэмт хэргийн бүрдэл нь бараа материалыг хууль бусаар хил нэвтрүүлэхээр хил дээр буюу байцаан шалгах газарт ирүүлснээр төгсдөг. Контрабанд хийх зорилгоор бараа материалыг худалдан авсан, тусгай саванд хийсэн явдлыг энэ хэрэгт бэлтгэсэн буюу завдснаар хариуцлага хүлээлгэнэ.

13. Урлагийн бүтээл буюу онц үнэ бүхий ховор зүйл гэдэгт нийтийн өргөн хэрэгцээнд зориулаагүй урлагийн төрөл бүрийн бүтээлүүд, түүх соёлын дурсгал бүхий зүйлүүд, дэлхийд ховордсон ан амьтан, олзвор зэрэг эд зүйлүүд хамаарна.

14. Контрабанд үйлдэх гэмт хэрэг нь гэм буруугийн шууд санаатай хэлбэртэй байх бөгөөд чухам ямар зорилго сэдэлтэй байсан нь хэргийн зүйлчлэн ангилахад нөлөөлөх учир холбогдол байдаггүй. Гэвч энэ асуудлыг тодруулах нь эрүүгийн ялыг оногдуулахад харгалзан үзэх нөхцөл байдал болдог.⁸¹ гэжээ.

Мөн хуулийн тусгай ангийн “Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд” гэсэн 10-р бүлгийн 189-р зүйлд “Соёлын дурсгалт ба хамгаалалт бүхий байгалийн зүйлүүдийг санаатайгаар устгах, эвдэх, гэмтээх” гэмт хэргийг заахдаа “...Соёлын дурсгалт ба улсын хамгаалалт бүхий байгалийн зүйлүүдийг санаатайгаар устгасан, эвдсэн, гэмтээсэн байвал 1 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 500 төгрөг хүртэл торгоно...”⁸² гэсэн байна.

1. Соёлын дурсгалт болон улсын хамгаалалтанд бүхий байгалийн зүйлүүдийн жагсаалтыг БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн тогтоолоор баталдаг. Үүнд:

БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа шинжлэх ухаан, түүх, соёлын ач холбогдолтой буюу уран барилга, хөшөө дурсгал, уран баримал, зургийн хуучны судлалын малталт буюу олдвор, эртний болон орчин үеийн ард түмний амьдрал, түүхт үйл явдалтай хобогдолтой газар, байгууламж зэрэг түүх дурсгалын зүйлүүд хамаарагдана.

2. Байгалийн зүйлүүдэд БНМАУ-ын хууль тогтоомжоор хамгаалсан байгаль орчин, сонин гойд байгалийн цогцолбор, физик газар зүйн үзэсгэлэнт орчин, шинжлэх ухааны болон соёл танин мэдэхүйн ач холбогдолтой газар ургамал зэрэг орно.

3. Соёлын дурсгалт ба хамгаалалт бүхий байгалийн зүйлүүдийг санаатайгаар устгах, эвдэх, гэмтээх гэдэг нь уг зүйлүүд өөрийн соёл уран сайхан, уран барилга, хуучны судлалын болон түүхийн үнэ цэнг үгүй болгох буюу тэр чанар нь буурч багассныг хамруулан ойлгоно.

4. Соёлын дурсгалт, байгалийн зүйлүүдийг устгасан, эвдсэн, гэмтээсэн арга нь янз бүр байх боловч хэргийг зүйлчлэн ангилахад нөлөөлөх ач холбогдол байдаггүй.

5. Энэ гэмт хэргийн субъектив талын сэдэлт нь танхайрсан шунахайрсан зэрэг янз бүр байж болно. Танхайрлын явцад энэ зүйлд заасан хор уршиг бий болсон тохиолдолд Эрүүгийн хуулийн 169-р зүйлийн зохих ангитай давхардуулан нийлмэл хэрэгт хариуцлага хүлээлгэнэ.

6. Энэ хэргийн субъект 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд хэн ч байж болно. Хэрэв уг хэргийг албан тушаалтан эрх хэмжээгээ урвуулсан буюу хэтрүүлсэн, албан үүргээ үл биелүүлсэн нөхцөлд үйлдсэн бол албан тушаалын гэмт хэргийн аль тохирох зүйл ангийг давхар хэрэглэж хариуцлага хүлээлгэнэ.

⁸¹ Г.Совд. “БНМАУ-ын эрүүгийн хуулийн тайлбар” УБ хот.1982 он. 139-141 дэх талууд

⁸² Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ., 1998 он. 199 дэх тал

7. Хэрэв энэ зүйлд заасан гэмт хэргийг болгоомжгүй хэлбэрээр үйлдсэн бол тодорхой нөхцлийг харгалзан Эрүүгийн хуулийн 66-р зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.⁸³ гэж шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд тайлбарлажээ.

1986 оны БНМАУ-ын шинэчлэн найруулсан эрүүгийн хууль: БНМАУ-ын Ардын Тэргүүлэгчдийн 1986 оны 12 сарын 5-ны өдрийн 217 дугаар зарлигаар 1961 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж, 1987 оны 7 сарын 1-нээс мөрдөж эхэлсэн энэ хуулийн Төрийн эсрэг бусад гэмт хэргийн бүлэг, 74 дүгээр зүйл “Контробанд хийх”-д:

1. Гаалийн болон бусад баримт бичиг засварлах буюу гаалийн үзлэгээс тусгайлан нуун далдлах замаар бараа, үслэг ангийн үнэт арьс, бусад зүйлийг хууль бусаар БНМАУ-ын хил нэвтэрүүлсэн бол контробандын бараа, бусад үнэт зүйлийг хурааж, 3 жил хүртэлх хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.
2. Контробандыг их хэмжээтэй буюу давтан эсхүл зохион байгуулалттай бүлэг этгээд эсхүл албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг ашиглаж хийсэн, түүнчлэн буу зэвсэг, байлдааны хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, ухаан мэдрэл алдуулах, хордуулах болон мансууруулах бодис, валютын үнэт зүйлийг хууль бусаар БНМАУ-ын хил нэвтэрүүлсэн бол контробандын бараа, бусад үнэт зүйлийг хурааж, нутаг заах буюу заахгүйгээр, эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хоёроос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁸⁴ гэж хуульчилжээ.

Тус эрүүгийн хуулийн “Байгаль орчин түүний баялгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг” гэсэн 7-р бүлгийн 183-р зүйлд /Байгалийн объектыг санаатай устгах гэмтээх/”... Улсын хамгаалалтанд байгаа байгалийн объектыг санаатай устгасан, эвдсэн, гэмтээсэн бол 1 жил 6 сар хүртэлх хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.⁸⁵ гэсэн байна.

Энэ гэмт хэргийн объект нь улсын хамгаалалтанд байгаа байгалийн объектыг хамгаалах, хайр гамтай хадгалах эрх ашиг юм. Халдлагын зүйл нь улсын хамгаалалтанд байгаа байгалийн объект бөгөөд түүнд дархан цаазат, байгалийн цогцолборт, дурсгалт газар хамаарна. Объектив тал нь байгалийн объектыг устгасан, эвдсэн, гэмтээснээр илэрнэ. Энэ гэмт хэргийг шатаах, усанд авахуулах, огтлох, дэлбэлэх олон аргаар үйлдэх боловч зүйлчлэлд нөлөөлөхгүй. Устгасан гэж байгалийн объектыг бүрэн хэрэгцээгүй болгож, дахин сэргээх боломжгүй байдлыг ойлгоно.

Гэмтээсэн гэж тухай объектыг түр буюу хэсэгчлэн хэрэгцээгүй болгосныг хэлнэ. Объектын төрөл, байдлаас шалтгаалж, тодорхой хугацаа өнгөрсний дараа сэргээгдэх буюу учир холбогдолоо бүр мөсөн алдах явдал ч гарна. Эвдсэн гэж объектыг устгах, гэмтээх хэмжээнд хүрээгүй боловч байгалиас заяасан гадаад дүрс байдлыг алдагдуулж ямар нэг хэсэгт нь өөрчлөлт /хэлтлэх, эмтлэх, зураас, хэрчлээс тавих, нэрээ бичих/ гаргасныг хэлнэ.⁸⁶

Мөн 11 дүгээр бүлэг. Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг. 258-р зүйл. “Түүх соёлын дурсгалт зүйлийг санаатай устгах, эвдэх, гэмтээх” Түүх соёлын дурсгалт зүйлийг санаатай утгасан

⁸³ Ч.Доржсүрэнгийн судалгааны ажлын материалын хэсэгээс

⁸⁴ С.Жанцан, Б.Баярсайхан нар. “Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/ УБ хот. 2011 он. 542 дахь тал

⁸⁵ С.Жанцан, Б.Баярсайхан нар. “Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/ УБ хот. 2011 он. 568 дахь тал

⁸⁶ С.Нарангэрэл. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” 1998 он. 207, 208 тал

эвдсэн, гэмтээсэн бол 1 жил 6 сар хүртэлх хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.⁸⁷ гэж заасан нь нийгмийн объект болох түүх соёлын дурсгалт зүйлсийг устгах, эвдэх, гэмтээх гэмт хэрэг болон байгалийн объектыг устгах, эвдэх, гэмтээх гэмт хэргийг өөр бүлэг, зүйлд тусад хуульчилсан нь маш оновчтой болжээ.

Энэ гэмт хэргийн объект нь нийгмийн зан суртахуун байна. Объектив тал нь түүх соёлын дурсгалт зүйлийг устгасан, эвдсэн, гэмтээснээр илэрнэ. Түүх соёлын дурсгалт зүйлд түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий эд өлгийн болон оюуны үнэт зүйлийг өмчийн төрөл харгалзахгүйгээр түүх соёлын дурсгалт зүйл хамруулдаг юм. Жишээлбэл: эртний хүний оромж, отог бууц, зэр зэвсэг, сүг зураг, хадны бичээс, хөшөө дурсгал, булш бунхан, хиргисүүр зэрэг археологийн дурсгал, түүхэн аль ч үеийн хүний болон сөнөсөн амьтан, ургамал бичил биетний бүх төрлийн олдвор, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз болон түүхэн аль ч үеийн уран барилгын цогцолбор, сүм, дуган, хийд, гудамж талбай, байшин барилга зэрэг болно.

Доктор, профессор С.Нарангэрэл энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдийг тайлбарлахдаа устгасан гэж бүрмөсөн хэрэгцээгүй болгосныг ойлгоно. Эвдсэн гэж хэлбэр дүрсийг нь үзэмжгүй болгосон, элдэв зүйл эрээлэн бичсэн, сийчсэн зэргийг хэлнэ. Гэмтээсэн гэж сэргээн шинэчлэлт, засвар зайлшгүй шаардлагатай болсон байдлыг ойлгоно. Субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай байна. Субъект нь 16 насанд хүрсэн этгээд байна⁸⁸ гэжээ.

Дээрхээс үзэхэд 1921 оноос хойш орчин цагийн Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид түүх соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэргүүдийг хуульчилж ирсэн бөгөөд тухай цаг эрүүгийн хууль тогтоомжуудад түүх соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэрэгт оногдуулж байсан ял шийтэлийн эдгээр шинэчлэл өрчлөлтүүд нь эрт эдүгээ өнөө үеийн хууль цаазуудын уламжлал шинэчлэлийг харуулахын зэрэгцээ тэдгээрийн залгамж чанарыг хадгалж чадахуйц өөрчлөлтүүд болсон байна.

Түүхийн олон жилийн хугацаанд чандлан сахиж ирсэн хууль цаазаа судлаж танин мэдэх нь тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулж байсан ял шийтгэл, тэдгээрийн төрөл хэмжээ, хуулиудын уялдаа холбоо уламжлал шинэчлэлтийг гүнзгий ухаач ойлгоход тус болох тэдгээрийн үндсэн дээр хууль тогтоомжийн ололтой шүүмжлэлтэй талыг нь харьцуулахад ихээхэн тус төхөм болох юм.

МӨНГӨ УГААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮҮСЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Жанцангийн Төгс-Очир

Хууль сахиулахын их сургуулийн докторант

⁸⁷ С.Жанцан, Б.Баярсайхан нар. “Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/ УБ хот. 2011 он. 587 дахь тал

⁸⁸ С.Нарангэрэл. “Монгол улсын эрүүгийн эрх зүй” 1998 он. 291,292 талууд

Стерлинг Сиргив хэмээх зохиогчийн “Захын лордууд” номонд Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчид манай эриний өмнөх 2000 орчим жилийн тэртээгээс асар ихээр хуримтлагдсан мөнгөө эрхтэн дархтан, ноёдууд нь хурааж авах, бусдад булаалгаж дээрэмдүүлэхээс айж өөрсдийн эд хөрөнгөө асар их нарийн арга хэрэглэж нуудаг байсан тухай бичжээ.⁸⁹ Тэд ингэж нуухын зэрэгцээ бөглүү тосгонд аваачиж хөрөнгө оруулах, Хятадын мөнгөө хилээс гаргах зэрэг арга хэрэглэдэг байснаар оффшерын бизнес үүсч, төрөөс оногдуулах татвараас зугтаах боломж бүрдсэн гэж үздэг. Эртний цаг үед хүмүүс мөнгө угаахдаа нуун далдлах, холдуулах, хөрөнгө оруулах, эд зүйл өндөр үнээр худалдан авах зэрэг цөөн тооны түгээмэл арга хэрэглэж байсан бөгөөд олон жил өнгөрсөн боловч мөнгө угаах арга, зарчимд төдийлөн дорвитой өөрчлөлт орсонгүй өдийг хүрчээ. Нэгэн зэрэг хэд хэдэн банк ажиллуулах замаар мөнгө угаадаг нь удаан хадгалагдаж арга, ажиллагаа улам нарийсч онцын бэрхшээлтэй тулгарахгүйгээр мөнгө угаах арга болжээ. Энэ удаан хугацааны туршид хүмүүс гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө угаахдаа гол төлөв төрийн хараа, хяналтаас зугтаалгах олон аргуудыг хэрэглэж ирсэн түүхтэй. Мөнгөний оронд алтан зоос хэрэглэж байсан бөгөөд энэ үед мөнгөө угаахад алтны чанар, хэмжээ чухал үүрэгтэй байв. Түүнээс гадна асар их үнэтэй алмаз эрдэнийг мөнгө угаахад өргөнөөр ашиглаж ирсэн тухай түүхийн эх сурвалжуудад тэмдэглэж ирсэн байна.

“Money laundering” буюу мөнгө угаах гэдэг нэр томьёо нь Америкаас гаралтай бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах болон түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль ёсны болгох үйлдлийг хэлнэ.

Мөнгө угаах явдал нь АНУ-д архи хэрэглэхийг тас хорьдог хуультай болсон үеэс улбаатай. Тухайн үед гангстерүүд сархдын хууль бус наймаанаас асар их мөнгө олдог байж. Орлого хууль бус наймаанаас олдсон байж таарахгүй учир өөр орлогоос олсон мэт харагдуулах ёстой байв. Орчин үед хар тамхи, зэвсэг наймаалсан хууль бус мөнгөө казиногоос хожиж олсон мэт болгож угаадаг түгээмэл арга дэлгэрчээ. Мөнгө угаахад тогтсон ханш ч бий. Хууль бус мөнгөтэй хүн 30м хүртэл хувийг нь тушаагаад казиногоос асар их баялаг азаар хожлоо гэсэн баримт бүрдүүлж орхино.

Мөнгө угаахтай төстэй үйл ажиллагаа бол маш эрт дээр үеэс хийгдэж байсан. Гэмт хэрэгтэн гэмт үйлдлээс олсон орлогоо нуун дарагдуулж, эх үүсвэрийг нь халхлах үйл ажиллагааг дэлхийн түүхийн аль ч үед хийж байсан. Харин мөнгө угаах нэр томьёолол нь сонгодог хэлбэрээрээ 1920-иод онд Америкийн хуурай хууль үйлчилж байх үед Чикагогийн мафийн толгойлогч алдарт Ал Капоне өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудыг ашиглан хууль бус үйлдэл (архины худалдаа, рекет)-ээр олсон орлогоо угаалгын газрын ашиг мэт харуулж байсныг “L expresse” сонинд “Хувцас биш мөнгө угааж байна” гэж бичсэнээр анх гарч ирсэн гэж үздэг.

АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоныг 1974 онд огцруулж байсан “Watergate”-ийн дуулианы үеэр энэ нэр дахин гарч ирснээр дэлхий нийтэд танил болсон. Тэр үед Ричард Никсоныг дэмжих “Ерөнхийлөгчийг дахин сонгох хороо”-гоор дамжуулан нууц данс ашиглан хууль бус мөнгийг Мексик рүү гуйвуулж байсан нь тогтоогдсон байна. Энэ үеэс олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг болжээ.

“Хар гариг” буюу 1929 онд Нью-Йоркийн бирж дээр гэнэтийн хүчтэй уналт болж тэр нь улам даамжирсаар дэлхийн эдийн засгийг сүйрүүлсэн юм. Эндээс “хар гариг” гэсэн нэршил үүссэн байна. Бирж дээрх гэнэтийн уналтыг ийнхүү “хар” гэж

⁸⁹Sterling C.Crime without Frontiers Little,Brown.London 1994 P.15

нэрлэдэг болжээ. Энэхүү гэнэтийн уналтанд ч гэсэн Америкийн анхны мафийн гишүүд оролцож их хэмжээний ашиг олсон тухай баттай бус мэдээлэл гарч байжээ.

Төрийн дээд эрх мэдлийг биенээсээ үл хамаарсан харилцан хянаж чаддаг хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглалууд болгон хуваах тухай онолыг Монтеスキо боловсруулж, 1776 оноос АНУ-д анх амьдралд хэрэгжүүлж эхэлжээ. Дэлхийн анхны үндсэн хууль тэнд боловсорч төрийн гурван өндөрлөгийн тухай хуульчилж өгсөн байна. Энэ загвар өдгөө аль ч улс орнуудад хуульчлагдсан, харин хэрэгжилт нь мэдээж өөр өөр байдаг. Хамгийн анхны үндсэн хуулийг баталсан оронд мөнгө угаалт бий болж түүнтэй тэмцэх үйл ажиллагаа нь ч дэлхий дахинд нөлөөлж байна.

Түүхэнд мафи буюу зохион байгуулалттай гэмт байгууллага анх XVIII, XIX зууны заагт Италийн Сицилид бүрэн утгаараа үүссэн гэж судлаачид үздэг. Нөгөө талаараа “Mafia” гэдэг нь Араб гаралтай “орогнох, хоргодох” гэсэн утгатай үг юм. Гэхдээ зохион байгуулалттай гэмт байгууллага (цаашид “гэмт байгууллага” гэх) анх XVIII, XIX зууны заагт Италийн Сицилид үүссэн гэж шууд утгаар нь ойлгож болохгүй. Учир нь энэ үед Европ, Ази, Дорно дахины улс орнуудад гэмт байгууллага байсан.

Тиймээс мафийн үүслийн талаарх ойлголт нь дээрх улс орнуудыг гэмт байгууллагын талаар цогц байдлаар өнөө болтол бүрэн судлагдаагүй байгаа нөгөө талаар Итали-Америкийн мафийн сүлжээ тодорхой хэмжээнд судлагдан олны хүртээл болсонтой холбоотой.

Харин “Мафи” гэдэг нэр томьёо нь анх Италийн Сицилид үүссэн гэдэгтэй хэн ч маргахгүй. VIII зуунд Сицили нь Арабын түрэмгийлэгчдэд эзлэгдсэн байв. Сицилийн уугуул иргэд ихээхэн зовлон зүдгүүрийг амсаж тэд Араб, Нормандчуудын булаан эзлэгчид тэдэнтэй сүжрээд буй нутгийн баячуудын эсрэг өөрсдийн нууц нийгэмлэгийг байгуулж тэр нь “мафи” гэж нэрлэгдэх болсон байна.

Гэхдээ мафи хэмээх нэр томьёо нь аль эрт буюу 1282 онд Сицилийн ард түмэн Францын булаан эзлэгчдийн өөдөөс зэвсэглэсэн тэмцэлд боссон тэрхүү түүхэн цаг үед хамаардаг. Тэр үед “Morte alia Francia, Italia anela” (Франц сөнө, Итали амьсгалаа ав) хэмээх дуулал төрсний эхний үсгүүдийг нийлүүлэн “MAFIA” гэх нэр үүссэн түүхтэй.⁹⁰

Түүхэн цаг үе өнгөрөхийн хажуугаар мафи гэх нэрийг зөвхөн ядуучууд болон дарлагсдыг хамгаалах, ямар нэгэн арилжаа наймаанд төлөөлөн оролцох ажиллагаанд ашиглах зэргээр хэрэглэж байснаар одоогийн бидний мэдэх мафи үүссэн. Түүнээс хойш мафи нь улам бүр гэмт хэргийн байгууллагын шинжтэй болж хөгжиж ирсэн байна.

Тухайн үед Италийн жижиг үйлдвэр эрхлэгчид, газрын эзэд өөрсдийн аюулгүй байдлаа хангах зорилгоор зэвсэглэсэн этгээдийг хөлслөн авч ажиллуулах болсон төдийгүй тэд өрсөлдөгчийнхөө эд хөрөнгийг устгуулах, амь насанд нь халдахдаа тэрхүү этгээдүүдийг ашигладаг байсан ба улмаар нарийн зохион байгуулалтад орж аллага хядлага, дарамт шахалт үзүүлэн зорилгоо биелүүлэх нууц гэмт байгууллага болж хувирсан юм.

Эрхтэн дархтанууд нь сайн зохион байгуулалттай, бүрэн зэвсэглэсэн дээрэмчдийн бүлэглэлүүдийг гар хөлөө болгодог. Италид олон жил ноёрхож ирсэн шударга бус амьдралын зөрчлийг гүнзгийрүүлэх болсон.⁹¹

Мөнгө төгрөгтэй хэсэг нь нутгийн ард түмэнд мөнгө төлж захиалгат аллага хийх болсон. Уг систем эрт цагаас ноёрхож ирсэн бөгөөд үүнд баячууд дээрэмчдээс гадна албан ёсны төр засгийн ажилтнууд хүртэл хамрагдсан байна. Эд хөрөнгө, мөнгө, айлган сүрдүүлэлт, цусан өшөө авалт, садан төрлийн холбоо энэ бүгд мафи хэмээх нууц байгууллагад оршдог юм. Энэ байгууллагын жинхэнэ гишүүд

⁹⁰Батзаяа “Мөнгө угаалт”

⁹¹ Батзаяа “Мөнгө угаалт”

өөрсдийгөө хүмүүнлэг, ёс төртэй, өгөөмөр хүмүүс гэж үздэгт гайхах зүйл байхгүй юм. Мафийг судалсан нэрт эрдэмтэн зохиолч Лоскьяво Сицилид олон жил шүүгч хийж байхдаа мафийн толгойлогчдын нэг Пассалакка "...Та хөгшин болсон хойноо намайг үхсэний дараа ямар сайн хүн байсныг ойлгоно доо..." гэж түүнд хэлж байсныг дурдсан байдаг. Сицилийн мафийн гишүүдийг "Лупарагийн баатрууд" гэж нэрлэдэг байв. "Лупара" нь тус нутгийн анчид эрт цагт хэрэглэдэг байсан буу юм. Түүгээр хэн нэгийг буудвал амьд үлдэх боломжгүй болгодог аж. "Лупарагийн баатар" болохдоо өөрсдийн цусаараа тангараг өргөж, хохимой толгой зурсан цаасыг лааны дөлөн дээр шатаадаг уламжлалтай байж. "Ах дүүдээ үнэнч байж энэ дүрс үнс болж байгаатай адил ах дүүдээ цусаа өгөхөд бэлэн, үнс дахин цаас болж чадахгүйтэй адил би ах дүүсээсээ хэзээ ч урвахгүй" гэж тангараг өргөдөг байв.

"Омерта" гэдэг нь мафийнханы мөрддөг гол хууль юм. Италийн сэтгүүлч Франческо Маркезе бичихдээ "...ах дүүсээсээ урвасан хүнийг өршөөлгүйгээр алахыг омерта гэнэ. Мафийн гишүүн биш байсан ч шаардлагатай бол хөндлөнгийн хүнийг ч ална. Бүгд дуугүй байх ёстой. Үхсэн гэрч дуугүй байдаг. Энэ бол мафийн гол зарчим..." гэсэн байдаг.

Өнөөдөр Америкийн мафид 10 гаруй гэр бүл багтаж, АНУ, Канадыг "хувааж" үйл ажиллагаа явуулдаг байна.

- Зүүн эрэг хавийн мафи: (Vito Genovese, Carlo Gaetano, Gaetano Lucchese, Giuseppe Magliocco, Joseph Bonanno),

- Баруун эрэг хавийн мафи: (Баффало, Род Айлэнд, Бостон, Детройт, Чикаго) Уг эрэг хавийн газар нутгийг эзэмшиж, хууль бус мөнгөө хууль ёсны бизнесээр дамжуулан угааж их хэмжээний ашиг олж байна.⁹²

АНУ-д согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэх, тээвэрлэж зөөвөрлөх, худалдаалж борлуулахыг хориглосон "Архины хууль" буюу "хуурай хууль" хэмээн нэрлэгдсэн АНУ-ын Үндсэн хуулийн 18-р зүйлийн нэмэлтийг ийнхүү нэрлэжээ. Уг нэмэлтийг 1920 оны 1-р сарын 20-нд хүчин төгөлдөр болгож 1933 оны 12-р сард хүчингүй болгосон байна. Энэ үед архи согтууруулах ундааны хууль бус бизнесийн талбарыг гартаа авахын төлөө Ирланд ба Итали гаралтай хүмүүсээс бүрдсэн бүлгүүдийн хооронд ширүүн тэмцэл явагдаж Америкийн мафи эх үндсээ тавьсан юм. Архи зарахыг хориглосон "Хуурай хууль"-ийг ашиглаж "Коza ностра" нууцаар архи зарж маш их хөрөнгөжсөн гэдэг. Яг энэ үед 1930 онд "Кастелламарын дайн" гэж нэрлэгдсэн тэмцэл бүлгүүдийн хооронд гарсан юм. Сицилийн хотхон Кастелламаре дель Жузеппе Массерия өөрийн гартаа Гангстерын байгууллагын удирдлагыг авахын тулд өөрийн хамтран зүтгэгч өрсөлдөгчөө алах гэж байгаад өөрөө алуулсан түүхтэй. Түүний шадар тойрон хүрээлэгчид болох Чарли Лю Чиано, Дон Вито Женовезе, Сальваторе Маранзано, Аль Капоне нарын эхний хоёр нь түүний хамгийн итгэлт шадар туслахууд байв. Аль Капоне Чикагогийн гэмт ертөнцийн толгойлогч бөгөөд "Чикагогийн хаан", "Сальваторе Маранзано" нь "Нью-Йоркийн" хаан гэгддэг байжээ. Жузеппе Массериягийн дараа Сальваторе Маранзано "Коza ностра"-гийн удирдагч болж өнөөгийн мафийн их суурийг тавьсан юм. Тэрээр гэмт байгууллагаа газар зүйн байршлаар нь эрх мэдэл гэх мэтээр 27 дүүрэгт хуваасан. Гэлээ ч тэдний хоорондын тэмцэл үргэлжилсээр Сальваторе Маранзаноны гэртээ алдагдсан юм. Боссын суудалд суусан хэн ч тайван амьдардаггүй, үхэл ямагт хажууд нь сүүдэр лугаа адил дагадаг. Гэр орондоо байсан ч, хүлээн авалтын ширээний ард суусан ч урвагчийг өршөөхгүй. Эрх мэдлийн төлөө тэмцлийн дүнд дараах хүмүүс "Коza ностра"-ийн эздийн эзнээр дараалан гарч ирсэн юм.

"Лаки" Лючиано 1946 онд эд хөрөнгөө аваад аль нэг тийшээ зугтаасан гэж тухайн үеийн хүмүүс таамагладаг байна. Багси Зиегель хамгийн том казиног

⁹²Криминология "Словарь Справочник" 1998, М, стр 134-р тал

Ласвегаст анх байгуулж үндэс суурийг нь тавьжээ. Франк Костелла 1957 онд бусдад алдагдсан. Дараа нь толгойлогч нь Вито Женовезе болсон юм.⁹³

Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсвэл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж шилжүүлсэн, бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томьёоллыг ашигладаг.

Мөнгө угаахтай тэмцэх гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршдог. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх, түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой.

Мөнгө угаагчдын нийтлэг дүр зураг бол тэд өөрсдийн шударга хөдөлмөрөөр олсон мөнгөө үрж байгаа мэт олон түмэнд харагдахыг чухалчилдаг. Тэд мөнгөө угаахдаа архи, согтууруулах ундааг их хэмжээгээр импортлох, экспортлох, борлуулах үйл ажиллагаанаас орлого олох, бизнес эрхлэгчид, худалдаачдыг далайлган сүрдүүлэх (рекэт хийх) мөрийтэй тоглох зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан бохир мөнгөө цэвэршүүлдэг.

ШУ-ны доктор Б.Баттөмөр энэ асуудлыг тусгайлан судлаад “Мөнгөний эх сурвалжийг нуух нэг гол арга нь мөрийтэй тоглоом байжээ. Гангстеруудын хувьд олсон мөнгөө ихэнх тохиолдолд задгай мөнгө, заримдаа зоосон мөнгө болгодог байсан нь нуухад төвөгтэй байдалд оруулж, хаанаа нуух вэ гэдэг нь тэдний хувьд шүдний өвчин болоод байв.” Задгай зоосыг банкинд хийвэл асуудал үүснэ. Зоосон мөнгийг их хэмжээгээр хадгална гэдэг нь аюултай. Тэд зоос хадгалах савыг удалгүй зохион бүтээсэн нь зоосон мөнгөөр ажилладаг машин байлаа. Эндээс л мөнгө угаах гэсэн нэр томьёо үүссэн гэдэг. Согтууруулах ундааг хууль бусаар зарж борлуулсан ашгийг янз бүрийн аргаар нуун хааж байсан олон тохиолдол байдаг. 1931 онд Аль Капоне татвараас зугтаасан хэргээр яллахад Мейер Лански Флоридад казиногоос олсон мөнгөө гадаадын дансруу шилжүүлж байсан нь тогтоогджээ.

1934 онд Швейцарын банкны хууль гарч банкны нууцлалын зарчмыг бий болгосноор Мейер Лански халхавч компани, оффшер дотор дамжуулан хууль бусаар олсон мөнгөө байршуулахаар Швейцарийн нэг банкныг хүртэл худалдаж авсан. Мөнгө угаах гэсэн нэр томьёог XX зуунд хатуу хориглох болсон ч үнэн хэрэг дээрээ мөнгө угаах арга, зарчим дээр үед бий болсон. Шунахай худалдаачид болон эрх мэдэлтнүүдээс эд агуурсаа нуухын тулд тэдний олж мэдэхгүй, хураан авч чадахгүй аргаа мөнгөө эргэлдүүлэх арга олсон тухай бичсэн байдаг. Ийм болохоор мөнгө угаах тухай ойлголт бүр Христийг мэндлэхээс 2000 жилийн өмнө оршиж байсан байж таарах нь”⁹⁴ гэж бичсэн нь үндэслэлтэй юм.

Мөнгө угаах талаар улс орнуудад нэгдсэн ойлголт хараахан тогтоогүй өдий хүрчээ. Зарим оронд мөнгө угаахын тулд үйлдэгддэг гэмт хэргүүдийг мөнгө угаах суурь ажиллагаа гэж үзэж мөнгө угаах гэмт хэрэгт хамааруулдаг бол ихэнх улс орнуудад мөнгө угаахын тулд үйлдэгдсэн гэмт хэргийг бус зөвхөн гэмт хэрэг үйлдэж олсон мөнгийг л угаадаг гэсэн ойлголт түгээмэл байна.

Мөнгө угаах гэсэн нэр томьёо жинхэнэ утгаараа АНУ-д Уотергейтийн хэмээх дуулиант хэрэг мандах үед хэрэглэгдэж байсан АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоны удирдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн хороо сонгуулийн компанит ажлын үеэр хандивласан мөнгийг Менски улсруу шилжүүлээд, дараа нь буцаагаад Мянанид байх нэг банкруу буцаан татжээ. Үүнийг Их британийн “Cenardian” сонин угаагдсан мөнгө гэж нэрлэсэн.

⁹³ С.Нарангэрэл. Зохион байгуулалттай гэмт явдал. УБ 1991. 11 дэх тал

⁹⁴ Б.Баттөмөр. Мөнгө угаах гэмт хэрэг гэж юу вэ? УБ, 2007он 12-19 дэх тал

1980 оноос олон улсын хэмжээнд мөнгө угаах явдлыг гэмт хэрэгт тооцох хандлага илэрхий идэвхжсэн нь харагддаг. Тухайлбал, 1986 онд АНУ, Англи зэрэг улс мөнгө угаахыг гэмт хэрэгт тооцож хуульчилсан бол 1988 оны Венийн Конвенцид нэгдсэн орнууд мөнгө угаах үйлдлийг өөрсдийн үндэсний хууль тогтоомждоо гэмт хэрэгт тооцож хуульчлах үүрэг хүлээсэн байдаг. Мөнгө угаахтай хийх тэмцэл улам эрчимжиж, 1989 онд Олон улсын Санхүүгийн хяналтын алба FATF (Financial Task action Force) байгуулагдаад нэг жилийн үйл ажиллагааны тайландаа энэ байгууллагаас мөнгө угаахыг гэмт хэрэгт тооцохыг улс орнуудад зөвлөмж болгосон.

FATF нь гишүүн орнуудынхаа мөнгө угаахтай хийж буй тэмцлийн явц, үр дүнг сайжруулах, мөнгө угаалтын чиг хандлагыг нь хянаж, ажиглан чиглэл өгч байдгаас гадна мөнгө угаахын эсрэг дэлхийн стандарт тогтоох асуудлыг хариуцан ажилладаг байна. FATF-ын бодлого нь ирээдүйд бий болж болзошгүй гэмт хэргийг санхүүжүүлэх болон эдийн засгийн хууль ёсны үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэмт хэргийн чанартай орлого олох явдлаас сэргийлэх зорилготой байдаг.

FATF-ын зарчим нь мөнгө угаах явдал нь нэлээд нарийн түвэгтэй эдийн засгийн гэмт хэрэг учраас ердийн хуулийн хүрээ дангаараа үүнд хяналт тавихад үр ашиг муутай байдаг тул сангийн сайдууд, санхүүгийн байгууллагууд болон хууль тогтоогчид мөнгө угаах гэмт явдалтай нягт хамтран тэмцэх ёстой гэсэн үзэл санаанд үндэслэдэг юм. FATF-т “одоогоор Австрали, Австри, Бельги, Канад, Дани, Финланд, Франц, Герман, Грек, Хонг Конг, Ирланд, Итали, Япон, Люксембург, Нидерландийн Вант Улс, Шинэ Зеланд, Норвег, Португал, Сингапур, Испани, Швед, Швейцарь, Турк, Их британ, АНУ гэсэн 30 орон, Европын комисс, Персийн булангийн хамтын ажиллагааны зөвлөл гэсэн олон улсын 2 байгууллага элсээд байгаа юм. Мөн Хойд Америк, Азийн санхүүгийн голлох төв улс орнууд хамрагдаад байна.”⁹⁵

1999 оны 5-р сард болсон Бирминхэмийн эдийн засгийн чуулга уулзалтад Их долоогийн сангийн сайд нар, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага OECD болон FATF мөнгө угаах явдлын эсрэг системийг сайжруулах, сэжигтэй гүйлгээг мэдээлж байх тал дээр хүчин чармайлт тавихыг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэггүй улс орнуудад хандан уриалсан болно. FATF-аас жил бүр хурал, семинар зохион байгуулж хууль хэрэгжүүлэгч эксперүүдэд мөнгө угаах гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх талаар, тухайлбал гэмт хэргийн эх үүсвэртэй орлогыг угаах сүүлийн үеийн хандлага, өсөн нэмэгдэж байгаа аюул заналхийлэл болон эсрэг авах арга хэмжээг хэрхэн үр дүнтэй авч хэрэгжүүлэх зэргийг хэлэлцэж байжээ.

FATF-ын 40 зөвлөмж нь 1990 онд анх гарсан бөгөөд 1996 оноос хойш уг 40 зөвлөмжийг дахин хянаж, шинэчилсэн байна.⁹⁶ Эдгээр 40 зөвлөмжийг мөнгө угаахын эсрэг тэмцэх дэлхий нийтийн сонирхолд нийцүүлэн боловсруулжээ. Эдгээр нь эрүүгийн шүүн таслах систем, хуулийн арга хэмжээ, эдийн засгийн систем болоод түүний тогтворжилт, олон улсын харилцаа зэрэг бүх салбарыг хамарч хийгдсэн уян хатан шинж чанартай баримт бичиг юм. Түүнчлэн улс төр, эдийн засгийн хөгжилд нөлөөлөхөөргүй хууль сахиулах болон санхүүгийн системийн тогтолцоо, түүний зохицуулалт, олон улсын хамтын ажиллагааг хамарсан байдаг нь эдгээр зөвлөмжийн онцлог бөгөөд түүнийг өнөөдөр олон улсын мөнгө угаахтай тэмцэх стандарт хэмээн тооцох болсон.

FATF-ын орнууд бүгд зөвлөмжийг хүлээн зөвшөөрч дагаж мөрдөх болжээ.

⁹⁵ Эрх зүйн шинэчлэлийг дэмжих хуульчдын төв. “Бизнесийн эрх зүй” Д.Зүмбэрэлхам. УБ., 2003., 5 дахь тал

⁹⁶ “Мөнгө угаахын эсрэг санхүүгийн аргаар тэмцэх олон улсын байгууллагын 40 зөвлөмж” танилцуулга. УБ, 2004

FAFT нь бусад улсад тодорхой заавар өгч хянадаг. Эдгээр арга хэмжээ нь мөнгө угаахтай тэмцэхэд үр дүнтэй сайн нөлөөтэй байдаг. Энэбаримтбичигт:

- Улс орон бүр Венийн конвенцийн дагуу мөнгө угаах ажиллагааг гэмт хэрэг гэж хуульчлах,

- Угааж буй орлого, түүнд ашигласан ба ашиглахыг завдсан аливаа хөрөнгө мөнгийг хууль зөрчөөгүй гуравдагч талын эрх ашгийг хохироолгүйгээр хураан авах,

- Эрх бүхий байгууллагуудаас мэдээлэл хүссэн тохиолдолд шуурхай хариу өгөх зорилгоор дотоод ба гадаад гүйлгээний сүүлийн 5-аас доошгүй жилийн бүртгэлийг санхүүгийн байгууллагууд хадгалж байх,

- Хэрэв санхүүгийн байгууллагууд гүйлгээнд орсон мөнгийг гэмт хэргийн шинжтэй гэж сэжиглэвэл эрх бүхий байгууллагуудад энэ талаар нэн даруй мэдэгдэж байх,

- Сэжигтэй гүйлгээ, түүнд оролцсон байгууллага, хүмүүсийн талаарх мэдээллийг олон улсын эрх бүхий байгууллагууд нэн даруй ба хүсэлт гаргасны дагуу солилцох явдлыг улс орон бүр дэмжиж байх зэрэг гол чухал гэсэн 40 зүйлтэй зөвлөмжийг багтаасан байдаг.

Мөн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэл явуулдаг бас нэгэн олон улсын байгууллага бол “Эгмонт” группын Олон улсын санхүүгийн тагнуулын алба юм. “Эгмонт-групп” нь анх 1995 оны 6-р сарын 9-нд Брюселийн” Эгмонт-Аренбэг” ордонд “Эгмонт групп” хэмээн албан бусаар нэрийдэх болсон уулзалт хийснээр байгуулагдаж үйл ажиллагаа нь эхэлжээ. Эгмонт групп нь 1997 оны 6-р сарын 23-24-ний хооронд “Мадрид” хотноо уулзалт зохион байгуулж, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнтэй нөлөө үзүүлэх хэрэгсэл санхүүгийн тагнуулын албатай байна гэж тодорхойлон “Эгмонт группын гишүүд”-ийг бүрдүүлэн Ром хотноо 1996 оны 11-р сард дахин хуралдан дэлхий нийтээр засгийн газрын хүрээнд санхүүгийн тагнуулын байгууллагыг бий болгох талаар харилцан тохиролцсон байна.⁹⁷ Сэжиглэгдэж байгаа гэмт хэрэгтэй холбоотой үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн мэдээллийг хүлээн авах (зөвшөөрөгдсөн бол хүсэлт гаргах) дүгнэлт хийх эрх бүхий байгууллагуудад тарааж мэдээлэх асуудлыг эрхэлсэн үндэсний төв агентлагыг санхүүгийн тагнуулын байгууллага гэж нэрлэнэ гэсэн тодорхойлолттой санал нэг нотолсон байна.

“Эгмонт группын” санхүүгийн тагнуулын алба нь дараах асуудлыг нэн тэргүүний ач холбогдолтой гэж үзэн ажлын хэсэг болоод бусад хэлбэрээр авч хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Дэлхий нийтээр засгийн газрын хүрээнд санхүүгийн тагнуулын байгууллагыг байгуулах,

- Хоёр талын тохиролцоо харилцан солилцоон дээр үндэслэн мэдээллийн солилцоог идэвхжүүлэх,

- Дэс дараатай семинар зохион байгуулах, мэргэжилтэн солилцох хэлбэрээр бүсийн хэмжээнд сургалтыг үргэлжлүүлэх,

- Мэдээлэл солилцох хэлбэрийг хөгжүүлэх,

- Эгмонт группын болоод группээс зөвшөөрөгдсөн олон нийтэд таниулан сурталчлах мэдээллийг буй болгох,

- Бүс нутгийн улсуудад бололцоотой практик туслалцаа үзүүлж зохицуулах.

Эдгээр байгууллагууд байгуулагдсанаараа мөнгө угаахтай тэмцэх бүс нутгийн хүчин чармайлтыг нэгтгэх, форум зохион байгуулсны үр дүнд:

- Бүс нутгийн асуудлыг авч хэлэлцэн туршлага солилцох,

⁹⁷ “Эгмонт группын Санхүүгийн тагнуулын албаны үйл ажиллагааны тайлбар” Монгол банк, УБ., 2000

- Мэдээлэл солилцох замаар мөнгө угаах гэмт хэргийн улмаас учруулсан хор уршгийг арилгах талаар судалгаа, шинжилгээ явуулах,
- Хууль бус орлогын асуудлыг шийдвэрлэх, бүс нутаг дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг судлан анхааралдаа авах,
- Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартыг бүс нутагт нэвтрүүлэх явдлыг дэмжих,
- Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын шинжтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ бүс нутгийн онцлогыг харгалзах,
- Эрх зүйн харилцан туслалцах илүү үр ашигтай ажиллагаа зэрэг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээнүүд хэрэгжүүлэхийг дэмжих.⁹⁸

Эдгээр ажлуудын үр дүнд өнөөдөр Эгмонтын гишүүн орнууд доорх албадыг байгуулан хамтран ажиллаж байна. Үүнд:

Аруба Мот Аруба, Австрали АУСТРАС, Австри ЭДОК-Мэлдэстэлэ, Бельги СТИФ-СФИ, Бермуда Санхүүгийн мөрдөх алба, Болив Санхүүгийн мөрдөх алба, Бразил СОАФ, Британы Виржин арал Тайлагнах алба-Санхүүгийн Инспектрот, Болгар Санхүүгийн тагнуулын хороо, Чил СДИ, Колуб ЮИАФ, Коста Рика СИСАД ЮАФ, Хорват Санхүүгийн цагдаа, Сири Мөнгө угаахтай тэмцэх алба, Чехийн БНУ Санхүүгийн судалгааны алба, Дани СОК, Доминиканий БНУ ЮИФ, Эстоны БНУ мөнгө угаах талаарх мэдээллийн алба, Финлянд Санхүүгийн цагдаа, Франц ТРАКФИН, Грек 2331/1995 хуулийн 7-р зүйлийн хороо, Гюрнси Гааль цагдаагийн хамтарсан санхүүгийн алба, Хонг Конг Санхүүгийн хамтарсан тагнуул. Унгар ОРФК, Исландын БНУ, Ирландын БНУ залиланг мөрдөх товчоо. Исле ов ман ФЮИ, Итали ФИС, Япон ЖАФИО, Жэрсси Гааль, цагдаагийн хамтарсан санхүүгийн алба, Латив, Литив, Люксенбург Мөнгө угаахтай тэмцэх алба, Мексик ЮИФ, Монако СИССФИН, Голланд МОТ, НЛ Антилс МОТ, Шинэ Зеланд Цагдаагийн санхүүгийн алба, Норвега ОКОРМ, Панама Санхүүгийн судалгааны алба, Парагвай Санхүүгийн судалгааны алба, Португал Мөрдөх товчоо, Румын Мөнгө угаахын эсрэг тэмцэх үндэсний төв, Словак ЮНП, Славян ЮПД, Испани СЭПБЛАЗ, Швед санхүүгийн цагдаа, Швецари мөнгө угаалтын талаарх тайлагнах алба, Тайван мөнгө угаахаас сэргийлэх төв, Турк МСК, Нэгдсэн вант Улс ЭКЮ, Венусвель ЮНИФ, АНУ ФИНСЭН буюу Санхүүгийн мэдээллийн сүлжээнд гэмт хэрэгтэй тэмцэх газар⁹⁹ зэргийг нэрлэж болно.

Энэ байгууллагыг санхүүгийн мэдээллийн албанаас ялган ойлгох хэрэгтэй. Тагнуулын алба нь улс орнуудын хэмжээнд холбооны буюу группын орнуудын тагнуулын байгууллагуудтай хамтран ажилладаг бол санхүүгийн мэдээллийн алба санхүүгийн гүйлгээнд хяналт шалгалт, үнэлгээ дүгнэлт өгч ажилладагаараа ялгаатай. Гэхдээ санхүүгийн мэдээллийн алба, санхүүгийн тагнуулын байгууллага хоёул санхүүгийн гүйлгээг задлан шинжилж сэжигтэй мэдээллийг шүүх цагдаа, прокурор гэсэн хууль хяналтын байгууллагатай хамтрах замаар мөнгө угаах гэмт хэрэгтэй хамтран тэмцдэг.

Манай бүс нутагт энэ чиглэлээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь мөнгө угаахын эсрэг “Ази-Номхон далайн групп” (APG) юм. Ази-Номхон далайн бүс нутагт мөнгө угаах асуудал мөн л анхаарал татах хэмжээнд хүрээд байгаа билээ. 1997 онд Бангкок хотноо явагдсан мөнгө угаах үзэгдлийн талаар Ази-Номхон далайн Симпозиумын үеэр мөнгө угаахтай тэмцэх “Asia Pacific Group on Money laundering” буюу Ази-Номхон далайн групп гэдэг “APG” байгууллагыг байгуулсан юм.¹⁰⁰ Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон

⁹⁸ Г.Арсланхуяг. Мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх тэмцлийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал. УБ., 2006. Магистрийн дипломын ажил. 8-9 дэх тал

⁹⁹ Эгмонт группын Санхүүгийн Тагнуулын албаны үйл ажиллагааны тайлбар. Монгол банк, УБ., 2000

¹⁰⁰Клаус Коттке. “Грязные деньги” М., 1998

далайн 26 гишүүн, 13 ажиллагч оронтой ажиглагчийн нэг нь Монгол Улс.¹⁰¹

Энэхүү групп байгуулагдсан нь Ази-номхон далайн бүс нутагт нөлөөлж буй мөнгө угаах асуудал нь олон улсын хэмжээний асуудал болж байгааг, мөн бүс нутгийн улс орнууд мөнгө угаахтай тэмцэхэд хамтран ажиллах шаардлагтайг харуулсан байна. АРГ-ын албан ёсны анхны хуралдаан нь 1998 оны 3-р сард Токио хотноо болж, 25 улсын хууль тогтоох байгууллагууд, олон улсын 7 байгууллагаас төлөөлөгчид оролцож, Ази номхон далайн бүс нутаг дахь мөнгө угаах явдлын эсрэг үр ашигтай бодлого боловсруулахад чиглэсэн хэд хэдэн бичиг баримт, дүрэм гаргасан болно.¹⁰²

Энэхүү дүрмээрээ мөнгө угаахын эсрэг үр дүнтэй тэмцэх хүрээ, орчинг бүрдүүлэхийн тулд “FATF”-аас санал болгосон 40 зөвлөмжийг үндэслэн “АРГ”-ийн ажлын хэсэг тус бүс нутагт үйл ажиллагаандаа баримтлах зарчим, арга хэмжээний талаар баримт бичгийг боловсруулж гаргажээ.

Энэ бүс нутагт мөнгө угаах талаар мэдээллийн эх сурвалж харьцангуй бага байдаг. Зарим улс орнуудад мөнгө угаахын эсрэг өөрийн гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байхад бусад оронд зөвхөн эхлэлийн төдий байна. Өмнөд Ази мөнгө угаах талаар энэ бүсэд тэргүүлж байдаг. Энэ бүсэд олон улсын нилээд олон банкууд байрладаг бөгөөд Афганистан, Иранаас хар тамхийг барууны орнууд руу, Мьянмар, Тайланд, Лаосынхыг зүүн зүг рүү тээвэрлэдэг. Ази-Номхон далайн бүс нутагт Оросын зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгүүдтэй холбоотой санхүүгийн үйл ажиллагаанууд Баруун “Самао”, “Наури”, “Вануати” болон “Коок” арлууд дээр хийгддэг. Уг бүсийн мөнгө угаах эх үүсвэр хөрөнгө нь хууль бусаар хүн болон хар тамхи тээвэрлэх, мөрийтэй тоглоом болон зохион байгуулалттай гэмт хэргээс олсон орлого байдаг.¹⁰³

Төв ба Зүүн Европын бүс нутагт мөнгө угаах хөрөнгийн эх үүсвэр нь хууль бусаар хийсэн гэрээ хэлцэл, хувьчлалын луйвар, байгалийн түүхий эд, бусад бараа таваарын арилжаа байдаг. Аж ахуйн нэгжүүд байгуулсан гэрээ хэлэлцээр зөрчих замаар хөрөнгөждөг. Хүүхэд хулгайлах, зэвсгийн наймаа, хүн барьцаалах, авилга, татвараас зайлсхийх зэрэг гэмт хэрэг тогтвортой гардаг.¹⁰⁴

Хуучны ЗХУ-ын нутаг дэвсгэр дээр ажилладаг зохион байгуулалттай гэмт хэрэгтэн, бүлэглэлүүд анхаарал маш ихээр татаж байдаг. Франц болон Газар дундын тэнгис орчимд үл хөдлөх хөрөнгө их хэмжээгээр худалдан авдаг. Хөрөнгө оруулалтаа ихэвчлэн Чанел, Гибралтар болон Карибийн арлуудаар дамжуулан хийдэг байна. Зүүн Европын банк болон аж ахуйн нэгжүүд эдгээр бүлэглэлүүдийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаагаа явуулдаг байж болзошгүй.¹⁰⁵ Уг бүс нутагт их хэмжээний валют хөрвүүлэх явдал энгийн үзэгдэл, түүнийг хянах шалгах механизм байдаггүй байна. Болгар, Эстони, Латви, Литва ба Румин гэх мэт орнуудын мөнгө угаахтай тэмцэх ажил нь эхлэлийн шатандаа байна.¹⁰⁶

Мөнгө угаах гэмт хэрэгтэй хийх тэмцлийг боловсронгуй болгосноор сүүлийн жилүүдэд эрчимжиж энэхүү эргэлдэж буй олон зуун тэрбум доллараас хууль хяналтын байгууллагууд үе үе хэн хэдэн зуун сая долларыг илрүүлдэг байна. Өнгөрсөн 10 жилийн дотор зуун сая доллараас дээш хэмжээний мөнгө угаалтыг 4 удаа илрүүлжээ. 1992 онд АНУ-ын Хар тамхитай тэмцэх зөвлөл Колумбийн хар тамхины “Кали” гэх, картелийн эсрэг

¹⁰¹ Өнөөдөр сонин. 2004. “Банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжиж мөнгө угаагддаг” нийтлэл

¹⁰² Peter Lilley. “DIRTY DEALING” London., 2000., 12-р тал

¹⁰³ Г.Арсланхуяг. Мөнгө угаах гэмт хэргийн олон улсын нөхцөл байдал ба эрүүгийн эрх зүйн шинж. Магистрын дипломын ажил. 2007. УБ., 12 дахь тал

¹⁰⁴ Peter Lilley. “DIRTY DEALING” London., 2000., 12-р тал

¹⁰⁵ Клаус Коттке. “Грязные деньги” М., 1998., 102-р тал

¹⁰⁶ Право. “Отмывание денег и выявление доходов от преступной деятельности” М., 1997.

“Ногоон мөс Динеро” гэдэг мөнгө угаалтыг илрүүлэх хоёр ажиллагаа явуулжээ. Ажиллагааны дүнд 130 сая бэлэн мөнгө, доллар, 10 тонн кокайн, 12 тонн героин хураан авсан аж.¹⁰⁷

2002 онд Колумбын хар тамхины хаад мөн нэг хүчтэй цохилт амсчээ. Энэ нь “Касабланка” ажиллагааны үеэр АНУ-ын хууль хяналтын байгууллагууд 150 сая доллар, 2 тонн кокайн, 4 тонн марихуан хураасан ба хар тамхины хаадын мөнгө угаалтын ажиллагаа хэрхэн хялбар явагддаг нь илэрсэн юм.¹⁰⁸ Мөнгө угаагчид эхлээд хар тамхинаас олсон бэлэн мөнгийг тусгай зарлагууд Колумбаас Лос Анжелс дахь дансанд тушааж тэндээс мөнгө нь Мексикийн банкууд руу шилждэг. Энд банкны ажилтнууд мөнгийг угаахад туслаад эргээд Лос Анжелс руу шилжүүлдэг байжээ.

Ажиллагааны үеэр тэдгээр банкны 22 төлөөлөгч баригдсан юм. Гэвч мөнгө угаагчидтай тэмцэгчид гэмт хэргийн өртөнцийн жилийн эргэлтийн аравны нэгд ч хүрэхгүй хөрөнгийг хураан авдаг нь тэмцэл төдийлөн үр дүнд хүрэхгүй байгааг харуулж байна.¹⁰⁹

Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банк болон АНУ-ын төрийн департаментын гаргасан тооцоогоор дэлхий дээр угаагдаж байгаа мөнгөний хэмжээ дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2-4 хувьтай тэнцдэг, мөнгөн дүн нь 590-1500 тэрбум ам.долларт хүрсэн гэсэн тооцоо байна. Эл 590 тэрбум ам доллар гэдэг нь Испанийн ДНБ-ний хэмжээтэй тэнцүү байгаа юм.¹¹⁰

2003 оны байдлаар Чехийн ҮНБ-ний 10% далд эдийн засгийн хүрээнд эргэлдэж байсан (Horspordarske Noviny), жил бүр Мексикээс 30 тэрбум ам доллар хар тамхи АНУ-д хүрдэг (Chicago tribune), жил бүр Польшид 2 тэрбум орчим ам доллар угаадаг (National bank report), Орос Улсад сүүдрийн эдийн засгийн эзлэх хувь 25-50 хувь (TACIS), Оросын Дотоод хэргийн яам болон Эдийн засгийн яамны тооцоогоор сүүлийн 5 жилд 50-250 ам доллар хууль бусаар барууны банкуудад шилжсэн (Interfax News Agency), Швейцарт жил тутам 500 тэрбум ам доллар угаагддаг (Swiss Finance Ministry), Белорасуын ҮНБ-ий 30 хувьтай тэнцэх мөнгө тэнд угаагддаг (European Humanities University), Колумбад 2,7 тэрбум ам доллар угаагддаг (BBC Monitoring Service), АНУ-ын далд эдийн засаг ҮНБ-ий 7-10 хувьтай тэнцүү (Sunday Telegraph), дэлхийд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний үнийн 2-5 хувь буюу 1-3 тэрбум ам.доллартой тэнцүү мөнгө угаагддаг (Dow Jones News) гэх мэтээр дэлхийн хэвлэлүүдэд мэдээлэгдэж байснаас үзэхэд бохир мөнгөний угаалтын цар хүрээ мэдрэгдэнэ.¹¹¹

Сүүлийн 10 жилд буюу 2002-2012 онуудад энэ байдалд дүгнэлт хийж, улмаар дэлхий нийтээрээ мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх улс орнуудын хууль сахиулах болон санхүүгийн байгууллагын хамтын ажиллагаа зохион байгуулах, мөнгө угааж болох сонирхлын хүрээг олж тогтоох, тандан судлах, мөнгө угаах ажиллагааны тухай дэлхийн хэмжээний мэдээллийн бааз үүсгэх, угааж байгаа мөнгөний урсгал зэргийг тогтоох талаар нэлээд судалгааны ажил явуулсан билээ.

НҮБ, “Олон улсын зохицуулалтын банк” зэрэг олон улсын байгууллага 1980 оноос мөнгө угаах гэмт хэрэгт анхааралаа хандуулж хүний нийгэм дэх хүмүүнлэг бус зүйлсийг устгах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үүднээс 1988 оны 12-р сарын 19-нд Вена хотноо “Хар тамхи, сэтгэцэд

¹⁰⁷Х.Х.Карнер. Э.Дах. “Отмывание денег” М., 1996

¹⁰⁸Peter Lilley: “DIRTY DEALING” London., 2000., 12-р тал

¹⁰⁹В.А.Никулин Отмывание Грязных денег уголовно-правовая характеристика и проблемы соучастия. М.2001

¹¹⁰ “Мөнгө угаах үйл ажиллагааны тухай танилцуулга” Монгол банк., УБ., 2004.

¹¹¹ Зууны мэдээ., 2004., 3., 19., №63., Мөнгө угаах гэж юу вэ? нийтлэл. Л.Баттогтох

нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай” олон улсын конвенцийг Вена хотноо баталсан юм. Энэ конвенцод мөнгө угаахыг зөвхөн хар тамхи, мансууруулах бодисыг худалдаалах замаар олсон мөнгийг эргэлтэд оруулах гэж үзсэн байна.¹¹²

1999 онд “НҮБ”-ын Вена дахь салбарт “Хар тамхины хяналт ба гэмт хэрэгтэй тэмцэх газрыг байгуулсан” байна. Энэ газар нь хар тамхины эсрэг төсөл, олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, санхүүгийн болон мөнгө угаах гэмт хэргүүдтэй тэмцэхэд анхаарлаа хандуулдаг. Мөн онд Базелийн конвенцод банкны талаар авч заасан. Манай улс 2001 оны 1-р сарын 5-ны өдөр энэ конвенцод нэгдэн орсон.¹¹³ 1990 оны 11-р сарын 8-нд Страсбург хотноо Европын Холбооноос “Гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, олсон орлогыг хураах тухай” конвенцийг баталсан бөгөөд энэ конвенцод мөнгө угаах гэсэн ойлголтыг дэлгэрүүлж хар тамхи, мансууруулах бодисын наймаа төдийгүй бусад гэмт үйлдлийн замаар олсон орлогыг мөнгө угаах гэмт хэрэг гэж үзсэн.¹¹⁴

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭР БЭЛТГЭСЭН БУЮУ ЗАВДСАН ҮЙЛДЭЛД ЯЛ ОНОГДУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ ГАДААД ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬИГЭМТ ХЭРГИЙН УРЬДЧИЛСАН ҮЕ ШАТНЫТАЛААРХ ЭРХ ЗҮЙНЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

С.Соёмбо-Эрдэнэ

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр
шүүхийн шүүгч, хууль зүйн магистр

Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулахдаа гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ, завдалт төгссөн эсэх, бэлтгэсэн буюу завдсан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэргээ туйлд нь хүргэж чадаагүй нөхцөл байдлыг харгалзана” гэж хуульчилсан явдал төгссөн гэмт хэрэгт оногдуулах ялаас төгсөөгүй гэмт хэрэгт оногдуулах ял хөнгөн байхыг зохицуулсан ач холбогдолтой юм.

Гэмт хэргийн урьдчилсан үе шатанд хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдэхэд уг үйлдэл гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсаны аль нь болохыг тогтоохоос гадна уг этгээдийн бэлтгэсэн, завдсан хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ, үйлдлээ туйлд нь хүргээгүй шалтгааныг харгалзан оногдуулах хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох шаардлагатай.¹¹⁵

Гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэрхэмжээ гэдэг бол юуны өмнө төгссөн буюу төгсөөгүй завдалтын үед их илэрдэг.

Төгссөн завдалтын үед гэмт этгээд гэмт хэрэг үйлдэх санаагаа бүрэн хэрэгжүүлсэн гэж итгэсэн байдаг бол төгсөөгүй завдалтын үеийн санааны хэрэгжилт нь төгсөөгүй завдалтын санааны хэрэгжилтийн хэр хэмжээнээс хавьгүй их аюултай.

¹¹² “Олон улсын санхүүгийн гэмт хэргийн эсрэг IV хурлын тухай” материал., Монгол банк., УБ., 2004

¹¹³ Олон улсын санхүүгийн гэмт хэргийн эсрэг IV хурлын тухай” материал., Монгол банк., УБ., 2004

¹¹⁴ Л.Мөнхтуяа “Олон улсын эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал” УБ., 2000

¹¹⁵ А.Няаа. Аодолгоо агуу. ОА., 2002. 92 аад дүг.

Үйлдлээ туйлд нь хүрээгүй шалтгаан гаднын болон гэмт этгээдийн сэтгэхүйн өөрчлөлт, хэрэглэсэн багаж зэвсгийн чанар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж болно.

Улсын дээд шүүхийн 2006 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийг тайлбарлах тухай” 9 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн “Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн...завдсан” гэдэгт мөн хуулийн 31, 32 дугаар зүйлд тус тус зааснаар тодорхойлох бөгөөд “Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ” нь Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэсэн ангиллаас хамаарна. Мөн зүйлийн “...гэмт хэргээ туйлд нь хүргэж чадаагүй нөхцөл байдлыг харгалзана” гэдгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийн явцад тухайн этгээд гэмт үйлдлээ туйлд нь хүргэж чадаагүй шалтгаан, нөхцөлийг тогтоох, энэ талаар үндэслэл бүхий дүгнэлт хийсэн байхыг ойлгоно”¹¹⁶ гэж тайлбарлажээ.

2002 оны Эрүүгийн хуулиар 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэг оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын хоёрны нэгээс хэтрэхгүй байна” гэж заасныг 2008 оны 2 дугаар сарын 1-ний Эрүүгийн хуулийн өөрчлөлтөөр “Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд оногдуулах ялын доод хэмжээг...” гэж өөрчлөн найруулсан юм. Эндээс харахад 2002 оны Эрүүгийн хуулиар бол хүнийг санаатай алахад бэлтгэсэн этгээд 7 жил 6 сарын хугацаатай хорих ялаар шийтгэгдэхээр байсан бол одоо 5 жилийн хугацаатай ял шийтгэгдэхээр болсон нь бэлтгэсэн, завдсан үйлдэл нь төгссөн гэмт хэрэгтэй харьцуулбал нийгмийн хор аюулаар үлэмж бага гэдгийг хууль тогтоогч харгалзсан энэрэнгүй ёсны зарчимд нийцсэн зохицуулалт болсон.¹¹⁷

Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Гэмт хэрэгт завдсан үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна” гэж завдсан үйлдэлд ял оногдуулах үндэслэл, журмыг хуульчилсан. Мөн зүйлийн 60.2, 60.3 дахь хэсэгт заасан “...аль хүнд төрлийн ял...” гэдэгт мөн хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсэгт заасан сонгох ялын аль хүнд төрлийн ялыг ойлгоно. Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэгт заасан сонгомол ялын аль хүнд төрлийн ялыг тодорхойлохдоо шүүх зөвхөн үндсэн ялын чанартай хэрэглэдэг торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялын хүрээнд, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан дарааллыг баримтлах нь зүйтэй. Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэгт сонгомол ял байхгүй тохиолдолд мөн хуулийн ерөнхий ангийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.3 дахь хэсэгт заасан журмыг баримтлан хувилж, тухайн зүйл хэсэгт заасан ялын доо дхэмжээнд тохируулан ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.3 дахь хэсэгт заасан “...төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний хоёрны нэгээс... гуравны хоёроос хэтрэхгүй байна” гэдгийг мөн хуулийн тухайн зүйл хэсэгт заасан торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялын доод хэмжээнээс хувилан тооцож хэрэглэх шаардлагатай. Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсэгт онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд 15 жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүй гэж заасан нь энэрэнгүй ёсны биелэл юм.

Гадаадын эрүүгийн эрх зүйн онолд гэмт хэрэгт бэлтгэх, гэмт хэрэг үйлдэхээр завдахыг гэмт хэрэг үйлдэгдэх бааз суурь болдог учир эрүүгийн эрх зүйн бие даасан

¹¹⁶ᠮᠠᠨᠠᠶᠢ ᠣᠪᠨᠠᠶᠢ ᠠᠶᠢᠨ ᠰᠡᠭᠡᠳᠡᠢ ᠳᠠᠳᠠᠨᠠᠶᠢ ᠶᠢᠳᠠᠳᠠᠶᠢ. ᠒᠕.,2008. 39 ᠠᠶᠢᠳᠠᠶᠢ.

¹¹⁷ᠶᠢᠳᠠᠳᠠᠶᠢ ᠳᠠᠳᠠᠶᠢ, ᠶᠢᠳᠠᠳᠠᠶᠢ ᠠᠠᠶᠢᠳᠠᠶᠢ ᠰᠡᠳᠠᠳᠠᠶᠢ ᠳᠠᠳᠠᠶᠢ ᠶᠢᠳᠠᠳᠠᠶᠢ. ᠒᠕.,2008. 12 ᠠᠶᠢᠳᠠᠶᠢ.

судлагдахуун гэж үздэг. Энэ талаар тусгайлан судалсан АНУ-ын эрдэмтэн Дж.Флетчер, ОХУ-ын эрдэмтэн А.В.Наумов нар “гадаад орнуудын эрүүгийн эрх зүйд гэмт хэрэгт бэлтгэх, ялангуяа завдах нь суурь эрх зүйн зөрчил, харин төгссөн гэмт хэргүүд, тухайлбал, хүн алах, хүний бие махбодид гэмтэл учруулах, хорлон сүйтгэх нь санаатайгаар эдгээр гэмт хэргийг үйлдэхээр завдсаны нэг ёсны үр дагавар гэсэн номлол ноёрхдог”¹¹⁸ гэж үзсэн байдаг.

Энэ номлол нь:

а)гэм буруутай этгээдийн хувийн байдал дээр суурилсан гэм буруу (субъектэд эхлээд гэмт

хэрэг үйлдэх гэмт санаа төрж, дараа нь түүнийгээ бодит үйлдлээр хэрэгжүүлдэг);

б)гэмт халдлага (гэмт халдлагыг таслан зогсоохгүй бол хор уршиг зайлшгүй учирна) гэсэн

хоёр үзэл санааны нэгдэл юм.

Энэ номлолыг Англо-саксоны эрүүгийн эрх зүй бүхэлд нь хүлээн авсан.

Ром-Германы эрх зүйн тогтолцоотой Франц, Орос, Германы эрүүгийн эрх зүйд:

а)гэмт хэрэгт бэлтгэх;

б)гэмт хэрэг үйлдэхийг завдах;

в) гэмт хэрэг үйлдэж дуусгах гэсэн санаатай гэмт хэргийн гурван үе шатыг хүлээн зөвшөөрдөг.¹¹⁹

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэрэгт бэлтгэх тухай хэм хэмжээ байдаггүй боловч Эрүүгийн хуулийн тусгай ангид эх орноосоо урвах (§82), Зэвсэгт бүлэг байгуулах (§127), Гэмт бүлэглэл байгуулах (§129), Мөнгөн тэмдэгт, төлбөрийн хэрэгслийг хуурамчаар үйлдэх (§149) зэрэг хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд (22-р зүйл) “Гэм буруутай этгээд гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлж эхэлсэн боловч төгсгөлд нь хүрээгүй байхыг завдах гэнэ”¹²⁰ гэж хуульчилсан. Энд ямар шалтгаанаар гэмт хэргийг төгсгөлд нь хүргээгүйг дурдаагүй нь ойлгомжгүй байна.

ОХУ-ын Эрүүгийн хуульд (29-р зүйл) “Төгсөөгүй гэмт хэрэг гэдэг нь гэмт хэрэгт бэлтгэх, завдах үйлдэл юм” гэсэн тодорхойлолт өгсөн. 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх зэвсэг, хэрэгслийг эрж олох, хийж бэлтгэх, хамтран оролцогчдыг сонгох, тэдэнтэй гэмт хэрэг үйлдэх талаар тохиролцох болон гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай бусад нөхцөлийг санаатай бүрдүүлсэн. Энэ тохиолдолд гэмт хэрэг гэм буруутай этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас бүрдэл төгсөөгүй байхыг гэмт хэрэгт бэлтгэх” гэж тодорхойлсон. Хүнд, онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээнэ.¹²¹

Барууны эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийн урьдчилсан үе шатыг бэлтгэх, завдах гэсэн хоёр төрөлд ангилдаг нь түгээмэл юм. Голланд, Болгар, Польш Улсуудын эрүүгийн хуулиас бусад орны хуульд гэмт хэрэгт бэлтгэх тухай хэм хэмжээ тусгагдаагүй байна.

Швейцарийн Эрүүгийн хуульд гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт байдаггүй.¹²²

Польшийн Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн §1-д “Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх гэж гэм буруутай этгээд эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийх

¹¹⁸ А.А.Овчаров, А.А.Иванов. Институты правосудия в странах СНГ. М., 1998. 442 аадуу дээр.

¹¹⁹ А.А.Овчаров, А.А.Иванов. Правосудие в странах СНГ. М., 1998. 102-106 аадуу дээр.

¹²⁰ Овчаров А.А. ОД. М., 2000. 17 аадуу дээр.

¹²¹ Овчаров А.А. ОД. М., 2006. 54 аадуу дээр.

¹²² Овчаров А.А. ОД. М., 1997. 109 аадуу дээр.

урьдчилсан нөхцөл бүрдүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэх төлөвлөгөө зохиох, бусад хүмүүстэй хуйвалдах, зэвсэг хэрэгсэл олж бэлтгэх, гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой мэдээлэл цуглуулах, гэмт хэрэг үйлдэх боломжийг судлах зэрэг үйл ажиллагааг хэлнэ”. Энэ зүйлийн §2-т “Эрүүгийн хуульд заасан тохиолдолд бэлтгэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”¹²³ гэж тус тус заасан.

Голланд Улсын Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Санаатайгаар зэвсэг, хэрэгсэл, мөнгө, төлбөрийн хэрэгсэл, эд зүйл, бичиг баримт, бусад зүйлийг гэмт хэрэг үйлдэх үедээ ашиглах зорилгоор бэлтгэсэн байхыг гэмт хэрэгт бэлтгэсэн гэж үзнэ”, энэ зүйлийг 2 дахь хэсэгт “Бэлтгэсэн гэмт хэрэгт оногдуулах ялын талаас дээшгүй хувийг бэлтгэсэн үйлдэлд оногдуулна”¹²⁴ гэж заасан.

Зүүн өмнөд Азийн орнуудын эрүүгийн хуульд гэмт хэрэгт бэлтгэх тухай тусгай хэм хэмжээ хуульчлагдсан байдаг. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 15, 16 дугаар зүйлүүдэд гэмт хэрэгт бэлтгэх гэсэн нэр томъёо хэрэглэгддэг боловч, агуулгыг нь тодорхойлоогүй. Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын түвшин, хор уршгийн хүнд, хөнгөнөөс хамаарна гэсэн ерөнхий хэм хэмжээ БНХАУ-ын хуульд байдаг. Мөн хуулийн 22 дугаар зүйлд гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах буюу ялаас чөлөөлөх боломжийг хуульчилжээ.¹²⁵

Вьетнам Улсын Эрүүгийн хуульд хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.¹²⁶

“Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг хэрэгжүүлж эхэлсэн байх нь завдалтын мөн чанарыг илэрхийлнэ” гэсэн номлол барууны эрүүгийн эрх зүйд нэгэнт дэлгэрсэн юм. Завдалтын тухай хэм хэмжээ анх удаа 1810 оны Францын Эрүүгийн хуульд тусгагдсан. Энд гэмт хэргийг үйлдэж эхэлсэн боловч гэм буруутай этгээд өөрөө зогсоосон эсвэл түүний хүслээс үл хамаарах шалтгаанаар туйлдаа хүрч чадаагүй, сайн дураараа татгалзаагүй байхыг завдалт гэж сонгодог утгаар нь хуульчилсан нь өнөө хүртэл агуулга нь алдагдаагүй явж иржээ.¹²⁷ Францын Эрүүгийн хуулиар завдалтад бүх тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин эрүүгийн зөрчилд завдсан бол зөвхөн хуульд заасан тохиолдолд хариуцлага яригдана. Энэ улсын хуульд зааснаар үйлдэгдээгүй гэмт хэрэг завдалтын хоёр дахь төрөл болдог. Энд ашиггүй объектод, бүтэлгүй зэвсгээр завдах тухай заасан байдаг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд “Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг буй болгож эхэлсэн боловч энэ нь туйлдаа хүрээгүй бол завдсан гэж үзнэ” гэж заасан. Германы эрүүгийн эрх зүйд завдалтыг:

а) гэмт хэрэгт завдах;

б) эрүүгийн зөрчилд завдах гэж ангилаад гэмт хэрэгт завдсан бол эрүүгийн хариуцлага хүлээнэ

гэж хуульчилсан.

Хуульд шууд заагаагүй бол эрүүгийн зөрчилд завдсанд хариуцлага хүлээлгэхгүй. Завдсан үйлдэлд хэрэглэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх эрхийг шүүгч эдэлнэ.¹²⁸

Голландын эрүүгийн хуульд завдалтын тодорхойлолт өгөөгүй. Харин завдалтын бүх төрөлд ял оногдуулахдаа завдсан гэмт хэрэгт оногдуулахаар заасан

¹²³ Оἰκτεῖταιὺς εἰσαέν Δάντιαεεεεε ἱεῦσα. Ἰ., 1998. 11 αὐθ δαε.

¹²⁴ Оἰκτεῖταιὺς εἰσαέν Αἰεεαῖαεε. Νἱά., 2001. 175-176 ἀαδῦ δαε.

¹²⁵ Ἰ.Ο.Αοῖαδδδδδ, Ἰ.Ο.Αοῖαδδδδδ. ἱαῖα οἰκτεῖταιῖα γαεῖνῖααδδδδδδδδδ εἰδδ. Αἱνῖααδδδδδδδ εἰδδδδ. 1988. 110. 7 ἀαδῦ δαε.

¹²⁶ Ἰ.Α.Εααῖα, Α.Α.Εῖδδδδδδδ. Οεαα.νῖδδ. 189 ἀαδῦ δαε; Αἱγ ×ε Οε. Οἰκτεῖταιὺς εἰσαέν ΝΔΑ. 1999. 106 ἀαδῦ δαε.

¹²⁷ Ἰ.Α.Εδδδδδδδ. ἱνῖαῖαῖα +αδδδδ Οἰκτεῖταιῖα εἰσαένδδδδδδδδδδδδδ. Ἰ., 1996. 40 αὐθ δαε.

¹²⁸ Οἰκτεῖταιὺς εἰσαέν ΟΔΑ. Ἰ., 2000. 17 ἀαδῦ δαε.

ялын гуравны нэгийг хэрэглэнэ. Завдсан үйлдэлд төгссөн гэмт хэргийн нэгэн адил нэмэгдэл ял оногдуулж болно.¹²⁹

Дани Улсын Эрүүгийн хуулийн “Завдалт ба хамтран оролцох” гэсэн бүлэгт завдалтын тухай хэм хэмжээ тусгажээ. Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийг үйлдэхэд болон үйлдэхэд нөлөөлөхөд чиглэгдсэн үйлдлийг завдалт гэж үзнэ. Энэ тохиолдолд гэмт хэрэг туйлдаа хүрээгүй байх ёстой”¹³⁰ гэж завдалтыг хуульчилсан.

Польш, Болгар Улсын Эрүүгийн хуульд завдалтыг ОХУ, манай Эрүүгийн хуульд заасантай төсөөтэй агуулгаар хуульчилсан.¹³¹

Испани Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн гэмт этгээдийн үйлдэл гэмт хор уршигт хүргэх ёстой байсанч түүний хүсэл зоригоос шалтгаалахгүй нөхцөл байдлаас тухайн хор уршиг учраагүй бол завдалт гэж үзнэ”¹³² гэж заасан. Испанийн Эрүүгийн хуульд зааснаар амь бие, эрүүл мэндийн болон өмчийн эсрэг гэмт хэргүүдийг үйлдэхээр завдсан бол ял оногдуулахаар тусгайлан заасан.

Аргентин Улсын Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйлд “Гэмт этгээд гэмт хэрэг үйлдэхээр шийдэж, түүнийгээ эхэлсэн боловч түүний хүсэл зоригоос хамаарахгүй шалтгаанаар төгсгөлд нь хүргэж чадаагүй бол завдсан гэж үзэж хуулийн 44 дүгээр зүйлд заасан ял оногдуулна” гэж заасан. Завдагч этгээд гэмт хэргийг туйлд нь хүргэхээс сайн дураараа татгалзсан бол ял хүлээхгүй. Завдсан үйлдэлд оногдуулах ял нь 44 дүгээр зүйлд зааснаар завдсан гэмт хэрэгт оногдуулах ёстой ялын тэн хагасаас хэтрэхгүй хэмжээтэй байна.¹³³

Турк Улсын Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэг бүхэлдээ гэмт хэрэгт завдах үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Энэ хуулийн 61 дүгээр зүйлд “Хэн нэгэн этгээд гартаа дайралдсан зүйлийг ашиглан санаатай гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйл ажиллагаа явуулсан боловч түүнээс хамаарахгүй хөндлөнгийн шалтгааны улмаас дуусгаж чадаагүй бол завдалт болох бөгөөд хуульд заасан бол 15 жилээс 20 жил хүртэл хугацаагаар хорих буюу бүх насаар нь хорьж шийтгэнэ” гэж заасан нь завдах үйлдэлд хэргийн хүнд, хөнгөнөөс хамаарахгүйгээр хүнд ялоногдуулахаар байна.¹³⁴

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ТҮҮНИЙ ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГТ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

¹²⁹ Óáñëíáíúé êñááëñ Áñëëáíáëë. Ñíá.,2001. 175 ääüü òàë.

¹³⁰ Óáñëíáíúé êñááëñ Ááíëë. Ñíá.,2001. 26 ääüü òàë.

¹³¹ Óáñëíáíúé êñááëñ Ðáñíóáëëëë Áñëááðëë. Ñíá.,2001. 35 ääüü òàë; Óáñëíáíúé êñááëñ Ìñëüðëë. Ì.,1996. 10-12 ääüü òàë.

¹³² Óáñëíáíúé êñááëñ Ëñíáíëë. Ì.,1998. 15 ääüü òàë.

¹³³ Óáñëíáíúé êñááëñ Áðááíðëíü. Ñíá.,2003. 56 ääüü òàë

¹³⁴ Óáñëíáíúé êñááëñ Õóðüëë. Ñíá.,2003. 68 ääüü òàë

Бибишийн Одхүү

Баянхонгор аймгийн прокурор, хууль цаазын
иргэмжит зөвлөх, ХСИС-ын магистрант

Удирдагч: ХСИС-ийн Удирдлагын сургуулийн захирал, хууль
зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Б.Бат-Эрдэнэ

Аливаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллага өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган биелүүлэхэд сахилга бат, ёс зүй, хариуцлага, хяналт түүний удирдлага, зохион байгуулалт чухал үүрэгтэй бөгөөд хэдий чинээ энэ бүх нөхцөл байдлуудын уялдаа холбоо төгс боловсронгуй байна, төдий чинээ зөрчил, дутагдал бага гарч ажлын гүйцэтгэл, үр бүтээл чанартай байж аль болох бага зардлаар богино хугацаанд өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган биелүүлдэг.

Тэгвэл Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт¹³⁵ нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршдог. Энэхүү зорилт нь түүнийг хангахад чиглэсэн олон талт үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг бөгөөд үүнд прокурорын хяналт нь онцгой чухал байр суурийг эзэлнэ.

Прокурорын хяналт, түүний мөн чанар, ЭБША-ны чиг үүрэгт прокурорын хяналтын эзлэх байр суурийн талаар судлахын тулд юуны өмнө эхлээд прокурорын хяналтын тухай ойлголтыг авч үзэх нь чухал юм.

“Прокурорын хяналт”-ыг хэл бичгийн найруулга зүйн бүтцээс нь авч үзвэл “прокурор”, “хяналт” гэсэн хоёр үгний нийлбэрээс бүтэж байгааг харагдуулах авч энэ нь нэг талаас үйл ажиллагааг хэрэгжүүлэгч субъект, нөгөө талаас түүний гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл, хэлбэрийн тухай ойлголтыг багтаасан гүн гүнзгий агуулгатай ойлголт байна.

Тэгвэл энд яригдаж байгаа субъект **“Прокурор гэж хэн бэ?”** гэсэн асуулт зүй ёсоор тавигдана.

“Прокурор” гэдэг нь “санаа тавих”, “хэрэг мөрдөх”, “хангах”, “бэхжүүлэх”, “арилгах”, “халамжлан сургах”, “хянан сахиулах”, “урьдчилан сэргийлэх”, “удирдах” гэсэн олон салаа утгыг агуулсан “Procurare” хэмээх латин үгнээс гаралтай бөгөөд бүр ХҮ зууны эхээр Францад¹³⁶ үүссэн гэж үздэг байна¹³⁷.

Хууль зүйн талаас нь авч үзвэл Монгол Улсын ЭБШХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.20. дахь хэсэгт “прокурор” гэж бүх шатны прокурорын газрын прокурорыг хэлнэ” гэж нэр томъёоны тодорхойлолтыг өгч мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1. дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцоно” гэж заагаад мөн хуулийн 193 дугаар зүйл, 195 дугаар зүйлүүдэд прокурорт хуулиар олгосон эрх хэмжээг нь тусгасан боловч **“прокурор” гэгч өөрөө ямар албан тушаалтан юм бэ?** гэсэн тодорхойлолт нь огт тусгагдаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж түүний үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон байна.

¹³⁵ Монгол Улсын ЭБШХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1. дэх хэсэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт. Эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59>

¹³⁶ анх эзэн хааны хамгаалагч гэсэн утгаар үүссэн байдаг.

¹³⁷ В.И.Рохлин. Прокурорын хяналт ба төрийн хяналт: түүх, хөгжил, ойлголт, харьцаа холбоо. Санкт петербург. 2003. 305 хуудас. (орос хэл дээр).

Мэдээж төрийн нэрийн өмнөөс ЭБША-г хэрэгжүүлэхэд оролцож байгаа, энэ үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд өөрт тусгайлан олгогдсон эрх бүхий этгээд болохын хувьд төрийн албан тушаалтны ангилалд хамрагдах нь зүйн хэрэг. Харин чухам ямар эрх бүхий албан тушаалтан юм бэ? гэдгийг Монгол Улсын ЭБШХ-ийн 5-р зүйлд¹³⁸ тусгаагүй байна.

Тэгвэл Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн тусгай албан тушаалд “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал хамаарна” гэж тодорхойлсноос дүгнэхэд прокурор нь төрийн тусгай албан тушаалтны ангилалд хамаарагдахаар байна¹³⁹.

Мөн 2002 оны 7 дугаар сарын 4-ны өдөр батлагдсан “Прокурорын байгууллагын тухай хууль”-д прокурорын байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, прокурорын эрх хэмжээ, хяналтын хэлбэр, прокурорын байгууллагын боловсон хүчин, прокурорын нийгмийн баталгаа гэх мэт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л байдлыг хуульчлан баталгаажуулсан боловч мөн л “прокурор нь ямар албан тушаалтан юм бэ?” гэдэгт тодорхойлолт өгөөгүйгээр түүний эрх зүйн байдлыг хуульчлан баталгаажуулсан нь учир дутагдалтай.

Бидний үзэж байгаагаар, аливаа субъектын эрх зүйн байдал, эрх хэмжээ, үүрэг, хариуцлагын талаар авч үзэхдээ эхлээд уг субъект хэн болохыг тодорхойлж, дараа нь түүний эрх хэмжээ, хүлээх үүрэг, хариуцлагын талаар авч үзэх нийтлэг зарчим байх ёстой.

Судалгааны ажлыг үндэслэлтэй болгох үүднээс бусад орны хууль тогтоомжид “прокурор” гэгч субъект (*албан тушаалтан*) хэн болохыг тодорхойлж тусгасан эсэх талаар дагнасан судалгааг явуулахад **эхлээд** уг албан тушаалтан (*тухайлбал: прокурор*) хэн болохыг тодорхойлж, **дараа нь** түүний эрх хэмжээг хуульчлан баталгаажуулж өгсөн байна. Үүнд:

1. ОХУ-ын ЭБШХ-ийн 5 дугаар зүйлийн 31 дэх хэсэгт “Прокурор – ОХУ-ын Ерөнхий прокурор, түүний удирдлагад байгаа прокурорууд болон тэдгээрийн орлогчид, мөн Прокурорын байгууллагын тухай Холбооны хуульд зааж тусгай эрх олгогдсон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бусад албан тушаалтан”, гээд мөн хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Улсын яллагч – эрүүгийн хэргийн талаар шүүхэд төрийн нэрийн өмнөөс улсын ялыг хэрэгжүүлэгч прокурорын байгууллагын албан тушаалтан” гэж тодорхойлсон байна.

Мөн хуулийн 37 дугаар зүйлд “Прокурор нь төрийн нэрийн өмнөөс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд эрүүгийн ялыг хэрэгжүүлэх мөн түүнчлэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавих хуулиар олгогдсон тусгай эрх бүхий албан тушаалтан” гэж тодорхойлоод түүний бүрэн эрхийг хуульчлан баталгаажуулж өгсөн байна¹⁴⁰.

2. Бүгд Найрамдах Беларусь Улсын ЭБШХ-ийн 5 дугаар бүлгийн “ЭБША-г хэрэгжүүлэгч төрийн байгууллага, албан тушаалтан”-ны ангилалд прокурорыг багтаан мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор нь өөрийн бүрэн

¹³⁸ Монгол Улсын ЭБШХ-ийн 5 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт. Энэ хэсэгт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтан болохыг тодорхойлж харин прокурорыг зөвхөн бүх шатны прокурорын газрын прокурор гэсэн нь чухам ямар эрх бүхий албан тушаалтан болох нь тодорхойгүй байна.

¹³⁹ Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл. Төрийн тусгай албан тушаалтан. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/487?lawid=487>

¹⁴⁰ ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Москва: “Омега-Л” хэвлэлийн газар. 2011. 217 хуудас. (*орос хэл дээр*).

эрхийн хүрээнд төрийн нэрийн өмнөөс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг болон шүүхэд улсын ялыг хэрэгжүүлэгч албан тушаалтан” гэж тодорхойлоод 2 дахь хэсэгт “Прокурор нь шүүхийн өмнөх шатанд хууль ёсыг сахиулахад тавих хяналтын талаархи өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хараат бус байж зөвхөн хуульд захирагдана¹⁴¹” гэж түүнийг ямар албан тушаалтан болохыг тодорхойлж түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх хэмжээг тусгайлан зааж өгчээ.

3. Эрх зүйн тогтолцоо ойролцоо тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэх, түүний нотолгооны эрх зүйн зохицуулалт ижил бусад улс, тухайлбал Бүгд Найрамдах Таджикистан Улс¹⁴², Бүгд Найрамдах Казахстан Улс¹⁴³, Бүгд Найрамдах Молдав Улсын¹⁴⁴ ЭБШХ-д мөн л прокурорыг төрийн нэрийн өмнөөс улсын ялыг хэрэгжүүлэгч, ЭБША-нд хууль ёсыг хэрэгжүүлэхэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан болохыг тодорхойлж түүнчлэн албан тушаалтан болохын хувьд өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх хэмжээг нь хуульчлан баталгаажуулж өгсөн байна.

Харин Монгол Улсын ЭБШХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1. дэх хэсэгт “Прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцоно” гэж зааснаас дүгнэлт хийхэд прокурор нь:

1) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих;

2) шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох эрх бүхий этгээд болох нь харагдаж байна.

Иймд **нэг талаас** прокурор нь ЭБША-г хэрэгжүүлэхэд оролцож байгаа эрх бүхий албан тушаалтан мөн болохыг тодорхойлох, **нөгөө талаас** эрх зүйн зохицуулалтыг бусад орны жишигт хүргэх зайлшгүй шаардлагын үүднээс дээрхи заалтыг:

“Прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас явуулж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих түүнчлэн шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцох эрх бүхий албан тушаалтан” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Одоо “хяналт”-ын тухай авч үзье.

Монгол хэлний тайлбар толь бичигт хяналтыг: 1) шалгах зорилго бүхий үйл ажиллагаа¹⁴⁵; 2) ажлын гүйцэтгэлийн явцад хийгдэж буй иж бүрэн шалгалт¹⁴⁶ гэж тодорхойлсон бол орос хэлний тайлбар толь бичигт хяналтыг хамгийн өргөн утгаар нь: 1) шалгалт, мөн шалгахын тулд хийгдэж буй ажиглалт; 2) шалгалтыг

¹⁴¹ Бүгд Найрамдах Беларусь Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Цахим эх сурвалж, холбоос: <http://pravo.kulichki.com/vip/upk/00000003.htm#g5>

¹⁴² БНТаджикистан Улсын ЭБШХ-ийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт прокурорыг “Төрийн нэрийн өмнөөс улсын ялыг хэрэгжүүлэх, ЭБША-ны бүх шатанд хуулийн хэрэгжилтийг хангах эрх бүхий төрийн албан тушаалтан” гэж тодорхойлсон байна. Цахим эх сурвалж, холбоос: <http://yandex.ru/yandsearch?lr=213&text=упк+республики+таджикистан>

¹⁴³ БНКазахстан Улсын ЭБШХ-ийн 62 дугаар зүйлд “Прокурор нь шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа, хялбаршуулсан шүүхийн өмнөх шатны болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа мөн түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд хууль ёсыг сахиулах, хяналт тавих эрх бүхий албан тушаалтан” гэж тодорхойлсноос гадна мөн “Эрүүгийн хэргийг шүүхээр хэлэлцэхэд оролцож ялыг хэрэгжүүлэх замаар төрийн ашиг сонирхлыг төлөөлөх улсын яллагч” гэж тодорхойлж түүний эрх хэмжээг хуульчлан баталгаажуулж өгчээ. Цахим эх сурвалж, холбоос: http://online.zakon.kz/Document/?doc_id=1008442#sub_id=620000

¹⁴⁴ БНМолдав Улсын ЭБШХ-ийн 51 дүгээр зүйлд прокурорыг мөн дээрхи байдлаар албан тушаалтан гэж тусгасан. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.pravo.org.ua/files/pdf>

¹⁴⁵ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь бичиг. УБ., 1966. 578 дах тал.

¹⁴⁶ Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь бичиг. УБ., 2009. 917 дах тал.

хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага; 3) шалгалтыг хэрэгжүүлэгч этгээд¹⁴⁷ гэж тодорхойлжээ. Үүнээс дүгнэхэд хяналт нь гол төлөв шалгалтаар дамжиж хэрэгждэг эсвэл шалгалт нь өөрөө хяналтын нэг хэлбэр гэж дүгнэж болохоор байна.

Тэгэхээр хяналт гэдэг нь аливаа үйл ажиллагаа өмнөө тавьсан зорилго, зорилтдоо нийцэн явагдаж байгаа эсэхийг шалгалтын тусламжтайгаар тогтооох, зорилго, зорилтоосоо хазайсан буруу үйл ажиллагааг зогсоох, түүнийг гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн удирдлагын үйл ажиллагааны нэг хэлбэр юм.

Тэгвэл прокурорын хяналт нь ЭБША-ны зорилтыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааны нэг хэлбэр бөгөөд прокурорын хяналтын ойлголт, зорилго, чиглэлийн талаар олон эрдэмтэн судлаачид өөрийн байр сууриа илэрхийлсэн байдаг. Үүнд:

Оросын эрдэмтэн Н.И.Кулагин өөрийн судалгааны ажилдаа хяналтыг удирдлагын үйл ажиллагааны бие даасан чиг үүрэг гэж үзээд ЭБША-ны явцад тавих хяналт нь¹⁴⁸:

1) нэг талаас, хууль сахиулах үйл ажиллагааны системийн хамгийн үр нөлөөтэй хэлбэр, нөгөө талаас, ЭБША-г бие даан хэрэгжүүлэгч – мөрдөн байцаагчийн ажлыг шалгах цорын ганц арга;

2) ЭБШХ-ийн заалт, шаардлагад үндэслэгдэх бөгөөд зөвхөн эрүүгийн хэргийн явц байдлыг ажиглахад чиглэгдэх бус мөн мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд хууль ёсыг сахиулахад чиглэн түүний ажлыг чиглүүлэх удирдлагын нөлөөллийн хэлбэрийг өөртөө агуулдаг¹⁴⁹ гэж дүгнэсэн байна.

Тэгвэл олон улсын цахим нэвтэрхий толь бичиг (википедия)-т прокурорын хяналтыг:

Байцаан шийтгэх ажиллагаанд хууль ёсыг сахиулах, хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэх, шалгаж тогтоох, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн прокурорын байгууллагын үйл ажиллагааны нэг хэлбэр¹⁵⁰ гэж тодорхойлсон байна.

Зарим эрдэмтэн, судлаачид прокурорын хяналтыг “Төрөөс прокурорын байгууллагад тусгайлан олгосон, төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа хяналтын тусгай төрөл¹⁵¹” гэж байхад зарим нь “Үндсэн хуулийг сахиулах, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа тусгай үйл ажиллагаа¹⁵²” гэж тодорхойлсон байна.

Тэгвэл мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь ЭБША-г хэрэгжүүлэх явцад хууль ёсыг сахиулахад чиглэсэн прокурорын хяналтын нэг хэлбэр бөгөөд дээрхи тодорхойлолтуудад үндэслэн мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтыг:

¹⁴⁷ С.И.Ожегова. Орос хэлний тайлбар толь бичиг: нэмж, засварласан 26 дахь хэвлэл. Москва: “Оникс”, “Дэлхий ба боловсрол” хэвлэлийн газар. 2008. 245 дах тал.

¹⁴⁸ Зөвхөн прокурорын хяналт бус мөрдөн байцаах албаны даргын зүгээс тавих хяналт мөн энд нэг адил хамаарна.

¹⁴⁹ Н.И.Кулагин. Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албаны удирдлага: бүтэц, чиг үүргийн судалгаа /хууль зүйн докторын диссертацийн ажил. Волгоград. 1989. 208 дах тал.

¹⁵⁰ Википедия олон улсын чөлөөт нэвтэрхий толь бичиг. Цахим эх сурвалж, холбоос: <http://ru.wikipedia.org/wiki/> (орос хэл дээр).

¹⁵¹ А.Н.Агеев. Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд прокурорын хяналтыг хэрэгжүүлэх зарим асуудал. Москва. 2008. (орос хэл дээр). Цахим эх сурвалж, холбоос: <http://www.dissercat.com/content/organizatsiya-prokurorskogo-nadzora-v-stadii-vozbuzhdeniya>.

¹⁵² И.Т.Махмудов. Шуурхай эрэн сурвалжлах ажиллагаанд хууль ёсыг хэрэгжүүлэхэд чиглэсэн прокурорын хяналтын онолын үндэс ба практикийн зарим асуудал: (БНТаджикистан Улсын жишээн дээр). Москва. 2008. (орос хэл дээр). Цахим эх сурвалж, холбоос: <http://www.dissercat.com/content/teoreticheskie-osnovy-i-nauchno-prakticheskie-problemy-prokurorskogo-nadzora-za-ispolnieniem>.

“Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт гэдэг нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор прокурорт (прокурорын байгууллагад) олгогдсон тусгай эрх хэмжээний нэг төрөл бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогчдын хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсоох, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль ёсыг сахиулах, хууль ёс зөрчсөн үйлдлийг шалгаж тогтоох, түүнийг залруулах, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд гаргасан гомдол, мэдээллийг шалгах, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, шийдвэрлэх чиг үүрэг бүхий төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа”¹⁵³ гэж тодорхойлж болох юм.

Товчоор хэлбэл: “Мөрдөн байцаалтын ажиллагаанд хууль ёсыг сахиулах, хуулийг дээдлэх, хүний болон иргэний эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн эрх ашиг сонирхлыг хамгаалах явдлыг хангах чиг үүрэг бүхий үйл ажиллагаа” юм.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын онолын үндэс, мөн чанарыг тодорхойлон гаргахын тулд дараах гурван асуудалд анхаарлаа хандуулж авч үзэх нь чухал юм. Үүнд:

1. Прокурорын хяналтын чиг үүрэг ба ЭБША-ны чиг үүрэгт түүний эзлэх байр суурь

Энэ асуудлыг авч үзэхийн өмнө нь эхлээд ер нь **чиг үүрэг** гэж ямар ойлголт болохыг тодорхойлох нь чухал юм.

Чиг үүрэг гэдэг нь: 1) аливаа байгууллага, амьд организмоос өөрийн үйл ажиллагаагаа хангахад чиглэн гүйцэтгэж байгаа ажил, үүрэг; 2) ямар нэгэн зүйлийн үүрэг, ач холбогдол; 3) тодорхой хүрээний үйл ажиллагааны гүйцэтгэх үүрэг¹⁵⁴ гэж тодорхойлсон байна.

Тэгвэл Монгол Улсын ЭБША-ны чиг үүрэг нь байцаан шийтгэх ажиллагааны зорилго, зорилттой салшгүй холбоотой бөгөөд энэхүү чиг үүрэг байцаан шийтгэх ажиллагааны үндсэн чиглэл, түүний хэрэгжилт, түүнчлэн уг ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг багтаан авч үзсэн маш өргөн хүрээтэй ойлголт юм.

Энэ байдлаас дүгнэхэд ЭБША-ны чиг үүрэг нь эрх бүхий байгууллага, тодорхой албан тушаалтны ЭБШХ-ийн хүрээнд явуулах үйл ажиллагааны ерөнхий чиглэл бөгөөд энэхүү чиг үүргийг зөв хэрэгжүүлснээр ЭБША-ны зорилтыг хангаж зохих үр дүнд хүрнэ. ЭБША-ны чиг үүрэг нь:

- 1) эрүүгийн хэргийг мөрдөх;
- 2) өмгөөлөх;
- 3) яллах;
- 4) хэргийг шийдвэрлэх¹⁵⁵ гэсэн дөрвөн үндсэн чиг үүрэгтэй ба эдгээр чиг үүргүүд өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой юм. Нэг чиг үүргийн аль нэг хэсэг нь нөгөө чиг үүрэгт илрэлээ ямагт олж байдаг. Тухайлбал, эрүүгийн хэргийг бүртгэх, мөрдөн байцаах гэсэн хэлбэрээр явагддаг мөрдөх чиг үүргийг хэрэгжүүлэх явцад өмгөөлөх, яллах ба цагаатгах, нотлох баримт цуглуулах, хэргийг шүүхэд шилжүүлэх ажиллагаанууд явагдана.

Тэгвэл прокурорын чиг үүрэг (*прокурорын эрх хэмжээ*) нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

¹⁵³ Хэдийгээр мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын тухай ойлголт, түүний мөн чанар, чиг үүргийн талаар энэхүү магистрын ажилд авч үзэж байгаа боловч хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих прокурорын хяналтын тухай асуудал үүнд нэгэн адил хамааралтай.

¹⁵⁴ С.И.Ожегова. Орос хэлний тайлбар толь бичиг: нэмж, засварласан 26 дахь хэвлэл. Москва: “Оникс”, “Дэлхий ба боловсрол” хэвлэлийн газар. 2008. 688 дах тал.

¹⁵⁵ Оросын эрдэмтэн Р.Д.Рахунов дээрхи дөрвөн чиг үүргээс гадна иргэний нэхэмжлэлийг хангах, иргэний нэхэмжлэлээс хамгаалах чиг үүргүүдийг оруулан ЭБША-ны зургаан чиг үүргийг тодорхойлсон байдаг. Эх сурвалж: Р.Д.Рахунов. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид. – Москва. 1991. 47-48 дах тал. (*орос хэл дээр*).

1. Хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналт;
2. Мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт;
3. Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт;
4. Шүүх хуралдаанд оролцож, төрийн нэрийн өмнөөс яллах нь прокурорын буюу прокурорын байгууллагын чиг үүрэг нь юм.

Харин мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүрэг нь дээрхи үндсэн чиг үүргийн салшгүй хэсэг бөгөөд мөн дараах өөрийн онцлог байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

а) байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсоох.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын нэг гол зорилго нь эрүүгийн хэргийг нотлоход чиглэсэн мөрдөн байцаалтын ажиллагаа Монгол Улсын ЭБШХ-ийн заалт, шаардлагын дагуу явагдаж байгаа эсэхийг хэргийн явцад шалгах, илэрсэн зөрчлийг засуулах, уг ажиллагаанд оролцогчдын эрхийг хангуулах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаа юм.

Хүн бүрийн Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон эрх мөрдөн байцаалтын ажиллагааны явцад зөрчигдөх, гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эрхийг илүүд тавьж бусад оролцогч болох сэжигтэн, яллагдагчийн эрхийг зөрчих, тэдний хүсэлт, шаардлагыг хангахаас цааргалах, аль болох хойш тавих нийтлэг зөрчил, дутагдал өнөөдөр ч хүртэл амь бөхтэй оршсоор л байна. Тухайлбал, үндэслэлгүйгээр буюу хангалттай нотлох баримтаар гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдоогүй байхад сэжигтнээр тооцож улмаар яллагдагчаар татах, үндэслэл, шаардлага бага байхад цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг урьтал болгох, цаашлаад удаан хугацаагаар уг таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх, тодорхой ажиллагаа хийлгүйгээр мөрдөн байцаалтын ажиллагааг сунгуулах, хугацаа алдах г.м. олон зөрчил дутагдлын улмаас хүний эрх зөрчигдөх цаашлаад хуулийн байгууллагад итгэх олны итгэл, найдвар алдагдахад хүрэх ихээхэн сөрөг үр дагавартай.

Энэ бүх зөрчил дутагдлыг гаргуулахгүй байх, мөрдөн байцаалтын ажиллагаанд хүний эрхийг хангах, хууль ёсыг сахиулахад прокурорын хяналт чиглэгдэх ёстой.

б) мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль ёсыг сахиулах, хууль ёс зөрчсөн үйлдлийг тогтоох, залруулах.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, хуулийн заалт шаардлагын дагуу байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулах, хэргийг тал бүрээс нь бодитойгоор судлан шинжилсэний үндсэн дээр зохих шийдвэрийг гаргахад чиглэсэн мөрдөн байцаагчаас нэлээд ур чадвар, мэдлэг шаардсан ажиллагаа юм. Хэрэв мөрдөн байцаалтын ажиллагааны явцад мөрдөн байцаагч ямар нэгэн алдаа тухайлбал, нотлох баримтыг цуглуулахад цаг хугацаа алдах, хуулийн дагуу бэхжүүлэх явцад хайнга хандах нь тухайн хэргийн талаархи нотлох баримт үгүй болох нөхцөл бүрдэж улмаар нотлох баримтын чанараа алдах, цаашлаад гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэх боломж алдагдаж, хохирогчийн гомдол хангагдахгүй үлдэх ноцтой хор уршигт хүргэдэг бөгөөд энэ талын жишээ баримт амьдрал, практик үйл ажиллагаанд олноор тохиолдож байсан.

Онц ноцтой гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хэргийн газрын үзлэгээс эхлээд мөрдөн байцаалтын бүхий л ажиллагааны явцад прокурор анхнаас нь хяналт тавьж оролцдог¹⁵⁶. Энэ нь *нэг талаас* мөрдөн байцаагчаас явуулж байгаа

¹⁵⁶ Монгол Улсын Ерөнхий прокурорын 2011 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 32 тоот тушаалаар батлагдсан “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажилд Эрүүгийн

мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурорын зүгээс хяналт тавьж байгаа хэрэг боловч, **нөгөө талаас** цаад утга агуулгаараа мөрдөн байцаалтын ажиллагааг хууль ёсны дагуу явуулах, мөрдөн байцаагчийг хууль зөрчих, алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх, алдаа, зөрчил гарсан тохиолдолд тухай бүрт нь засаж залруулах боломжийг олгож байгаа чиг үүрэг бүхий үйл ажиллагаа юм.

в) мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд гаргасан гомдол, мэдээллийг шалгах, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, шийдвэрлэх.

Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад мөрдөн байцаагч хууль зөрчсөн тухай болон түүний гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй, хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухайгаа байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бичгээр гомдол, санал гаргах явдал олонтаа байдаг.

Энэхүү гомдол саналыг тухайн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорт болон прокурорын байгууллагад гаргах бөгөөд прокурор нь уг гомдол саналыг хүлээн авч хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэн¹⁵⁷ гомдол гаргагчид хариу мэдэгдэх ёстой. Үүний тулд прокурор нь тухайн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан эсэх, гомдол, мэдээлэл үндэслэлтэй эсэх талаархи шалгалтыг явуулж гомдол гаргагчид хариу мэдэгдэх ба мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд хууль зөрчсөн байдал тогтоогдсон гэж үзвэл гарсан зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоож түүнийг засуулах талаар харъяа мөрдөн байцаах байгууллагад шаардлага бичиж хүргүүлдэг.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, саналыг хүлээн авч зохих шалгалтыг хийж байгаа энэхүү ажиллагаа мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтаар дамжин хэрэгжиж байгаа нь түүний чиг үүргийн нэг хэлбэрийг тодорхойлж байна.

2. Прокурорын хяналт ба мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих хяналт, тэдгээрийн онцлог

Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурорын хяналт тавих эрхээс гадна мөрдөн байцаах албаны дарга өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд өөрийн шууд удирдлагад байгаа мөрдөн байцаагчийн шалгаж буй эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хяналт тавьж гагцхүү түүнийхээ тусламжтайгаар тухайн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явц, байдлын талаар шаардлагатай бодит мэдээллийг олж авахаас гадна мөрдөн байцаалтын ажиллагаанд хууль ёсыг хангуулах мөн өөрийн удирдлагад байгаа мөрдөн байцаагчийн ажил гүйцэтгэх чадварт үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг өөртөө бий болгодог.

Мөрдөн байцаах албаны даргын эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг хангахад чиглэсэн эрх хэмжээний талаар эрдэмтэн судлаачид янз бүрийн байр сууринаас хандаж судлаж ирсэн бөгөөд **зарим нь** түүний хуулиар олгогдсон эрхийг хасаж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч байхаас болиулж мөрдөн байцаагчийн эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг бие дааж явуулах боломжийг олгох ёстой¹⁵⁸ гэсэн байр суурьтай байхад **нөгөө хэсэг нь**

байцаан шийтгэх хуулийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан заавар”-т зааснаар иргэд, байгууллагаас аливаа гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад гомдол, мэдээлэл ирж бүртгэлд авагдаж шалгалтын ажиллагаа эхэлсэн цаг үеэс прокурор хяналт тавих бөгөөд онц ноцтой хэргийн талаархи гомдол мэдээлэлд хэргийн газрын үзлэгээс эхлэн биечлэн хяналт тавьж оролцох ёстой.

¹⁵⁷ Монгол Улсын ЭБШХ-ийн 112 дугаар зүйлийн 112.2. дах хэсэгт зааснаар гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах буюу бусад арга хэмжээ авах бол ажлын 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

¹⁵⁸ А.М.Ларин. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчим ба хүний эрхийн баталгааг хандах тухай асуудал //Шүүхийн шинэчлэл: тайлан дүгнэлт, бодит байдал, хэтийн төлөв. Москва. 1990. 80 дахь тал, ОХУ-ын шүүхийн шинэчлэлийн үзэл баримтлал. Москва. 1992. 65-66 дах тал.

эсрэгээр харин ч түүний оролцоог нэмэгдүүлэх, эрх хэмжээг нь өргөжүүлэх нь зүйтэй¹⁵⁹ гэсэн байр суурьтай байдаг байна¹⁶⁰.

Бүгд Найрамдах Беларусь Улсын эрдэмтэн В.П.Ашитко өөрийн судалгааны ажлын бүтээлдээ мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх чиг үүрийг (*эрх хэмжээг*) “Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд хууль ёс зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг шалгаж тогтоох, илрүүлэхэд чиглэсэн ЭБШХ-ийн заалт, шаардлагад нийцсэн үйл ажиллагаа юм” гэж тодорхойлсон байна¹⁶¹.

Тэгвэл Оросын эрдэмтэн В.М.Савицкий өөрийн бүтээлдээ “Мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ мөрдөн байцаах ажлын удирдлагаар дамжин хэрэгждэг ба харин мөрдөн байцаалтын ажиллагааны явцад мөрдөн байцаах албаны даргын зүгээс тавих хяналт нь энэхүү удирдлагын үйл ажиллагааны нэг хэлбэр¹⁶²” гэж үзсэн байхад эрдэмтэн В.Я.Чеканов “Мөрдөн байцаах албаны даргын зүгээс хэрэгжүүлж байгаа байцаан шийтгэх ажиллагааны удирдлагын эрх хэмжээ, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тавих хяналт нь хоорондоо харилцан хамаарал бүхий үйл ажиллагааны арга юм¹⁶³” гэж тодорхойлсон байна.

Мөн Оросын эрдэмтэн А.А.Чувилев, В.В.Кальницкий нар энэхүү оролцогчийг байцаан шийтгэх ажиллагаанд бие даасан үйл ажиллагаа явуулдаг гэж үзэн түүний эрх хэмжээг:

- 1) мөрдөн байцаах албаны удирдлага;
- 2) мөрдөн байцаах албаны даргын зүгээс мөрдөн байцаалтынажиллагаанд хяналт тавих гэж зааглаж авч үзсэн байна¹⁶⁴.

Харин Монгол Улсын ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлд мөрдөн байцаах албаны даргын гэмт хэргийг шалгах үед эдлэх эрх хэмжээг¹⁶⁵ хуульчлан баталгаажуулж өгснөөс өөр энэ чиглэлийн тухайлбал, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ, түүний удирдлага, зохион байгуулалт, мөрдөн байцаах албаны даргын зүгээс мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих хяналт болон прокурорын хяналтын харилцан хамаарал, тэдгээрийн мөн чанар, нийтлэг ба онцлог байдлын талаар онолын үндэстэй авч үзсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил огт хийгдээгүй байна.

Хуульд зааснаар мөрдөн байцаах албаны дарга өөрт оногдсон эрх хэмжээний хүрээнд мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавина гэж шууд заагаагүй ч

¹⁵⁹ С.Б.Россинский. Мөрдөн байцаах албаны даргын эрхийг өргөжүүлэх тухай асуудал: Бүх Оросын эрдэм шинжилгээний хурлын материал. 2004.02.19-2004.02.20. Москва: ОХУ-ын ДХЯамны Москвагийн их сургууль. 2004. 203-208 дах тал, Л.Я.Тарасова. Мөрдөн байцаах албаны даргын эрх: өчигдөр ба өнөөдөр: Нийгэм төр, сэтгүүл. 2009. №4. 109-113 дах тал.

¹⁶⁰ Монгол Улсад Мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ, түүний хэрэгжилт, эрх зүйн зохицуулалтын талаар дагнан судалсан бүтээл хараахан байхгүй байна.

¹⁶¹ В.П.Ашитко. Мөрдөн байцаах газрын даргын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хяналтын чиг үүрэг. хууль зүйн докторын диссертацийн ажил. Москва. 1996. 37 дах тал.

¹⁶² В.М.Савицкий. Байцаан шийтгэх ажиллагааны явцад тавих прокурорын хяналтын онолын асуудал. Москва. 1989. 30 дах тал.

¹⁶³ В.Я.Чеканов. Цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах албаны бие даасан байдал ба түүний удирдлага. Саратов. 1990. 40 дэх тал.

¹⁶⁴ А.А.Чувилев, В.В.Кальницкий. Мөрдөн байцаах хэлтсийн даргын хяналт //Төр эрх зүй сэтгүүл. 1993. №4. 69-73 дах тал.

¹⁶⁵ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 29 дүгээр зүйлд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга гэмт хэргийг шалгахад ижил эрх хэмжээтэй эрх эдлэхээр тусгасан байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна. Учир нь бидний үзэж байгаагаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байгаа хэрэг бүртгэгчийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий хэрэг бүртгэх албаны дарга нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа мөрдөн байцаагчийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж, түүний гүйцэтгэлд хяналт тавьж байгаа мөрдөн байцаах албаны даргатай ижил тэнцүү эрх эдлэж байгааг өөрчлөн тус тусад нь эрх зүйн зохицуулалтыг хийх нь зүйтэй юм.

түүний дараах эрх хэмжээг мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хяналт тавих эрх хэмжээ гэж үзэж болохоор байна. Үүнд:

- хэргийн материалтай биечлэн танилцах;
- байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд оролцох;
- мөрдөн байцаагчид бичгээр үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах эрхийг багтаан авч үзэж болох юм.

Нэгэнт судалгааны ажлын хамрах хүрээнд мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээний тухай асуудал давхар хөндөгдсөн тул түүний хуулиар олгогдсон эрх хэмжээг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны зорилго, чиглэлээр нь зааглаж авч үзэх нь чухал гэж үзээд онолын хувьд:

1. мөрдөн байцаах албаны даргын эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг удирдан, зохион байгуулах эрх:

- мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.);
- гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийх (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.);
- мөрдөн байцаалт явуулах үүргийг нэг буюу хэд хэдэн мөрдөн байцаагчид даалгах (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.);
- хэргийг нэг мөрдөн байцаагчаас нөгөө мөрдөн байцаагчид шилжүүлэх (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.);
- шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалтын ажиллагааг биечлэн явуулж, мөрдөн байцаагчийн эрх эдлэх (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.);
- мөрдөн байцаалтын ажлын хэсэг байгуулах түүний бүрэлдхүүнийг өөрчлөх (ЭБШХ-ийн 183 дугаар зүйл);
- гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шалгах хугацааг 14 хүртэл хоногоор сунгах (ЭБШХ-ийн 171 дүгээр зүйлийн 171.2.).

2. мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих эрх:

- хэргийн материалтай биечлэн танилцах (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.);
- байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд оролцох (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.);
- мөрдөн байцаагчид бичгээр үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах (ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.)

гэж хоёр үндсэн хэсэгт ангилж авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Мэдээж мөрдөн байцаах албаны даргын мөрдөн байцаалтын ажиллагааг удирдан зохион байгуулах, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих эрх нь бие даасан эрх хэмжээнүүд боловч бие биенээсээ харилцан хамаарал бүхий нэг эрх нь нөгөө эрхээсээ хамааралтай эрх хэмжээнүүд байдаг. Тухайлбал, эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад мөрдөн байцаах албаны дарга хэргийн материалтай биечлэн танилцсаны дараа мөрдөн байцаалтын ажиллагааны шаардлагаар эрүүгийн хэргийг нэг мөрдөн байцаагчаас нөгөө мөрдөн байцаагчид шилжүүлж болно.

Энэ нь нэг талаар мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч нөгөө талаас мөрдөн байцаалтын ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хангаж байгаа хэрэг юм.

Тэгэхээр мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын мөн чанарыг тодорхойлон гаргахын тулд **“Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тавих хяналтаас ямар ялгаатай юм**

бэ? гэсэн асуулт зүйл ёсоор тавигдах ба энэ нь зөвхөн одоо яригдаж байгаа асуудал биш бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолын хүрээнд өнөөдөр ихээхэн маргаантай байсан хэвээр байна.

Мэдээж энэ хоёр субъектын хуулиар олгогдсон эрх хэмжээний эрх зүйн зохицуулалтад олон нийтлэг зүйлүүд байгаа хэдий ч зарчмын олон ялгаатай зүйл байгаа нь тодорхой. Үүнийг авч үзвэл:

1) Мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тавих хяналт, мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүрэг, ЭБША-г хэрэгжүүлэх явцад эзлэх байр суурь талаас нь авч үзвэл мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь эрүүгийн хэрэг бүрт хэрэгждэг, өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг бүрийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор хяналт тавьдаг бол мөрдөн байцаах албаны дарга **зөвхөн шаардлагатай гэж үзсэн** эрүүгийн хэргийн материалтай биечлэн танилцаж мөрдөн байцаагчид мэргэжлийн туслалцаа, заавар зөвлөгөө өгч тухайн хэрэгт цаашид хийж гүйцэтгэх ажиллагааны талаар чиглэл өгдөг¹⁶⁶. Иймд зарим эрүүгийн хэрэг мөрдөн байцаах албаны даргын хяналтгүйгээр шууд прокурорт шилжих явдал байдаг. Өөрөөр хэлбэл мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хяналт тавих эрх нь түүний сонголтоор хэрэгждэг бол мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь эрүүгийн хэрэг бүрт заавал хэрэгжих чиг үүрэг байдгаараа онцлог юм.

2) Объектын талаас нь авч үзвэл мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих хяналт нь зөвхөн өөрийн удирдлагад байгаа мөрдөн байцаагчийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагааг хангуулах, хуулийн заалт, шаардлагын дагуу шуурхай явуулахад чиглэгдэх бол мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын объект нь эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулж байгаа мөрдөн байцаагчийн аль нэгж, тасагт харьяалж байгаагаас үл хамаарч¹⁶⁷ мөрдөн байцаах байгууллага (албанаас)-ын бүх нэгж, тасгийн мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд хууль ёсыг сахиулах, мөрдөн байцаалтын ажиллагаа хуулийн заалт, шаардлагад нийцэн явагдаж байгаа эсэхэд хяналт тавина. Өөрөөр хэлбэл **мөрдөн байцаах албаны даргын зүгээс тавих хяналт нь** өөрийн удирдлагад байгаа мөрдөн байцаагч нарын шалгаж буй эрүүгийн хэргийг илрүүлэх, мөрдөн байцаалтын ажиллагаагаар хэргийг тал бүрээс нь нотлох үйл ажиллагааг **хангахад** чиглэгдэх бол **мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь** мөрдөн байцаагчийн аль нэгж, тасагт харьяалагдаж байгаагаас үл хамааран мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль ёсыг **сахиулахад** чиглэгдсэн нийтлэг хяналт байна.

3. Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт ба мөрдөн байцаах албаны даргын эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийн харьцаа, онцлог

Прокурор нь эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хяналт тавихаас гадна мөрдөн байцаалтын ажиллагааг удирдах чиг үүргийг мөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын ЭБШХ-ийн 193 дугаар зүйлд “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх”-ийг хуульчлан баталгаажуулж өгсөн ба үүний 193 дугаар зүйлийн 193.1.19. дэх хэсэгт

¹⁶⁶ Мөрдөн байцаах албаны дарга гол төлөв ээдрээ төвөгтэй, олны шуугиан, анхаарал татсан ноцтой гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хэргийн материалтай танилцан хяналт тавьж, тодорхой ажиллагаанд биечлэн оролцож, бичгээр үүрэг даалгавар өгч, мэргэжил, зохион байгуулалтын удирдлагаар хангаж ажилладаг.

¹⁶⁷ Тухайлбал Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор УМБГ-ын хэлтсүүдийн мөрдөн байцаагчдын мөрдөн байцаалт явуулан шалгаж байгаа эрүүгийн хэрэг хяналт тавьж ажиллах ба үүнд мөрдөн байцаагчийн хэлтсийн харьяалал хамаарахгүй.

хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны үед хууль зөрчсөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг тухайн хэргийг цаашид мөрдүүлэхийг зогсоох эрхтэй байхаар тусгасан. Мөн хуулийн 195 дугаар зүйлийн 195 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй, хуулийг ноцтойгоор зөрчсөн нь тогтоогдвол тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар хэргийг цаашид мөрдүүлэхийг зогсоож, өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид хэргийг шилжүүлэхийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад даалгах ба түүнийг заавал биелүүлнэ” гэж заасан байгаа нь **нэг талаас** мөрдөн байцаах албаны даргын эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг удирдлагаар хангах чиг үүрэгтэй давхцаж байгаа төдийгүй **нөгөө талаас** түүний өмнөөс удирдлагын үйл ажиллагааны эрхийг хэрэгжүүлж байна гэж үзэхээр байна.

Бидний үзэж байгаагаар прокурор зөвхөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хууль хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих чиг үүрэг бүхий оролцогч. Үүний тулд дээр дурьдсан эрх хэмжээг¹⁶⁸ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих прокурорын эрх хэмжээнээс хасаж түүнийг зөвхөн мөрдөн байцаах албаны даргын эрүүгийн хэргийг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах эрх хэмжээнд авч үзэх нь чухал юм.

Ингэснээр **нэг талаас** прокурорын хяналтын үр нөлөө дээшлэхээс гадна **нөгөө талаас** мөрдөн байцаах албаны даргын удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгийн оролцоо бага болж өөрийн эрх хэмжээг бодитоор, бусдаас үл хамааран хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэх төдийгүй мөрдөн байцаах ажиллагааны чанарт ч бодит үр дүн гарна гэж үзэж байна.

Судалгааны ажлын энэ бүлгийг нэгтгэн дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна.

1. Судлаачийн тодорхойлолт:

- Прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас явуулж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих түүнчлэн шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцох эрх бүхий албан тушаалтан.

- Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт гэдэг нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор прокурорт (*прокурорын байгууллагад*) олгогдсон тусгай эрх хэмжээний нэг төрөл бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогчдын хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсоох, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль ёсыг сахиулах, хууль ёс зөрчсөн үйлдлийг шалгаж тогтоох, түүнийг залруулах, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд гаргасан гомдол, мэдээллийг шалгах, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, шийдвэрлэх чиг үүрэг бүхий төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа.

2. Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүрэг:

а) байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсоох;

б) мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль ёсыг сахиулах, хууль ёс зөрчсөн үйлдлийг тогтоох, залруулах;

в) мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд гаргасан гомдол, мэдээллийг шалгах, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, шийдвэрлэх.

¹⁶⁸ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193 дугаар зүйлийн 193.1.19. дэх хэсэг, мөн хуулийн 195 дугаар зүйлийн 195.3 дах хэсэгт заасан эрх хэмжээ

3. Прокурор эрүүгийн хэрэг бүрийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьдаг бол мөрдөн байцаах албаны дарга зөвхөн шаардлагатай гэж үзсэн эрүүгийн хэргийн материалтай биечлэн танилцаж мөрдөн байцаагчид мэргэжлийн туслалцаа, заавар зөвөлгөө өгч тухайн хэрэгт цаашид хийж гүйцэтгэх ажиллагааны талаар чиглэл өгдөг.

4. Мөрдөн байцаах албаны даргын зүгээс эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хяналт тавих эрх нь түүний сонголтоор хэрэгждэг бол мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь эрүүгийн хэрэг бүрт заавал хэрэгжих чиг үүрэг.

5. Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль ёсыг сахиулахад чиглэгдэх бол мөрдөн байцаах албаны даргын зүгээс тавих хяналт нь эрүүгийн хэргийг илрүүлэх, мөрдөн байцаалтын ажиллагаагаар хэргийг тал бүрээс нь бодитойгоор нотлох үйл ажиллагааг хангахад чиглэгддэг байна.

6. Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд Монгол Улсын ЭБШХ-д энэ бүлэгт дурьдсан өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ҮДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ТҮҮНИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

ХСИС-ийн магистрант **Б.Бат-Учрал**

Удирдагч: ХСИС-ийн Удирдлагын сургуулийн Цагдаагийн
удирдлагын профессорын багийн профессор, хууль зүйн
доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Б.Одбаатар

Хүний эрх, эрх чөлөөг хангах ер нь хүний эрхийн тухай асуудал нь хүн төрөлхтөний олон зуун жилийн туршид байнга анхаарлын төвд байж гүн ухаан, шашин, улс төр, эрх зүй мөн түүнчлэн ёс зүйн чухал сэдэв байсаар иржээ.

Нийгмийн хөгжил дэвшлийн үе шат, нийгмийн анги, давхраа түүний доторхи хүчний харьцаа, хоорондын тэмцэл, түүх, соёлын хөгжлийн уламжлал зэрэг олон нөхцөл байдал, хүчин зүйлээс хамааран хүний эрхийн тухай асуудал нь янз бүрийн агуулга, хэлбэрээр илрэн гарч зарим үед түүний шашны агуулга нь түлхүү тодрон хөгжсөн байхад зарим үедээ гүн ухааны агуулга, хэлбэр илүү анхаарал татаж хөгжиж ирсэн байдаг байна.

Хүний эрх гэдэг нь олон талын өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд одоогийн бидний “хүний эрх” гэж ойлгож, судлаж, хөгжүүлж байгаа энэ судлагдахуун нь олон жилийн нөр их тэмцлийн үр дүнд бий болсон юм.

Хүний нийгмийн хөгжлийн түүхэн он жилүүдэд хүний эрх, эрх чөлөө түүнийг хангах тухай ярих нь бүү хэл хүнийг мөнгө ашиг олох, арилжих, худалдах, мөлжих зэргээр хамжлагат ёсыг эрхэмлэн дээдэлсэн бүхэл бүтэн нийгэм өөрийн хөгжлийн олон зуун жилийг дамжин ирсэн гашуун түүх ч бий.

Энэ бүхэн ч Монгол Улсыг тойрон гараагүйгээр барахгүй түүхэн хөгжлийн явцдаа гадны эзлэн түрэмгийлэгчдэд эрх чөлөө, тусгаар тогтнолоо алдаж бүхэл бүтэн хоёр зууны туршид зовж, шаналан түүнийгээ ямар их хүч, хөдөлмөрөөр эргүүлэн олж авсныг түүхээс бид мэднэ.

Тэгвэл 1990 оны ардчилсан хувьсгалаар Монгол Улсад далан жилийн туршид оршин тогтносон социалист нийгэм түүний үзэл баримтлал, үнэт зүйлийг үндсээр нь

өөрчлөн өнөөгийн бидний сонгож авсан чөлөөт ардчилсан нийгэм нь хүний эрхийг хамгийн гол үнэт зүйлээ гэж үздэг байна. Чөлөөт ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөний тухай асуудал нь эрх зүйн тэр дундаа олон улсын эрх зүйн судалгааны анхаарлын төвд байнга оршиж хөгжлийн өөрийн бодит чиг хандлага, байр сууриа хэдийнээ олж авсан байна.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд **хүний эрх, эрх чөлөө гэж юу вэ? Хүний эрх, эрх чөлөөг хангах гэж юу вэ?** гэсэн асуудлууд зайлшгүй урган гарч ирнэ.

“Хүний эрх” гэсэн ойлголтийг хэл бичгийн найруулга зүйн бүтцээс нь авч үзвэл “хүн”, “эрх” гэсэн хоёр үгний нийлбэрээс бүтэж байгааг харагдуулах авч энэ нь цаанаа маш гүн гүнзгий утга, агуулга, оюун санааны илэрхийлэл юм.

Хүн өөрөө байгаль, нийгмийн хөгжлийн бүтээгдхүүн бөгөөд хүнийг тойрсон онолын тайлбарууд нь нэг талаас байгаль-биологийн, нөгөө талаас нийгэм-соёл түүний харилцан хамаарал гэсэн хоёр үндсэн агуулгаар тайлбарлагдаж байна¹⁶⁹.

Тухайлбал: Эрх зүйн эх толь бичигт бие хүн (хүнийг)-ийг (*англи. personal; орос. личность*):

1) нийгмийн харилцааны идэвхитэй субъект, нийгмийн гишүүн болохыг харуулсан хүний эрхийн ухагдахуун; 2) ... бусадтайгаа харилцан, хамтран ажиллаж, амьдрах чадвар төлөвшсөн хүн¹⁷⁰ гэж тодорхойлжээ.

Энэ байдлаас дүгнэхэд хүний эрхийн тухай ойлголт, ухагдхуун нь байгаль, нийгмийн хөгжлийн мөн чанартай салшгүй холбоотой юм гэсэн дүгнэлтийг өгөхөд хүрч байна.

Хүний эрхийн тухай ойлголт нь бие хүний үнэ цэнийн тухай үзэл санааны илэрхийлэл юм. Хүний эрх нь түүний өөрийн төрөлхийн буюу байгалийн, заяагдмал шинж чанар тухайн хүний зан харьцаа, нийгмийн харилцаанд оролцож байгаа үйл ажиллагаагаар илрэн гарч байдаг. Тиймээс хүн өөрийн эрхээ хэрхэн ухамсарлаж зөв эдлэж, хэрэгжүүлж байна тэр хэмжээгээр түүний нэр хүнд, нийгмийн үнэ цэнэ өсч байдаг. Өөрөөр хэлбэл түүнд нийгмийн зүгээс буюу бусдаас өгөх үнэлэмж ямагт зөв, эерэг байдаг байна.

Хүний эрх, түүнийг хангах тухай асуудал нь олон орны эрдэмтэн, судлаачдын анхаарлын төвд цаг ямагт оршин байж энэ чиглэлээр бичигдсэн судалгаа шинжилгээний бүтээл, өгүүлэл, нийтлэл нэлээд олон төдийгүй судлаач бүр хүний эрх, эрх чөлөөний тухай асуудлыг өөр өөрийн байр сууринаас хандаж тайлбарласан байдаг ба үүний заримаас авч үзэж үнэлэлт дүгнэлт өгвөл:

Монголын нэртэй хуульч, эрдэмтдэд хүний эрхийн талаар томьёолон тодорхойлохдоо:

Хүний эрх гэдэг нь хүнээс эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын амьдралын бүх хүрээнд төртэй харилцах эрх зүйн байдлыг илэрхийлдэг ухагдахуун. Хүний эрхийг угаас заяасан, салгаж болдоггүй зүйл хэмээн үзэж “Хүний эрхийг чөлөөтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь иргэний нийгэм, эрх зүйт төрийн нэг үндсэн зарчим юм.

Хүний эрхийг туйлын, харьцангуй гэж ангилдаг. Туйлын эрх бол угаас заяасан тул ардчилсан улсад ямар ч нөхцөлд хязгаарлах, түр зогсоохыг зөвшөөрдөггүй. Туйлын эрхэнд амьд явах, хувийн халдашгүй эрхтэй байх, нэр төр, алдар хүнд, хувийн болон гэр бүлийн нууцыг хамгаалах, шашин шүтэх, эс шүтэх эрхүүд болон эрүү шүүлт, хүчирхийлэл болон хүний нэр гутаан доромжлохоос чөлөөтэй байх эрхүүд хамаардаг.

¹⁶⁹ Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ., 2002. 8-9 дэх тал, Х.Бат-Ялалт. Хүний эрхийн онол. УБ., 2004. 42 дах тал, В.А.Кондрашов. Философийн шинэ толь бичиг: нэмж засварласан 3 дахь хэвлэл. Москва, 2008. 668 дах тал (*орос хэл дээр*), Б.Я.Гаврилов. Хүний үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг шүүхийн өмнөх шатанд хангах зарим асуудал /хууль зүйн ухааны докторын диссертаци. Москва: 2003. 7 дах тал. (*орос хэл дээр*).

¹⁷⁰ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг: нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2008. 71 дэх тал.

Эдгээрээс бусдыг нь харьцангуй буюу хуулиар тогтоосон /позитив/ эрх гэдэг бөгөөд онц болон дайны байдалтай зэрэг онцгой нөхцөл байдал тохиолдсон үед хязгаарлах буюу тодорхой хугацаатай түр зогсоох журам тогтоож болдог¹⁷¹” гэж тодорхойлсон байна.

Харин академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх тайлбар толь бичигт”-т хүнийг эрхийг (*англи. human rights; орос. право человека*) – “**хүний төртэй харьцах, түүний эдийн засгийн, нийгэмшлийн, улс төрийн, соёлын хүрэн дэх боломж ба шаардлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон ухагдахуун**” гээд үүнд “тухайн улсын иргэн, гадаад улсын харъяат иргэн ба харьяалалгүй хүмүүсийг нийтэд нь багтаах бөгөөд орчин цагийн дэлхий ертөнцөд хүнийг эрхийг жам ёсны ба хүнээс салгашгүй хэмээсэн төсөөлөл голлодог¹⁷²” гэж тайлбарлаад хүний эрхийг эрх чөлөөтэй ба зохистой хэрэгжүүлэх нь иргэний нийгэм ба эрх зүйт төрийн нэг үндсэн шинж болох талаар тодорхойлсон байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын албан ёсны цахим танилцуулгад “Хүний эрх гэж юу” гэдгийг **хүн-эрх-хүнийэрх** гэсэн хэлхээ холбоогоор маш энгийнээр тайлбарласан байна. Үүнд:

Хүн – эрэгтэй, эмэгтэй хүн буюу хүүхэд, хувь хүн

Эрх – энэ бол танд заяагдсан буюу зөвшөөрөгдсөн боломж. Хууль зүйн утгаараа баталгаатай эрх чөлөө

Хүний эрх – Та зүгээр л хүн учраас танд байх ёстой бүх эрх¹⁷³ юм гэж тайлбарласан байгаа нь хамгийн энгийн, ойлгомжтой тайлбар юм.

Хүний эрхийн ойлголтын талаар мөн манай нэрт эрдэмтэд тухайлбал: Б.Чимид “Хүний эрх гэж юуны өмнө хүнд өөрт нь байдаг төрөлх шинж, мөн чанар буюу субъектив (эзэнлэг) эрх мөн¹⁷⁴”, Д.Лүндээжанцан “Хүн хүсэл зоригоо хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны боломжийн хүрээг хүний, эрх, эрх чөлөө гэнэ¹⁷⁵”, Ж.Амарсанаа “Хүний эрх нь хувь хүн, нийгэм, төр хоорондын харилцааны эрх зүйн хэм хэмжээний хэлбэр мөн¹⁷⁶” гэж тодорхойлсон байдаг.

Дээрхи тодорхойлолтууд нь хүний эрхийн талаархи нийтлэг ойлголт, тодорхойлолтуудын үндэс болж байна гэж дүгнэж болох бөгөөд товчоор хэлбэл: “**Хүний эрх нь нийгээр хүлээн зөвшөөрөгдсөн нийгэм, улс төр, соёлын хэрэгцээ шаардлагад нийцсэн, хүний өөрийнх нь төртэй харьцах эрх зүйн байдлын боломж, шаардлагыг тодорхойлсон ухагдахуун ба хүний эрхийг хангах нь чөлөөт ардчилсан нийгмийн үндсэн зарчмын нэг юм**” гэсэн дүгнэлтийг өгч болохоор байна.

Хүний эрхийг хамгийн энгийнээр **хүнд төрөлхөөс заяагдсан эрхүүд** хэмээн ойлгож болно. Хүн бүр яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрөлх болон бусад байдлаар ялгаваргүйгээр эрхээ эдлэх нь хүний эрхийн хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал юм.

Хүний эрх гэсэн ойлголтод байх хамгийн чухал шинж чанаруудыг авч үзвэл:

1) Хүний эрх – хүн бүрийн үнэ цэнэ, эрхэм чанарыг хүндэтгэх үүднээс бий болсон ойлголт;

2) Хүний эрх – бүх хүнд ялгаваргүйгээр, тэгш хүртэх түгээмэл шинжтэй;

¹⁷¹ Ж.Амарсанаа, Г.Баясгалан, Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал, Г.Уранцэцэг. Хууль зүйн тайлбар толь бичиг. УБ.: Митита принтинг хэвлэлийн газар. 2003. 398 дах тал.

¹⁷² С.Нарангэрэл. мөн тэнд. 539 дэх тал.

¹⁷³ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим танилцуулга /вэб сайт. Эх сурвалж, холбоос: <http://mn-nhrc.org/index.php?newsid=535>

¹⁷⁴ Б.Чимэд. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002. 88 дах тал

¹⁷⁵ Д.Лүндээжанцан. Шинэ толь сэтгүүл. 1998. №24. 6 дах тал

¹⁷⁶ Ж.Амарсанаа. Хүний эрх. УБ., 2000. 15 дах тал

3) Хүний эрх – онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд тухайн хүнээс булаан авч үл болох салшгүй шинжтэй юм. Тухайлбал: зөвхөн гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон үед хүний эрх чөлөөтэй байх эрхийг хязгаарлана;

4) Хүний зарим эрхийг орхигдуулан цогц бус байдлаар хүндэтгэх явдлыг хангалтгүй гэж үздэгээс хүний эрх – хуваагдашгүй, өөр хоорондоо харилцан хамааралтай, мөн харилцан уялдаатай гэж хүний эрхийн нийтлэг чанаруудыг тодорхойлсон байдаг¹⁷⁷.

Бодит амьдрал дээр хүний нэг эрхийг зөрчсөнөөс болж бусад хэд хэдэн эрх хөндөгдөх явдал олонтаа тохиолддог. Иймээс хүн бүрийн үнэ цэнэ, нандин чанарыг хүндэтгэхэд хүний бүх эрх ижил, тэгш ач холбогдолтой, адил тэнцүү байх шаардлагатай гэж үзэх ёстой.

Хүн нийгмийн амьдралын бүхий л хүрээнд тодорхой эрх эдэлж оролцдог нь тэдний бүтээн байгуулах асар их хүч чадал, авъяас билгийг илэрхийлдэг. Эдгээр эрх нь хүн, нийгэм, төр гурвын хоорондын олон талт харилцаатай зохицон уялдаж, мөн олон төрөл зүйл эрх болон хэрэгжих зүй тогтолтой байдаг. Энэхүү олон төрлийн эрхийг тодорхой бүлэгт хамааруулан хүний эрхийг ангилсан байна. Хүний эрх, эрх чөлөөг үүсэл гарал буюу мөн чанарын талаас нь дараах хоёр үндсэн ангилалд хувааж авч үздэг байна.

1.Хүний жам ёсны буюу заяамал эрх. (амьд явах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, халдашгүй чөлөөтэй байх, гэр бүл үр хүүхэдтэй байх г.м.). Өөрөөр хэлбэл хүн байгалийн бүтээгдхүүн учраас түүний төрөлхийн заяамал гэдгээс үүсэлтэй бичигдээгүй хуулиар зөвшөөрөгдсөн зан үйлийн боломж юм. Жам ёсны эрхийг төрөөс баталж тогтоож болдоггүй бөгөөд харин төр тэрхүү эрхийг нь эдлэх боломжийг хангах ёстой.

2. Хүний зүй ёсны буюу үүсмэл эрх. (сурч боловсрох, сонгох, сонгогдох, эвлэлдэн нэгдэх, бүтээл туурвих, эд мөнгөний туслалцаа авах, г.м.). Энэ эрх нь нийгмийн хэрэгцээнээс үүдэлтэй тул зайлшгүй хуульчлан зохицуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл түүний хүрээ, хязгаарыг төрөөс баталж тогтоосон байдаг¹⁷⁸.

Хүний эрхийн тухай ойлголт нь хүний эрх чөлөөний тухай ойлголттой салшгүй холбоотой бөгөөд тэдгээрийн харилцан хамаарал, мөн чанарын тухай авч үзэхгүй орхигдуулах нь судалгааны ажлын сул тал болох юм.

“Хүний эрх”-ийн тухай ойлголт нь “ эрх чөлөө” гэсэн ойлголттой нягт холбогдож өөрийн мөн чанараа тодорхойлон гаргана. Энэ нь “хүний эрх”-ийн тухай ойлголт нь “эрх чөлөө” гэсэн ойлголтгүйгээр мөн нөгөө талаар “эрх чөлөө” гэсэн ойлголт нь “хүний эрх” гэсэн ойлголтгүйгээр салангид байх боломжгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл эрх нь бие хүний нийгэм дэх эрх зүйн зохицуулалтын орчинтой зохицож түүний эрх чөлөөний хэм хэмжээ тодорхойлогдоно.

Тэгэхээр эрх чөлөө гэдэг нь харьцангуй ойлголт төдийгүй хязгааргүй эрх, эрх чөлөө өөрөөр хэлбэл бусдын эрх, эрх чөлөө, улс үндэстний эрх ашиг, аюулгүй байдлаас давсан хүний эрх, эрх чөлөө гэж бас байж болохгүй болохыг хүн төрөлхтөн хөгжлийнхээ явцад хүлээн зөвшөөрсөнтэй холбоотойгоор хүний эрхийн түгээмэл үзэл баримтлалыг нийтээр боловсруулан гаргаж түүнд нийцүүлэн өөрийн орны хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн гаргаж хүний эрх, эрх чөлөө, түүнийг хангах механизмыг боловсруулан гаргадаг байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч Б.Чимид мөн хүний эрх, эрх чөлөөний талаар тодорхойлохдоо:

¹⁷⁷ Хүний эрхийн Дээд комиссарын газар: Нэгдсэн үндэстний байгууллага. Хүний эрх: НҮБ-ын ажилтнуудад зориулсан гарын авлага. УБ., 2003. 3 дах тал.

¹⁷⁸ Б.Энхтуяа. Хүний эрх, эрх чөлөөний талаарх Олон улсын гэрээний үзэл санаа Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан нь. УБ., 7 дах тал

“Хүний эрх гэдэг нь төрөлхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг, нийгмийн дотор заавал эдлэх боломж мөн. Харин эрх чөлөө гэж хүний эдлэх ёстой бөгөөд хүнээс хаалт хэрэм босгон салгаж үл болох боломжийг хэлнэ¹⁷⁹” гэжээ. Үүнийг товчоор:

Хүний эрх – төрөлхөөс заяасан нийгэмд заавал эдлэх боломж

Эрх чөлөө – хүний эдлэх ёстой салгаж үл болох боломж гэж маш товч, тодорхой ойлгож болох юм.

Жон Стюарт Милль эрх чөлөөг тодорхойлохдоо: **“Эрх чөлөө гэдэг бол жинхэнэ утгаараа бид өөрсдийн үйл хэргээ өөрсдийн хүслээр гүйцэтгэхдээ бусдын үйл хэргийг үгүйсгэхгүй, түүнд нь саад тотгор учруулахгүй байх явдал мөн¹⁸⁰”** гэсэн байдаг. Энэ бол ардчилсан нийгэмд эрх чөлөөг ойлгох ойлголтыг хамгийн энгийн ойлгомжтойгоор тайлбарласан тодорхойлолт гэж дүгнэж болох юм.

Өөрөөр хэлбэл хувь хүний эрхээ хэрэгжүүлэх явцад илрэн гарсан үйлдэл болон нийгэмд биеэ авч яваа байдал, бусдыг хүндэтгэн харьцах харилцаа, түүний ухамсар, соёлын хэмжүүрт бусдаас өгч байгаа үнэлэмжийн тухай ойлголт энд агуулагдсан байна.

Эрх чөлөө гэдэг бол хүн бүр бусдын оролцоо, албадлага, шахалт, хавчилтгүйгээр өөрийн хүссэн зүйлээ сонгох боломж мөн. Гэхдээ энэ нь харьцангуй ойлголт бөгөөд хязгааргүй эрх чөлөө гэж бас үгүй юм.

Эрх чөлөө гэдэг бол хүн өөрийн эрхийн хүрээнд амьдрах, үйл ажиллагаа явуулахыг хэлэх бөгөөд бусдын эрх, эрх чөлөөнд саад учруулсан түүнээс давсан илүү эрх, эрх чөлөө байх учиргүй. Хэрэв хүн бүр өөрийн эрх, эрх чөлөөгөө эдлэж байна гээд санасан бүхнээ чөлөөтэй, хэнээс ч үл хамааран, өөрийн дур зоргоор эдэлбэл эрх чөлөөг буруугаар ойлгож “дураараа авирласан” үйлдэл болно. Мэдээж “эрх чөлөө”, “дур зорго” хоёр маш их ялгаа, заагтай өөрийн гэсэн хэмжүүртэй учир түүгээрээ мөн чанар нь тодорхойлогдож байдаг. Энэ нь төрөөс тогтоосон буюу зөвшөөрсөн хууль зүйн боломжит байдал бөгөөд дараах агуулгыг илэрхийлсэн байна. Үүнд:

- Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрхийг хөндөхгүй байх;
- Эрхээ эдлэхийн зэрэгцээ үүргээ хүлээсэн байх;
- Хүний жам ёсны эрхийг төрөөс хүлээн зөвшөөрсөн байхын дээр хүний зүй ёсны эрхийн хүрээг төрөөс тогтоож зохицуулсан байх;
- Хүн эрхээ эдлэх нөхцөл боломжийг хангах үүргийг төр өөртөө хүлэсэн байх;
- Хүний эрх, эрх чөлөө нь хүн хэрэгцээгээ зохистой, ухаалгаар хангах гол нөхцөл нь болсон байх;
- Хүний эрх, эрх чөлөөний зарчмуудыг Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон Үндсэн хуульд томъёолж тодорхойлсон байх¹⁸¹ зэрэг болно.

Хүний эрх, эрх чөлөөг ардчилсан, шударга нийгмийн нэг үнэт зүйл мөн гэдгийг одоо хүн бүр хүлээн зөвшөөрдөг болсон ч энэ нь нийгмийн хөгжил, дэвшлийн он цагийн урт удаан түүхийн туршид дандаа сайн сайхнаар төсөөлөгдөн уламжлагдаж ирсэн гэвэл түүн шиг ташаа ойлголт байхгүй юм.

¹⁷⁹ Б.Чимэд. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 94 дэх тал.

¹⁸⁰ Жон Стюарт Милль (1806-1873) нь 1806 оны 5 сарын 20-нд Английн Лондон хотод Ост-Инди компанид өндөр албан тушаал хашиж байсан шотланд гаралтай эдийн засаг, философичийн гэр бүлд төрсөн Английн эдийн засагт, философич, улс төрийн зүтгэлтэн, сонгодог улс төрийн эдийн засгийн онолын гол төлөөлөгч. Тэрээр өөрийн “Эрх чөлөөний тухай”, “Миний судалгааны ажлын төрөл” зэрэг философ, гүн ухааны алдарт бүтээлдээ хувь хүн, нийгмийн харилцааны талаар тодорхой тусган харуулсан байдаг.

Эх сурвалж, холбоос: http://c-bajun-v.narod.ru/libr1_bn/philosof/txt_1/dsmil fr.htm

¹⁸¹ Хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн зохицуулалтын талаар дараагийн бүлэгт авч үзэх болно.

Хүн төрөлхтний түүхийн дийлэнхи үед эрх, эрх чөлөөг зөвхөн ноёд, язгууртан, эрхэм дээдэс зэрэг тодорхой хүмүүс буюу хэсэг бүлэгт олгосон тусгай эрх дарх гэж ойлгож явсан цаг үе хийгээд одоо ч хүний эрх, эрх чөлөөний тухай ямар ч ойлголтгүй хүний наад захын эрх, амьдрах орчин нөхцөл нь хангагдаагүй улс, орон байсаар байгаа нь эрх, эрх чөлөө ямар их хүч, хөдөлмөр, тэмцлийн үр дүнд бий болдогыг харуулж байна.

Эрх чөлөө бол хүний бусад үнэт зүйлсийн үндэс болдог учраас хамгийн үнэ цэнэтэй зүйл юм. Эрх чөлөө хүнд өөрийн сонгосон амьдралаараа амьдрах боломж олгодог. Энэ нь мөн харьцангуй ойлголт бөгөөд магадгүй хүн бүр, нийгэм, ялангуяа, төр засаг ийм орчин нөхцлийг бүрдүүлэх боломжгүй юм гэж үзэж болох ч эрх чөлөөний тухай ойлголтын бас нэг утга, мөн чанар нь бусдын амьдрал, үйл хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байхыг шаарддагт оршин байна.

Хүний эрх, эрх чөлөөний талаархи дээрхи ойлголт, тодорхойлолтыг нэгтгэн дүгнэхэд хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт нь салангид байдлаар авч үзэх ойлголт биш харин бие биенээсээ харилцан хамаарал бүхий нягт холбоотой ухагдхуун болох нь харагдаж байна.

Хүний эрх, эрх чөлөөг зарлан тунхаглаад орхих бус харин дэлхийн улс орон **хүний эрх, эрх чөлөөг яаж хангаж байна вэ?** гэсэн асуудал зайлшгүй урган гарч ирнэ.

Хүний эрх нь хүний нандин чанар, үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах аливаа үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг хамгаалдаг хүний эрхийн хууль тогтоомжоор¹⁸² баталгаажин түүнийг хэрэгжүүлэх механизмаар дамжин хангагдаж байх ёстой. Өөрөөр хэлбэл хүний эрх, эрх чөлөөг улс орон бүхэн нийтээр зарлан тунхаглаад орхих бус түүнийг хангах, хэрэгжүүлэх механизмыг бий болгож түүний хэрэгжилтээр хүний эрхийн баталгаа хэрхэн хангагдаж байгааг үнэлэх, дүгнэх явдал бөгөөд тэр ч байтагүй энэ нь өнөөдөр аливаа улс орны хөгжлийн түвшин, олон улсын тавцанд эзлэх байр суурийг тодорхойлох шалгуур үзүүлэлт болтлоо хөгжиж байна.

Хэдийгээр хүний эрх нь хүний салшгүй, заяагдмал жам ёсны эрх ч гэлээ нийгмээрээ амьдрах болсон үеэс хүн, нийгэм, төр улс, хүмүүсийн хоорондын харилцаа, хамаарлыг илэрхийлэх болсон. Энэ нь хувь хүнд төр, нийгэмтэй харьцах эрх чөлөөг өгч, төр нь хувь хүн, иргэнийхээ эрхийг хангах, хамгаалах үүргийг хүлээх шаардлагыг бий болгож энэ нь улмаар **хэрэгжүүлэх механизмыг** бүрдүүлж байгаа өөр хоорондоо харилцан хамаарал бүхий орчинг бий болгож байна.

Тэгвэл механизм гэж юу вэ?

“Механизм” гэсэн үг анх “mechane” – “машин” гэсэн грек үгнээс үүсэлтэй бөгөөд С.И.Ожеговагийн тайлбар толь бичигт механизмыг:

1) машин, аппарат, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хангах дотоод бүтэц (системийн уялдаа холбоо); 2) ямар нэгэн төрлийн үйл ажиллагааны ажиллах горим, журмыг тодорхойлж буй системийн бүтэц; 3) ямар нэгэн үйл ажиллагаа, үйл явдлын төлөв, явц байдлыг тодорхойлж буй зүйл¹⁸³ гэжээ.

Үүнээс дүгнэхэд механизм гэдэг нь ямар нэг тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хангах нөхцөлүүдийг дэмжих уялдаа холбоог хангаж байгаа цогц шинж чанартай үйл ажиллагааны бүтэц (систем) байна. Товчоор дүгнэвэл:

“Ямар нэгэн үйл ажиллагаа нэг үйлдлээр бус хэд хэдэн үйлдлийн нэгэн зэрэг ажиллах нөхцлөөр дамжин хэрэгжиж зорилгоо ханган биелүүлнэ” гэсэн санаа юм.

¹⁸² Хүний төрөлх эрхийг албан ёсоор олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор тодорхойлдог. Хүний төрөлх эрхийн хууль зүйн хэлбэрийг 1945 онд анх хэлэлцсэнээс хойш хүний эрхийн Олон улсын Түгээмэл Тунхаглал, гэрээ, бусад эрх зүйн баримт бичгүүд цувран гарч баталгаажсан гэж үздэг.

¹⁸³ С.И.Ожегова. Орос хэлний тайлбар толь бичиг. Москва: Оникс хэвлэлийн газар. 2008. 328 дах тал. (орос хэл дээр).

Тэгвэл хүний эрхийг хангах механизмын хамгийн гол үндэс суурь нь тухайн улс орны хууль эрх зүйн орчин, түүнийг дагаад хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, түүний удирдлага гэсэн хүрээг хамруулан авч үзэх бөгөөд эрх зүйн орчин нь олон улсын гэрээ, конвенци түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүд болон эрх зүйн бусад эх сурвалжаар дамжин илэрхийлэгддэг.

Хүний эрхийн хууль тогтоомж нь улс оронд хүний эрхийг хангах талаар тодорхой алхмуудыг хийх үүрэг хүлээлгэгдгээс гадна тусгайлан заасан үйлдэл хийхийг мөн хориглодог байна.

Хэдий тийм боловч хууль тогтоомж нь хүний эрхийг тогтоодоггүй бөгөөд хүний эрх нь хүн бүрт, хүн болсныхоо хувьд угаас заяагдсан төрөлх чанар юм.

Эрх зүйн эх сурвалж нь ерөнхийдөө хувь хүн болон бүлэг хүмүүсийг эрхийг нийгэм, төрөөс хэрэгжүүлж байгаа хууль бус үйлдэл болон эс үйлдлээс албан ёсоор хамгаалахад зориулагдсан байдаг.

Орчин үеийн аливаа ардчилсан төр, нийгэм нь иргэнийхээ өмнө түүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашгийг хангах, хамгаалахын тулд нийгмийн дэг журам, орчин нөхцөл боломжийг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох үүргийг хүлээсэн механизмыг бүрдүүлсэн байх ёстой.

Хүний эрхийг хангах, хамгаалах механизм, түүнийг бүрдүүлэх тухай асуудал нь зөвхөн тухайн нэг улс орны хэмжээнд авч үзэх асуудал биш бөгөөд түүнийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны цар хүрээ, зорилго чиглэлээр нь:

1. Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм
2. Хүний эрхийг хамгаалах бүс нутгийн механизм
3. Хүний эрхийг хангах үндэсний механизм
4. Хүний эрхийг хамгаалах хэрэгсэл ба хяналтын механизм¹⁸⁴ гэж ангилан

авч үздэг байна.

Хүний эрхийг хангах, хамгаалах олон улсын эрх зүйн хэм хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход урт удаан хугацаанд уламжлагдаж ирсэн хоёр зарчим саад болж ирсэн байдаг. Үүнд:

Нэгдүгээрт: Аливаа улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглох.

Хоёрдугаарт: Улс орнуудыг зөвхөн олон улсын эрх зүйн субъект гэдгээр нь эрх зүйн эрх, үүргийг нь хүлээн зөвшөөрдөг байсан явдал.

Энэ нөхцөлд тухайн улс, орны төрийн зүгээс иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хязгаарлах, зөрчих явдлаас нь хамгаалах хамгаалалт байхгүй байв. Тухайлбал, дэлхийн нэг, хоёрдугаар дайны үед хүмүүс үй олноор үрэгдэж, тэр дундаа хэдэн сая еврейчүүдийг хомроглон устгаж, хүн төрөлхтөний түүхэнд аймшигт хэрцгий гэмт хэрэг үйлдэгдсэн байдаг.

Мөн үй олноор хомроглон устгах, хүчирхийлэх, боолчлох, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах гэх мэт олон зөрчлүүдийг таслан зогсооход олон улсын эрх зүй төвийг сахисан уламжлалт хандлагаасаа салах зайлшгүй нөхцөл бүрдэж улс, орны өөрийн үндэсний эрх зүйн тогтолцоо нь энх тайвныг сахин хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах хангалттай баталгаа болж чадахгүй байгаа нь нотлогдсон.

Түүхийн энэ мэт олон жишээ баримттай үйл явдлаас улбаалан улс орнууд бүгдээр нэгэн зэрэг хүний эрхийг хангах, хамгаалах явдал дээр санал нэгдэж **олон улсын механизмыг** бий болгосон байна.

Тэгвэл **Монгол Улс хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний механизмыг хэрхэн бүрдүүлж хангаж ажиллаж байна вэ?** гэдэг нь бас л анхаарал татсан асуудлын нэг юм.

¹⁸⁴ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын албан ёсны цахим танилцуулга. Эх сурвалж, холбоос: <http://humanrights.mn>

Монгол Улс 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталж түүнийхээ оршил хэсэгт нийгмийнхээ зорилтыг “Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”¹⁸⁵ хэмээн тунхагласан нь чөлөөт ардчилсан нийгмийн тулгуур зарчимд бүрэн нийцсэн хүний эрх, эрх чөлөөг хангах бүхий л орчин нөхцөлийг бүрдүүлсэн нийгмийг эх орондоо бүтээн байгуулна гэдгээ дэлхий нийтэд зарлан тунхаглаж байгаа Монгол Улсын хөгжлийн чиг баримжаа, үзэл баримтлал юм.

Түүнчлэн олон улсын хүний эрхийг хангах, хамгаалах механизмд бүрэн нийцүүлсэн, дэлхий нийтээр хүний эрхийг хангах, хамгаалахаар хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд тулгуурласан, түүнчлэн өөрийн орны нийгэм, үндэсний онцлог байдлыг тусгаж Олон Улсын Хүний эрхийн Билл¹⁸⁶-д нийцүүлсэн “Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”¹⁸⁷-ийг боловсруулан гаргасан нь Монгол Улсын Үндсэн Хуульд заасан төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээж хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж байгаа хэрэг бөгөөд Үндэсний хөтөлбөрийг Засгийн газар 2003 оноос дөрөв, дөрвөн жилээр тодотгосон төлөвлөгөөтэйгээр эрхлэн хэрэгжүүлж ирсэн байна.

Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах зохистой механизмыг бүрдүүлсэн, эрхийг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн хэрэгжүүлэхэд засаг, төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн, иргэний нийгэм, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгөн, үр нөлөөг нь сайжруулах, иргэдийн санаачлагыг өрнүүлэх чиглэл, арга замыг тодорхойлсон олон асуудлыг цогцоор нь авч үзсэн чухал баримт бичиг болсон гэж дүгнэж үзэж болохоор байна.

Үндэсний хөтөлбөрт зааснаар Монгол Улсын Хүний эрхийг хангах үндэсний механизм нь:

- 1) хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага;
- 2) Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд;
- 3) нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- 4) бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа;

¹⁸⁵ Монгол Улсын Үндсэн хууль. [1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр УИХ-аас баталсан]: Эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>

¹⁸⁶ Хүний эрхийн Билл гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэгч механизмыг тогтоосон олон улсын хүний эрхийн 4 үндсэн баримт бичиг юм. Үүнд: 1.Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал. (1948.12.10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр баталсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэг бүхий баримт бичиг). 2.Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пакт. (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966.12.16-ны өдөр баталж, 1976.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон олон улсын хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлсон гэрээ). 3.Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын I дэх нэмэлт протокол. (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966.12.16-ны өдөр баталж, 1976.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээ). 4.Эдийн засаг, нийгэм, соёлын Олон улсын Пакт. (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1996.12.16-ны өдөр баталж, 1976.01.03-ны өдөр хүчин төгөлдөр болсон олон улсын хамтын ажиллагаанд үндэс болгох зарчмыг тодорхойлсон гэрээ).

¹⁸⁷ Монгол Улсын Их хурлын 2003.10.24-ны 41-р тогтоол. Хүний эрхийн үндэсний хөтөлбөр батлах тухай. Эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

5) хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах дотоодын хэрэглүүрүүд гэсэн бүрдэл хэсгээс бүрдэж эдгээр бүрдэл хэсгийн чадавхи, хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Шүүх эрх мэдлийн байгууллага, Хүний эрхийн Үндэсний комисс, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд гэсэн шат дараалсан хэлбэрээр тодорхойлон хүний эрхийг хангах, хамгаалах механизмыг бүрдүүлж өгсөн нь чухал байна.

Хэдийгээр хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн хийгээд хүнийг эрх, эрх чөлөөг хангах механизм тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоо тодорхой байгаа ч өнөөдөр хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх явдал байсаар байгаа нь хүний эрхийг хангах механизм түүний харилцан ажиллагаа хангалтгүй байгаа явдалтай холбоотой гэж бид үзэж байна.

Үүний тулд яах ёстой вэ гэсэн? гэсэн асуудал мөн л тавигдах ба үүнд хариулт олохын тулд судалгааны ажлын үр дүнд тулгуурлан дараах арга хэмжээнүүдийг зайлшгүй авч хэрэгжүүлэх ёстой гэж товч дүгнэж байна.

1. Хүний эрхийг хангах үндэсний механизмын оролцогч талуудын эрх үүргийг нэмэгдүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог нь сайжруулах;

2. Орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүний эрхийг хангах” тухай бүлэг, хэсгийг бий болгож үйл ажиллагааны үнэлж болохуйц төлөвлөлтүүдийг бий болгож үр дүнг нь тооцож байх;

3. Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг тусгайлан улсын төсөвт жил бүр суулгаж, зарцуулалтыг бодит хийсэн ажлаар нь үнэлж, дүгнэж байх;

4. Хууль эрх зүйн шинэчлэлийг шуурхай явуулж хүний эрх, эрх чөлөөг хангах механизмын уялдаа холбоог хангасан эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;

5. Орон нутагт хүний эрхийг хангах чиглэлээр ажиллах хүний тоог нэмэгдүүлэх, тэр дундаа иргэд сумандаа хууль зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлэх;

6. Мөн хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн эрх зүйн баримт бичгүүдийг судлуулах, олон улсын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн саналыг дэвшүүлж байна.

Ингэснээр хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах механизм улам боловсронгуй болж бүх шатанд хүний эрх хангагдах орчин бүх талаасаа бүрдэж үйл ажиллагааны тодорхой ахиц дэвшлүүд гарна гэж дүгнэж байна.

УНШИГЧ ТАНЫ МЭДЛЭГИЙН САНД

Уншигч та бүхэнд сэтгүүлийнхээ “Уншигч таны мэдлэгийн санд” булангаар “Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуул”-ийг энэ удаагийн дугаарт нийтлэж байна.

Цаашид хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан хууль тогтоомжуудыг цувралаар хүргэхээр бэлтгээд байна.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчим

3.1.Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална:

3.1.1.хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3.1.2.нууцлалыг хамгаалах;

3.1.3.шуурхай байх;

3.1.4.хамтран ажиллах.

3.2.Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

3.3.Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."гэрч, хохирогч" гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан гэрч, хохирогчийг;

4.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг;

4.1.3."эрх бүхий албан тушаалтан" гэж энэ хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтныг /шүүгч, прокурор, мөрдөгч, Тахарын албаны алба хаагч/.

5 дугаар зүйл.Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

5.1.Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч хамаарна.

5.2.Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.

5.3.Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.

5.4.Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ТУСЛАЛЦАА 6 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээний төрөл

6.1.Хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

6.1.1.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;

6.1.2.сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

7 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

7.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

7.1.1.урьдчилан сануулах;

7.1.2.тодорхой үйлдлийг хязгаарлах;

7.1.3.биечилсэн хамгаалалт;

7.1.4.мэдээллийн нууцлалыг хангах;

7.1.5.нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;

7.1.6.аюулгүй газарт түр байрлуулах;

7.1.7.нүүлгэн шилжүүлэх;

7.1.8.баримт бичгийг солих;

7.1.9.гадаад төрхийг өөрчлөх.

7.2.Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

8 дугаар зүйл.Урьдчилан сануулах

8.1.Гэрч, хохирогчийг алах, бие махбодид гэмтэл учруулах, тарчлаах, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөнгө, эд зүйл амлах болон бусад гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн нь тогтоогдвол тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар шүүгч, прокурор, мөрдөгч, Тахарын албаны алба хаагч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

9 дүгээр зүйл.Тодорхой үйлдлийг хязгаарлах

9.1.Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

9.2.Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан эрх бүхий албан тушаалтан хязгаарлах арга хэмжээ авахуулсан этгээдээр гарын үсэг зуруулж, түүнд хяналт тавина.

10 дугаар зүйл.Биечилсэн хамгаалалт

10.1.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.

11 дүгээр зүйл.Мэдээллийн нууцлалыг хангах

11.1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд халхавч нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

11.2.Эрх бүхий албан тушаалтан иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.

11.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой онцгой тохиолдолд, эсхүл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн талаарх мэдээлэл авах хүсэлтээ Үндсэн хуулийн цэц болон шүүх эрх бүхий байгууллагад бичгээр гаргана.

12 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай

техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах

12.1.Гэрч, хохирогчийг Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

12.2.Тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах

13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

14 дүгээр зүйл.Нүүлгэн шилжүүлэх

14.1.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ.

14.2.Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

15 дугаар зүйл.Баримт бичгийг солих

15.1.Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино.

15.2.Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна:

15.2.1.иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг;

15.2.2.эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг;

15.2.3.хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ;

15.2.4.шаардлагатай бусад баримт бичиг.

15.3.Гэрч, хохирогч овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх тохиолдолд урьд өмнө гүйцэтгээгүй байгаа үүргийнхээ талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй ба ийнхүү мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаврыг Засгийн газар хариуцахгүй.

16 дугаар зүйл.Гадаад төрхийг өөрчлөх

16.1.Гэрч, хохирогчийнаюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно.

16.2.Гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх /үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх гэх мэт/ хамгаалалтын арга хэмжээ авч болно.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг насанд хүрээгүй гэрч, хохирогчид хэрэглэхгүй.

16.4.Энэ хуулийн 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бол тухайн гэрч, хохирогчийн гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх лавлагааг холбогдох байгууллагаас авна.

17 дугаар зүйл.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

17.1.Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

17.2.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:

17.2.1.гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;

17.2.2.гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.3.шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.4.шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;

17.2.5.шаардлагатай бусад арга хэмжээ.

17.3.Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

18.1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно:

18.1.1.хууль зүйн туслалцаа;

18.1.2.сэтгэл зүйн туслалцаа;

18.1.3.эрүүл мэндийн туслалцаа.

18.2.Гэрч, хохирогчид энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.

18.3.Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.4.Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан нэгж тус тус хариуцан хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

19 дүгээр зүйл.Хамгаалуулах эрх үүсэх

19.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.

20 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх, цуцлах үндэслэл

20.1.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал байна.

20.2.Аюулгүй байдлын хамгаалалтыг дараах үндэслэлээр цуцална:

20.2.1.хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн бичгээр гаргасан хүсэлт;

20.2.2.аюулгүй байдлын хамгаалалт хэрэглэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэр.

20.3.Энэ хуулийн 20.2.2-т заасан албан тушаалтан дараах үндэслэлээр аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана:

20.3.1.гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нөхцөл байдал арилсан;

20.3.2.хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн.

21 дүгээр зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх журам

21.1.Эрх бүхий албан тушаалтан гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана.

21.2.Дараах албан тушаалтан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана:

21.2.1.энэ хуулийн 16.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, эсхүл түүний өмгөөлөгчийн хүсэлтээр Тахарын албаны алба хаагч;

21.2.2.энэ хуулийн 7.1.2-7.1.6-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурор, шүүхийн шатанд шүүгч;

21.2.3.энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг прокурор, мөрдөн шалгах болон тагнуулын байгууллагын гаргасан саналыг үндэслэн шүүгч.

21.3.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан арга хэмжээ нь аюулгүй байдлын онцгой арга хэмжээ бөгөөд эдгээрийг Мөрдөх албаны харьяалах хэргийн гэрч, хохирогчид тэдний аюулгүй байдлыг хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэн хамгаалж чадахгүй нөхцөлд хэрэглэнэ.

21.4.Энэ хуулийн 7.1.6-7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх явцад тухайн хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг өмнө ажиллаж байсантай ижил хэмжээний цалин хөлс бүхий ажлын байраар хангана. Хэрэв ийм боломжгүй бол өмнө авч байсан дундаж цалин хөлстэй нь тэнцэх нөхөн олговрыг хамгаалалтад байх хугацаанд олгоно.

21.5.Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.6.Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний талаар мэдсэн иргэн, албан тушаалтан бусдад энэхүү мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

21.7.Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажиллагаа дууссаны дараа үргэлжлүүлж болно.

22 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахад харгалзан үзэх нөхцөл

22.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахдаа эрх бүхий албан тушаалтан дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

22.1.1.гэрч, хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;

22.1.2.хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;

22.1.3.гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;

22.1.4.нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин;

22.1.5.хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;

22.1.6.хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;

22.1.7.бусад нөхцөл.

22.2.Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг нь шаардлагатай тохиолдолд хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор энэ хуулийн 22.1.6-д заасан сэтгэл зүйн сорилыг авч, хамгаалалтын хэлбэрийг сонгох зөвлөмж гаргана.

23 дугаар зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг

23.1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ:

- 23.1.1. цагдаагийн алба;
- 23.1.2. мөрдөх алба;
- 23.1.3. Тахарын алба;
- 23.1.4. Авлигатай тэмцэх газар;
- 23.1.5. Тагнуулын ерөнхий газар.

23.2. Тахарын алба нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай нэгжтэй байна.

23.3. Тахарын алба нь гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

23.3.1. гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай авах;

23.3.2. гэрч, хохирогчийг мэдээллээр хангах;

23.3.3. нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих, мэс заслын аргаар гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

23.3.4. шинээр ажилд ороход туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах;

23.3.5. хууль зүйн туслалцаа болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх;

23.3.6. шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын хэлбэрийг өөрчлөх тухай саналаа холбогдох албан тушаалтанд гаргах;

23.3.7. энэ хуулийн 5.3-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах, энэ хуульд заасан туслалцаа үзүүлэх;

23.3.8. хамгаалалтын үйл ажиллагааны нууцлалыг хангах;

23.3.9. шаардлагатай бусад.

23.4. Тахарын албаны хамгаалалтын тусгай нэгжийн дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана.

23.5. Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн харьяалах асуудлын хүрээнд хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл. Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах

24.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуулийн 21.2-т заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана.

24.2. Шүүх гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

25 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг

25.1. Засгийн газар гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

25.1.1. гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;

25.1.2. гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгах.

25.2. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

25.2.1.гэрч, хохирогчийг хамгаалах талаар гадаад улстай хэлэлцээр хийх, гэрээ байгуулах;

25.2.2.энэ хуулийн 25.1.1-д заасан хөтөлбөрийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлыг уялдуулан зохицуулах.

25.3.Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хамгаалалтад байгаа болон хамгаалалтад байсан гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор Тахарын албыг дараах мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй:

25.3.1.яллагдагчид авсан, өөрчилсөн таслан сэргийлэх арга хэмжээний талаар;

25.3.2.өршөөсөн, уучилсан шийдвэрийн талаар;

25.3.3.сулласан, хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон талаар;

25.3.4.ялтан хорих байгууллагаас түр болон бүрмөсөн чөлөөлөгдсөн талаар.

25.4.Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, мөрдүүлнэ.

25.5.Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Тахарын алба болон эрх бүхий бусад байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

25.6.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан болон уг шийдвэрийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтан хохирогч, гэрчийн хувийн байдлын тухай мэдээллийг задруулахыг хориглоно.

26 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох

26.1.Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно.

27 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

28.1.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД